

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-91 НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮРЭМ

**ИНД-91-д 2010.04.16–ны өдрөөс хойш хийгдсэн нэмэлт, өөрчлөлтүүд:**

***Нэмэлт, өөрчлөлт- 6 /ЗТБХБ-ын Сайдын 2011.04.22-ны 123-р тушаал/***

1/ 91.101 /Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар/-ийг өөрчлөн найруулсан;  
2/ “Б” Бүлэгд 91.139 /Байгаль, цаг агаарын аюултай үзэгдэл болон газрын ба навигацийн тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагааны талаар мэдээлэх/-р зүйл нэмсэн;  
3/ “А” Бүлэгд 91.255 /RNP агаарын зайд нислэг үйлдэх/-р зүйл нэмсэн;  
4/ 91.413-ын (в)-гийн 3.1-3.8 áîëî (д)-гийн 1.1, 1.2, (е)-гийн 1/; 91.415-ын (в)-гийн 1/, 2/; 91.417-гийн (а)-гийн 1.1-д цэгтэй таслал /;/-ын дараа “эсхүл” гэж нэмсэн;

***Нэмэлт, өөрчлөлт- 7 /ЗТБХБ-ын Сайдын 2011.10.14-ний 278-р тушаал/***

1/ 91.425 /ХНД-ийн үнэмлэхүй өндөр болон өндрийн цуваачлал/-ын (а) хэсгийг өөрчилсөн  
2/ 91.239-ийн (а), (б)-д “760 м.у.б (1013.25 гПа)” гэснийг “1013.25 гПа (760мм.муб)”, 91.313-ын ийн (а), (г)-д “760 м.у.б” гэснийг “760мм.муб” гэж өөрчилсөн.

***Нэмэлт, өөрчлөлт- 8 /Зам тээврийн Сайдын 2013.01.11-ний 02-р тушаал/***

Е бүлэгт, 91.501 /Ерөнхий зүйл/-ийн (а)-гийн 2/-ын “нислэгт тэнцэх чадварын стандартыг” гэснийг “загварын нислэгт тэнцэх чадварын стандартыг” гэж, (а)-гийн 2.2-т “О бүлэг” гэснийг “Хавсралт В” гэж тус тус өөрчилсөн

***Нэмэлт, өөрчлөлт- 9 /Зам тээврийн Сайдын 2014.09.14-ний өдрийн 212-р тушаал/***

1/. 91.403-ын (а)-гийн 3/ дахь заалтыг “онгоц болон нисдэг тэрэг бэлтгэл аэродромоос дээш 600 м (2000ft)-ийн өндөрт хүлээх бүсэд 30 минут нисэх” гэж өөрчилсөн.

2/. 91.509 (а)-гийн 15/ дахь заалтыг дараах байдлаар өөрчилсөн:

15/ хэрэв агаарын хөлгийн бүхээг нь хөдөлгүүрээс гарах хийн халаагуур, эсхүл дотоод шаталтын халаагч ашигладаг бол бүхээг дэх нүүрсхүчлийн хэт ислийн хэмжээг заагч.

3/. 91.509 (б)-г дараах байдлаар өөрчилсөн:

(б) Монгол Улсын бүртгэлд бүртгэгдэж, Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгогдсон дараах агаарын хөлгүүдийг, нислэгийн цагийг бүртгэж хадгалах автомат төхөөрөмжөөр тоногдсон байна:

1/ ИНД-137-гийн дагуу хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа нисдэг тэрэг;

2/ ИНД-135-ын дагуу ашиглагдаж байгаа нисдэг тэрэг;

3/ тусгай ангиллын туршилтын Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй, эсхүл сонирхогчийн бүтээсэн тусгай ангиллын Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэйгээс бусад, аливаа зориулалтаар ашиглагдаж буй нисдэг тэрэг;

4/ ИНД-137-гийн дагуу хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа онгоц.

4/. Хавсралт А15 /Ослын байршил дамжуулагч /ELT/-ын (б)-гийн 1.4-ийг “ELT нь агаарын хөлгийн 3 тэнхлэгийн дагуу нэмэх болон хасах чиглэлд 100 г ачааллыг даах чадвартай байна”.

5/. 91.251-ийн (а)-д “91.507-гийн (б)-д заасны дагуу” гэснийг “91.509-ийн (б)-д заасны дагуу” гэж өөрчилсөн.

<b>А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....</b>	<b>7</b>
91.1. Зорилго.....	7
91.3. Тодорхойлолт.....	7
91.5. Нисэх багийн тушаал, зааврыг дагаж мөрдөх.....	8
91.7. Зөөврийн цахим хэрэгсэл ажиллуулахыг хориглох.....	8

91.9. Агаарын хөлгөөр галт зэвсэг тээвэрлэх, хэрэглэх .....	8
91.13. Согтууруулах ундаа, мансууруулах бодис, тамхийг хориглох .....	10
91.15 Агаарын хөлгийг түлшээр цэнэглэх .....	10
<b>Б БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА .....</b>	<b>10</b>
91.101. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар .....	10
91.103. НТЧ-ын хязгаарлагдмал ангиллын гэрчилгээ, үйл ажиллагааны хязгаарлалтууд .....	11
91.105. НТЧ-ын тусгай ангиллын гэрчилгээ, үйл ажиллагааны хязгаарлалтууд .....	11
91.107. Агаарын хөлгийн бүртгэл .....	11
91.109. Агаарын хөлгийн нислэгийн заавар .....	12
91.111. Агаарын хөлөгт авч явах бичиг баримт .....	12
91.112 Нислэгийн өдөр тутмын тэмдэглэл .....	12
91.113. Нисэх багийн гишүүдийн тоо .....	13
91.115. Агаарын хөлгийн үйлчлэгчид тавигдах шаардлага .....	13
91.117. Агаарын хөлгийн даргыг томилох .....	13
91.119. Агаарын хөлгөөр явгалалт үйлдэх .....	13
91.121. Зорчигчдын үйлчилгээнд зориулсан тоног төхөөрөмжийг хурааж бэхлэх ..	14
91.123. Нислэгийн сургалтад ашиглах агаарын хөлөгт тавигдах шаардлага .....	14
91.125 Хэрэглэлийн дууриамал нислэг .....	14
91.127. Аэродром ашиглах .....	14
91.129. Хязгаарлалттай болон аюултай бүсэд нислэг үйлдэх .....	15
91.133. Цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд нислэг үйлдэх .....	15
91.135 Мэдээлэл дамжуулах .....	16
91.137. Галт уулын бүсэд нислэг үйлдэх .....	16
91.139. Байгаль, цаг агаарын аюултай үзэгдэл болон газрын ба навигацгийн тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагааны талаар мэдээлэх .....	16
<b>В БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЕРӨНХИЙ ДҮРЭМ .....</b>	<b>176</b>
91.201. Агаарын хөлгийн даргын үүрэг .....	176
91.203. Агаарын хөлгийн даргын эрх .....	176
91.205. Багийн гишүүдийн ажлын байр .....	177
91.207. Хамгаалах бүс хэрэглэх .....	187
91.209. Хүчилтөрөгчийн тоноглол ашиглах .....	188
91.211. Зорчигчдод өгөх мэдээлэл .....	198
91.213. Гар тээшийг байрлуулах .....	209
91.215. Ачаа тээвэрлэх .....	209
91.217. Нислэгийн өмнөх мэдээлэл .....	209
91.219. Үйл ажиллагааны хязгаарлалт, аврах тоног төхөөрөмжтэй танилцах .....	20
91.221. Нислэгийн тоног төхөөрөмж ба мэдээлэл .....	20
91.223. Аэродром дээр болон түүний ойролцоо нислэг үйлдэх .....	20
91.225. Нислэгийн хөдөлгөөний удирдлагатай аэродромд нислэг үйлдэх .....	22
91.227. Өөр агаарын хөлгийн ойролцоо нислэг үйлдэх .....	232
91.229. Нислэгийн хөдөлгөөний давуу эрхийн дүрэм .....	232
91.231. Нислэгийн төлөвлөгөө .....	243
91.233. Агаарын хөлгийн гэрэл .....	254
91.235. Агаарын хөлгөөс эд зүйл унагах ба цацах .....	254
91.237. Агаарын хөлгийн хурдны хязгаарлалт .....	254
91.239. Өндөр хэмжигчийг тохируулах .....	254
91.241. НХУ-аас өгсөн зөвшөөрөл, зааврыг биелүүлэх .....	265

91.243. НХУ-аас өгөх гэрлэн дохио.....	265
91.245. Хяналттай агаарын зайд нислэг үйлдэх.....	266
91.247. Автомат хариулагч, өндрийг мэдээлэх төхөөрөмж ашиглах.....	276
91.249. Агаарын хөлгийн дуудлага.....	287
91.251 Автомат бичлэг хийх төхөөрөмжийн ажиллагаа.....	287
91.253. Агаараас талбай сонгож буух.....	288
91.255. RNPагаарын зайд нислэг үйлдэх.....	28
<b>Г БҮЛЭГ. ИЛ ХАРААНЫ НИСЛЭГИЙН ДҮРЭМ.....</b>	<b>30</b>
91.301. Ил харааны нислэгийн цаг агаарын хязгаарлалт.....	30
91.303. Нөөц.....	31
91.305. Ил харааны нислэгт шаардлагатай шатахуун.....	31
91.307. Нөөц.....	31
91.309. Байрлал илтгэх.....	31
91.311. Ил харааны нислэгийн аюулгүй өндөр.....	32
91.313. Ил харааны нислэгийн үнэмлэхүй өндөр ба өндрийн цуваачлал.....	32
91.315. Цас, мөстэй үед тавигдах шаардлага.....	33
<b>Д БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛИЙН НИСЛЭГИЙН ДҮРЭМ.....</b>	<b>343</b>
91.401. Нисэх багийн гишүүдийн тоо.....	343
91.403. Хэрэглэлийн нислэгийн үед шаардлагатай шатахуун.....	343
91.405. ХНД-ээр үйлдэх нислэгийн нөөц, аэродромд тавигдах шаардлага.....	344
91.407. Нөөц.....	355
91.409. Нислэгийн төлөвлөгөөг дагаж мөрдөх.....	355
91.411. Нислэгийн төлөвлөгөө өөрчлөгдөх.....	365
91.413. ХНД-ээр хөөрөх, буух.....	365
91.415. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх журам.....	377
91.417. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх заавар.....	388
91.419. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх зааврыг батлах.....	398
91.421. Мөстөлттэй үед нислэг үйлдэх.....	399
91.423. ХНД-д мөрдөх аюулгүй нам өндөр.....	409
91.425. ХНД-ийн үнэмлэхүй өндөр болон өндрийн цуваачлал.....	40
91.427. ХНД-ийн үед радио холбоо барих.....	41
91.429. ХНД-ийн үед радио холбоо алдагдах.....	41
91.431. Төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг мэдэгдэх.....	42
91.433 Нислэгийн чиглэл.....	42
<b>Е БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА</b>	<b>432</b>
91.501. Ерөнхий зүйл.....	432
91.503. Хэрэглэл, тоног төхөөрөмжийн байрлал.....	433
91.505. Суудал, хамгаалах бүс.....	433
91.507. Зорчигчдод мэдээлэх тэмдэглэгээ.....	443
91.509. Зайлшгүй шаардлагатай хэрэглэл ба тоног төхөөрөмж.....	443
91.511 Нөөц.....	454
91.513 ИХНД-д шаардлагатай холбооны төхөөрөмж.....	454
91.515 Нөөц.....	454
91.517 ХНД-д шаардлагатай хэрэглэл, төхөөрөмж.....	454
91.519 ХНД-ийн үед шаардлагатай холбоо, навигацийн төхөөрөмж.....	455

91.521. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт үйлдэхэд шаардлагатай төхөөрөмж .....	466
91.523. Ослын үед хэрэглэх төхөөрөмж .....	477
91.525. Усан дээгүүрх нислэг .....	488
91.527 Нөөц .....	499
91.529. Ослын байршил дамжуулагч /ELT/.....	499
91.531. Хүчилтөрөгчийг заах хэрэгсэл .....	509
91.533. Битүүмжлэлгүй агаарын хөлгийн хүчилтөрөгч .....	50
91.535. Битүүмжлэл бүхий агаарын хөлгийн хүчилтөрөгч .....	50
91.537. Ажиллагаагүй хэрэгсэл ба тоног төхөөрөмж.....	51
91.539. MEL-ийг батлах .....	52
91.541. Автомат хариулагч ба өндөр мэдээлэх төхөөрөмж .....	533
91.543. Тийрэлтэт хөдөлгүүрт агаарын хөлгийн нислэгийн өндөр дохиологч систем ба төхөөрөмж .....	533
91.545. Тогтоосон өндрийг заагч.....	544
91.547 Газар ойртолтыг анхааруулах систем.....	544
<b>Ж БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА .....</b>	<b>554</b>
91.601. Үйлчлэх хүрээ.....	554
91.602 Нислэгийн өмнөх техник үйлчилгээний шаардлага .....	554
91.603. Техник үйлчилгээний ерөнхий шаардлагууд .....	555
91.605. Техник үйлчилгээний хөтөлбөр ба төлөвлөгөө .....	565
91.607. Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах .....	587
91.609. Техник үйлчилгээний хөтөлбөр ба хуваарьт өөрчлөлт оруулах.....	588
91.611. Үзлэг төлөвлөх .....	598
91.613. Шалгах нислэг .....	598
91.615. Жил тутмын НТЧ-ын үзлэг .....	599
91.616. Техник үйлчилгээний дэвтэр.....	609
91.617. Техник үйлчилгээний тэмдэглэл хийх .....	609
91.619. Техникийн бүртгэл .....	60
91.621. Техник үйлчилгээний бичиг баримтыг шилжүүлэх .....	60
91.623. Бичиг баримтыг хадгалах .....	61
<b>З БҮЛЭГ. ТУСГАЙ НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....</b>	<b>61</b>
91.701. Уран жолоодлогын нислэг .....	61
91.703. Үзүүлэх нислэг .....	62
91.705. Шүхэр буулгах нислэг .....	632
91.707. Нөөц шүхэр .....	643
91.709. Планер чирэх .....	643
91.711. Планераас бусад зүйлийг чирэх .....	654
<b>И БҮЛЭГ. ГАДААДАД БҮРТГЭЛТЭЙ АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙН ГАДНА НИСЛЭГ ҮЙЛДЭЖ БУЙ, МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....</b>	<b>654</b>
91.751. Үйлчлэх хүрээ.....	655
91.753. Монгол Улсын агаарын зайн гадна нислэг үйлдэж буй Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа.....	655
91.755. Гадаадын агаарын хөлгийн үйл ажиллагааны тусгай дүрмүүд .....	655

<b>К БҮЛЭГ. ДУУ ЧИМЭЭНИЙ ХЯЗГААРЛАЛТ .....</b>	<b>665</b>
91.801. Зорилго .....	665
91.803. Агаарын хөлгийн дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээ .....	666
91.805. Агаарын хөлгийн дууны хурдны долгион .....	666
91.807. Хөдөлгүүрээс гарах хорт утааны зөвшөөрөгдөх хэмжээ .....	666
<b>ХАВСРАЛТ А. ХЭРЭГЛЭЛ БА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШААРДЛАГА .....</b>	<b>676</b>
A1. Тэмдэглэгээ ба зурагт хуудас .....	676
A2. Шатахуун ба тосны тэмдэглэгээ .....	677
A3. Суудал .....	67
A4. Хамгаалах бүс .....	677
A5. Хүүхдийн тусгай суудал .....	677
A6. Агаарын хөлгийн гэрлүүд .....	687
A7. Агаарын хөлгийн нислэгийн цагийг мэдээлэх төхөөрөмж .....	687
A8. Өндөр хэмжигч .....	688
A9. Холбоо навигацгийн төхөөрөмж .....	698
A10. RNP, MNPS, RVSM төхөөрөмж .....	69
A11. CAT II, CAT III-т шаардагдах төхөөрөмж .....	69
A12. Эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл .....	70
A13. Гал унтраагч .....	70
A14. Аврах тоног төхөөрөмж .....	70
A15. Ослын байршил дамжуулагч /ELT/ .....	71
A16. Хүчилтөрөгч .....	722
A17. Зорчигчийн хүчилтөрөгчийн баг .....	722
A18. Нисэх багийн гишүүдийн хүчилтөрөгчийн баг .....	722
A19. Нөөц .....	732
A20. Амьсгал хамгаалах төхөөрөмж /PBE/ .....	732
A21. Багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж .....	733
A22. Автомат хариулагч төхөөрөмж .....	733
A23. Өндрийн мэдээллийг кодлох тоноглол .....	733
A24. Өндрийн дохиоллын систем .....	733
A25. Аваарын үед хэрэглэх шүхэр .....	733
A26. Планер чирэх холбоос .....	733

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын  
2010 оны 04 дүгээр сарын 16–ны өдрийн  
112 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

## ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-91 НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ДҮРЭМ

### А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### 91.1. Зорилго

(а) Энэ дүрмийн зорилго нь иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх ерөнхий үйл ажиллагаа болон энэ зүйлийн (б)-д заасан улсын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

(б) Энэ дүрмийн дараах заалтууд улсын агаарын хөлгийн нислэгт хамаарна:

- 1/ 91.129;
- 2/ 91.223; 91.225 иргэний агаарын хөлгийн ойролцоо нислэг үйлдэж байвал,
- 3/ 91.229 иргэний агаарын хөлгийн ойролцоо нислэг үйлдэж байвал,
- 4/ 91.233;
- 5/ 91.241;
- 6/ 91.245, 91.247;
- 7/ 91.309;
- 8/ 91.313;
- 9/ 91.407-с 91.411;
- 10/ 91.425, 91.427;
- 11/ 91.431;
- 12/ 91.541.

(в) Энэ дүрмээр дараах нислэгийн үйл ажиллагааг зохицуулахгүй:

- 1/ онцгой нөхцөл байдлын үед иргэний хамгаалалтын зорилгоор үйлдэх аливаа нислэг;
- 2/ ИНД-73-ын дагуу тогтоосон аюултай, хязгаарлалтай болон цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд үйлдэх улсын агаарын хөлгийн аливаа нислэг;
- 3/ ИНД-101-ийн дагуу үйлдэх нислэг;
- 4/ ИНД-105-д хамаарах үйл ажиллагаа.

(г) Энэ дүрмийн дараах зүйлүүд нь улсын агаарын хөлгийн дадлагын нислэг (в) 1/, 2/-ийн заалтад хамаарч байвал зохицуулахгүй:

- 1/ 91.225 (б);
- 2/ 91.233;
- 3/ 91.313 хяналттай агаарын зайн гадна бол;
- 4/ 91.407 хяналттай агаарын зайн гадна бол;
- 5/ 91.427 хяналттай агаарын зайн гадна бол.

#### 91.3. Тодорхойлолт

*Агаарын хөлгийг ашиглагч (operator)*- гэж агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэгч этгээд ба аж ахуйн нэгж;

*Нислэгийн зааварчилгаа*- гэж агаарын хөлгөөр нислэгийн үндсэн ба хүндрүүлсэн хэлбэрийн жолоодлого, онгоцноос нисдэг тэргэнд, нисдэг тэрэгнээс онгоцонд шилжих сургалтын нислэгийн зааварчилгааг тус тус хэлнэ.

#### **91.5. Нисэх багийн тушаал, зааврыг дагаж мөрдөх**

(а) Зорчигчид нь 91.203-т заасан эрхийн хүрээнд агаарын хөлгийн даргаас өгсөн тушаал, зааврыг дагаж мөрдөх үүрэгтэй.

#### **91.7. Зөөврийн цахим хэрэгсэл ажиллуулахыг хориглох**

(а) Аливаа этгээдийг агаарын хөлөг ашиглагч болон агаарын хөлгийн дарга нь нислэгийг ХНД-ээр үйлдэж буй агаарын хөлөгт зөөврийн гар утас болон бусад цахилгаан соронзон долгионы нөлөө үзүүлэх зөөврийн цахим хэрэгсэл ажиллуулахыг хориглоно.

(б) Аливаа этгээдийг энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд агаарын хөлөг ашиглагч болон агаарын хөлгийн дарга нь ХНД-ээр үйлдэж буй агаарын хөлгийн хөөрөлт, буулт болон нислэгийн онцгой тохиолдлын үед зөөврийн цахим хэрэгсэл ажиллуулахыг хориглоно.

(в) Энэ зүйлийн (б)-д дараах хэрэгслүүд хамаарахгүй:

- 1/ сонсголын аппарат;
- 2/ зүрхний ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төхөөрөмж;
- 3/ зөөврийн дуу бичигч;
- 4/ сахлын цахилгаан машин;
- 5/ электрон бугуйн цаг; болон
- 6/ агаарын хөлгийг ашиглагч нь агаарын хөлгийн холбоо, навигацийн системд нөлөөлөхгүй болохыг тодорхойлсон зөөврийн бусад цахилгаан хэрэгсэл.

#### **91.9. Агаарын хөлгөөр галт зэвсэг тээвэрлэх, хэрэглэх**

(а) Энэ зүйлийн (в) болон (д)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь:

- 1/ агаарын хөлгөөр галт зэвсэг тээвэрлэхийг; эсхүл
- 2/ агаарын хөлөгт тээвэрлэж буй галт зэвсгийг хэрэглэхийг хориглоно.

(б) Энэ зүйлийн (г)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд нь агаарын хөлөгт галт зэвсгийг хэрэглэхгүй.

(в) Дараах тохиолдолд галт зэвсэг тээвэрлэнэ. Үүнд:

- 1/ галт зэвсэг нь:
  - 1.1 нислэгийн үед аливаа этгээд хүрэх боломжгүй байрлуулсан;
  - 1.2 хэрэглэх боломжгүй; эсхүл
- 2/ агаарын хөлөг нь тухайн галт зэвсэг эзэмших эрх бүхий этгээдийн тусгай зориулалтын нислэгт дараах тохиолдолд тээвэрлэхийг зөвшөөрнө:
  - 2.1 агаарын тээвэрлэгч нь галт зэвсэг тээвэрлэхийг зөвшөөрсөн;
  - 2.2 галт зэвсэг нь хэрэглэх боломжгүй; эсхүл



- 3/ амьтныг агаарын хөлгөөр зөөвөрлөхөд агаарын тээвэрлэгч нь аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзсэн; эсхүл
- 4/ агаарын хөлгөөс газарт байгаа ан амьтныг мэдээ алдуулах зорилгоор буудаж хэрэглэх тохиолдолд дараах байдлаар ашиглана:
  - 4.1 галт зэвсэг нь агаарт ашиглахаас өмнө цэнэглэгдээгүй байна;
  - 4.2 агаарын хөлөгт зөвхөн тухайн газарт байгаа ан амьтныг мэдээ алдуулах зорилгоор буудахад оролцох эрх бүхий этгээдийг тээвэрлэнэ.

(г) Галт зэвсгийг хэрэглэх:

- 1/ хэрэв нисэх баг амьд амьтан тээвэрлэхэд агаарын хөлөг болон зорчигчдын аюулгүй байдлыг харгалзан шаардлагатай гэж үзвэл мэдээ алдуулах зорилгоор агаарын хөлөгт хэрэглэж болно.
- 2/ дараах тохиолдолд агаарын хөлгөөс газарт байгаа зэрлэг амьтныг мэдээ алдуулахаар буудахыг хориглоно:
  - 2.1 галт зэвсгийг хэрэглэхэд газарт байгаа бусад амьд амьтан, хүн, эд хөрөнгөнд аюул учруулна гэж үзвэл;
  - 2.2 хот, тосгон, хүн оршин суугаа газарт.

(д) Галт зэвсгийг агаарын хөлөгт батлан хамгаалах, онцгой байдал, цагдаа, хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд дараах тохиолдолд тээвэрлэнэ:

- 1/ агаарын хөлгийг тусгай болон онцгой үүргийн зориулалтаар хөлсөлж авсан бол галт зэвсэг тээвэрлэх этгээд нь:
  - 1.1 хуулиар галт зэвсэг эзэмших эрхтэй;
  - 1.2 гүйцэтгэх үүрэгт нь галт зэвсэгтэй байхыг шаардсан;
  - 1.3 агаарын хөлөгт галт зэвсэг тээвэрлэхийг (е) зүйлд заасны дагуу зөвшөөрсөн;
  - 1.4 ИНЕГ нь энэ зүйлийн (е)-д заасан тусгай нөхцөл хязгаарлалтыг хүлээн зөвшөөрсөн байна.
- 2/ галт зэвсгийг тусгай болон онцгой үүрэг гүйцэтгэх агаарын хөлөгт батлан хамгаалах, онцгой байдал, цагдаа, хуулийн байгууллагын ажилтнууд нь цэнэглээгүй байх;
- 3/ тухайн агаарын хөлгөөр зорчих батлан хамгаалах, онцгой байдал, цагдаа, хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд нь үүргийн дагуу агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх.

(е) Цагдаа, Онцгой байдлын газар болон хууль хэрэгжүүлэх байгууллагын удирдлагын хүсэлтийг үндэслэн ИНЕГ нь:

- 1/ галт зэвсгийг агаарын хөлөгт батлан хамгаалах, онцгой байдал, цагдаа, хууль хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд тусгай болон онцгой үүргийн нислэгт шаардлагатай гэж үзсэн бол зөвшөөрч болно;
- 2/ зохих нөхцөл хязгаарлалтын хүрээнд байна;
- 3/ уг байгууллагын шийдвэрийг үйл ажиллагаа эрхлэгчид мэдээлнэ.

(ж) ИНЕГ зөвшөөрснөөс бусад тохиолдолд (е) заалтын дагуу хүсэлт гаргагч этгээд нь ИНЕГ-т тусгай болон онцгой үүргийн нислэгээр агаарын хөлгийг хөлсөлж нисэхээр төлөвлөсөн өдрөөс нэг хоногийн өмнө гаргана.

(з) Энэ зүйлийн (д) 1/ дэх заалтын хүрээнд галт зэвсэг тээвэрлэх этгээдийн тоо болон агаарын хөлөгт байрлах байршлын тухай агаарын хөлгийн ашиглагч нь агаарын хөлгийн даргад мэдээлнэ.

**91.11. Агаарын хөлөг болон түүний тоног төхөөрөмжийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох**

(а) Аливаа этгээдийг агаарын хөлгийн аливаа эд анги, тоноглол, утааны мэдрэгч, үйл ажиллагаанд ашиглаж буй суурин болон зөөврийн төхөөрөмж, навигацийн тоног төхөөрөмжийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

**91.13. Согтууруулах ундаа, мансууруулах бодис, тамхийг хориглох**

(а) Дараах тохиолдолд агаарын хөлгийн нисэх багийн гишүүнээр үүрэг гүйцэтгэж нислэгийн үйл ажиллагаанд оролцохыг хориглоно:

- 1/ согтууруулах ундаа хэрэглэснээс хойш 12 цагийн хугацаанд;
- 2/ хүний мэдрэмж, чадварт нөлөөлөх мансууруулах үйлчилгээтэй аливаа бодис хэрэглэсэн үед;
- 3/ цусан дахь согтууруулах бодисын хэмжээ 0,04% буюу түүнээс дээш бол;

(б) Эрх бүхий этгээд шаардсан тохиолдолд нисэх багийн гишүүн нь согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ тодорхойлуулах зорилгоор шалгуулна.

(в) Аливаа этгээдийг агаарын хөлгийн бүхээгт болон түүний ойролцоо тамхи татахыг хориглоно.

(г) Аливаа этгээдийг агаарын хөлгийн бүхээгт зөвшөөрснөөс бусад тохиолдолд согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно.

**91.15 Агаарын хөлгийг түлшээр цэнэглэх**

(а) Аливаа этгээд агаарын хөлгийг түлшээр цэнэглэхдээ:

- 1/ зорчигч агаарын хөлөгт байх, суух, буух ба аль нэг хөдөлгүүр ажиллаж байх үед агаарын хөлгийг 3.1А ангиллын түлшээр цэнэглэх ба юүлэхийг хориглоно;
- 2/ зорчигч агаарын хөлөгт байх, суух, буух үед агаарын хөлгийг 3.1С ба 3.1D ангилалын түлшээр цэнэглэх ба юүлэхийг хориглоно.

**Б БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА**

**91.101. Агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар**

(а) Энэ зүйлийн (в) болон ИНД-103, ИНД-106-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд иү хүчин төгөлдөр НТЧ-ын гэрчилгээгүй, нислэгт тэнцэх чадваргүй, эсхүл ИНД-21-ийн дагуу тусгай нислэгийн зөвшөөрөл олгогдоогүй агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

(б) Агаарын хөлгийн дарга иү MEL-д зөвшөөрөгдөөгүй дутагдалтай агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно.

(в) Аливаа этгээд нь дараах шаардлагыг хангасан бол хүчин төгөлдөр  $\text{Í}\times\text{-}\text{û}$  гэрчилгээгүй агаарын хөлгөөр, гэрчилгээ олгох, сунгах зорилгоор нислэг үйлдэж болно:

- 1/ агаарын хөлөг нь ИНД-21-ийн “Б” Бүлгийн дагуу олгогдсон Маягийн гэрчилгээ ба Маягийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээтэй;
- 2/ ИНД- 21.191-ийн шаардлагыг хангасан;
- 3/ ИНД-43.101-ийн (а)-д заасан шаардлагыг хангасан этгээд тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэнэ гэдгийг баталгаажуулсан;
- 4/ агаарын хөлгийн дарга нь ИНД-61-ийн дагуу олгогдсон хүчин төгөлдөр үнэмлэх болон тухайн агаарын хөлгийн маягийн зэрэглэлтэй;
- 5/ нислэгийн үйл ажиллагаанд оролцох зайлшгүй шаардлагатай этгээдээс бусад этгээдийг тээвэрлээгүй бол.

**91.103. НТЧ-ын хязгаарлагдмал ангиллын гэрчилгээ, үйл ажиллагааны хязгаарлалтууд**

(а) Агаарын хөлөгт НТЧ-ын хязгаарлагдмал ангиллын гэрчилгээ ИНД-21-ийн Е Бүлгийн дагуу олгогдсон бол нислэгийн зааварчилгаа өгөхийг дор зааснаас бусад тохиолдолд аливаа этгээдэд зөвшөөрөхгүй:

- 1/ маягийн зэрэглэлийг шилжүүлэх нислэгийн зааварчилгаа; эсхүл
- 2/ хөдөө аж ахуйн зэрэглэл олгох нислэгийн зааварчилгаа; эсхүл
- 3/ агаарын хөлөгт олгогдсон гэрчилгээний дагуу тусгай нислэгийн үйл ажиллагааны нислэгийн зааварчилгаа.

**91.105. НТЧ-ын тусгай ангиллын гэрчилгээ, үйл ажиллагааны хязгаарлалтууд**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд НТЧ-ын тусгай ангиллын гэрчилгээтэй агаарын хөлгийг зорчигч болон ачаа тээвэрлэж нислэгийн үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

(б) Агаарын хөлөгт нислэгийн үйл ажиллагаа хамтран гүйцэтгэж буй доорх шаардлагыг хангасан этгээдэд энэ зүйлийн (а) хэсэг хамаарахгүй:

- 1/ ИНД-61-ийн дагуу багшлах эрхийн зэрэглэл эзэмшсэн; эсхүл
- 2/ шилжин сургалтын зааварчилгаа авч байгаа этгээд.

(в) ИНЕГ-аас тусгайлан зөвшөөрөөгүй бол хөөрөлт, буулт үйлдэхээс бусад тохиолдолд хот, суурин буюу хүн ам шигүү суурьшсан нутаг дэвсгэрийн дээгүүр НТЧ-ын тусгай ангиллын гэрчилгээтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно.

(г) НТЧ-ын тусгай ангиллын гэрчилгээтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй этгээд уг агаарын хөлгийн онцлогийн талаар хөлгийн бүхээгт байгаа бүх этгээдэд мэдэгдэнэ.

**91.107. Агаарын хөлгийн бүртгэл**

(а) Энэ зүйлийн (б) болон ИНД-106-д зааснаас бусад тохиолдолд, аливаа этгээд дараах дүрэм, эсхүл зөвшөөрлийн дагуу улсын бүртгэлд бүртгэгдээгүй агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно:

- 1/ ИНД-47; эсхүл
- 2/ Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч улсаас олгосон зөвшөөрөл; эсхүл
- 3/ агаарын хөлгийн бүртгэлийг харилцан хүлээн зөвшөөрөх талаар бусад улстай байгуулсан гэрээний дагуу гадаад улсаас олгосон бүртгэл.

(б) Энэ зүйлийн (а) нь ИНД-148-ын дагуу гэрчилгээжсэн үйлдвэрлэгчийн агаарын хөлөгт дараах тохиолдолд хамаарахгүй:

- 1/ ИНД-21-ийн дагуу НТЧ-ын нислэгийн тусгай зөвшөөрөл авсан;
- 2/ шинэ бүтээгдэхүүн шалгаж байгаа.

#### **91.109. Агаарын хөлгийн нислэгийн заавар**

(а) Агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглах аливаа этгээд нь нислэг үйлдэх тухайн агаарын хөлгийн нислэгийн зааварт тусгагдсан хязгаарлалтуудыг дагаж мөрдөнө.

(б) Агаарын хөлгийн нислэгийн зааварт орох өөрчлөлтийг тухай бүрт нь хийсэн байна.

#### **91.111. Агаарын хөлөгт авч явах бичиг баримт**

(а) ИНД-103, ИНД-104 болон ИНД-106 -ийн дагуу гэрчилгээжсэнээс бусад төрлийн агаарын хөлгийн бүхээгт дараах бичиг баримт авч яваагүй тохиолдолд тухайн агаарын хөлгийг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахыг аливаа этгээдэд хориглоно:

- 1/ агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ;
- 2/ агаарын хөлөгт ИНД-91.101 (в)-д зааснаас бусад тохиолдолд НТЧ-ын хүчинтэй гэрчилгээ, эсхүл түүний хуулбар;
- 3/ агаарын хөлгийн нислэгийн заавар;
- 4/ Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээтэй агаарын хөлөгт;
  - 4.1 ИНД-91.619-д шаардсан агаарын хөлгийн техникийн бүртгэл;
  - 4.2 жин ба төвлөрөлтийн өгөгдөхүүн;
  - 4.3 агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээ;
  - 4.4 агаарын хөлгийн дуу чимээний хувьд ИНД-91.803 (а) 2/-ийн шаардлагад нийцэж буй болон хөдөлгүүрээс гарах хорт утааны зөвшөөрөгдөх хэмжээний хувьд ИНД-91.807-ын (а)-ын 2/-ын шаардлагад нийцэж буй гэсэн гэрчилгээ.

#### **91.112 Нислэгийн өдөр тутмын тэмдэглэл**

(а) Агаарын хөлгийг ашиглагч нь энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд өдөр тутмын нислэгтэй холбогдолтой дараах мэдээллийг хадгална:

- 1/ агаарын хөлгийн бүртгэлийн дугаар, ашиглагчийн нэр;
- 2/ нислэгийн огноо;
- 3/ нисэх багийн гишүүдийн нэрс;
- 4/ нисэн гарсан аэродром;
- 5/ нисэн ирсэн аэродром;
- 6/ нислэгийн цаг;
- 7/ нислэгийн зорилго;
- 8/ нислэгийн үед гарсан зөрчил;
- 9/ хариуцагч этгээдийн гарын үсэг.

(б) Агаарын хөлөг ашиглагч нь өдөр тутмын нислэгийн тэмдэглэлийг тухайн нислэг үйлдэгдсэн өдрөөс хойш 6 сарын хугацаанд хадгална.

**91.113. Нисэх багийн гишүүдийн тоо**

(а) Агаарын хөлгийн нислэгийн зааварт тогтоосноос цөөн тооны нисэх багийн бүрэлдэхүүнтэйгээр нислэг үйлдэхийг хориглоно.

**91.115. Агаарын хөлгийн үйлчлэгчид тавигдах шаардлага**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, 19-өөс дээш тооны зорчигч тээвэрлэх агаарын хөлгийн нисэх багийн гишүүнд дараах тооны агаарын хөлгийн үйлчлэгчийг томилно:

- 1/ 20-50 зорчигч тээвэрлэж буй агаарын хөлөгт 1-ээс доошгүй;
- 2/ 51-100 зорчигч тээвэрлэж буй агаарын хөлөгт 2-оос доошгүй;
- 3/ 101-ээс дээш тооны зорчигч тээвэрлэж буй агаарын хөлөгт 2-оос доошгүй, мөн 50 зорчигч тутамд нэмэлт нэг үйлчлэгч.

(б) Дараах агаарын хөлөгт үйлчлэгч шаардахгүй:

- 1/ шүхэрчид тээвэрлэж буй агаарын хөлөгт;
- 2/ агаарын бөмбөлөгт;
- 3/ 19 хүртэл зорчигч тээвэрлэх агаарын хөлөгт 4-өөс доош насны хүүхдийг 91.207-ын (г)-ийн 1/-ийн дагуу тээвэрлэж буй бол нийт зорчигчийн тоо 24-өөс ихгүй бол.

(в) Агаарын хөлгийн үйлчлэгч дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ өөрийн үүргийг гүйцэтгэх чадварыг харуулсан байх:
  - 1.1 онцгой нөхцөлийн үед;
  - 1.2 ослын үед зорчигчдыг агаарын хөлгөөс яаралтай гаргах нөхцөлд.
- 2/ тухайн агаарын хөлөгт суурьлуулсан ослын үед ашиглах тоног төхөөрөмжийг ажиллуулах чадвар эзэмшсэн байна.

**91.117. Агаарын хөлгийн даргыг томилох**

(а) Нэгээс дээш нисгэгчтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэхэд ашиглагч нь тухайн агаарын хөлгийн даргын үүрэг гүйцэтгэх этгээдийг томилсон байна.

**91.119. Агаарын хөлгөөр явгалалт үйлдэх**

(а) Аливаа этгээд нь агаарын хөлөг ашиглагч, эсхүл техник үйлчилгээний байгууллагаас зохих зөвшөөрөл олгогдоогүй, мөн дараах шаардлагыг хангаагүй тохиолдолд аэродромын талбайд агаарын хөлгөөр явгалалт үйлдэхийг хориглоно:

- 1/ агаарын хөлгөөр явгалалт үйлдэх чадвар эзэмшсэн байх;
- 2/ радио холбоо ашиглах шаардлагатай бол радиотелефон холбоо ашиглах чадвартай байх;
- 3/ тухайн аэродромд мөрдөх газар дээрх хөдөлгөөний дүрэм журамтай танилцсан байх.

**91.121. Зорчигчдын үйлчилгээнд зориулсан тоног төхөөрөмжийг хурааж бэхлэх**

(а) Дараах тоног төхөөрөмжийг дор зааснаар байрлуулаагүй тохиолдолд агаарын хөлгөөр явгалалт, хөөрөлт ба буулт үйлдэхийг хориглоно:

- 1/ зорчигчдын хоолны тавиур, эсхүл ширээг хураагаагүй бол;
- 2/ зорчигчдын үйлчилгээнд зориулсан тэргэнцэрийг бэхлээгүй бол;
- 3/ суудлын түшлэг нь босоо байдалд, эгнээ хоорондох зай нь чөлөөтэй бус бол.
- 4/ агаарын хөлгийн дүрс бичлэгийн дэлгэц хураагдаагүй бол;

**91.123. Нислэгийн сургалтад ашиглах агаарын хөлөгт тавигдах шаардлага**

(а) Аливаа этгээд, дараах тоног төхөөрөмж суурилуулаагүй агаарын хөлгөөр (агаарын бөмбөлөгөөс бусад) нислэгийн сургалт явуулахгүй. Үүнд:

- 1/ бүрэн ажиллагаатай хос удирдлага;
- 2/ аль ч нисгэгчийн суудлаас хөдөлгүүрийн чадлыг болон агаарын хөлгийн бүх тэнхлэгийн дагуух хөдөлгөөнийг удирдах удирдлага.

**91.125 Хэрэглэлийн дууриамал нислэг**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд хэрэглэлийн дууриамал нислэг үйлдэх бол дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ тухайн агаарын хөлөг нь 2 нисгэгчийн суудалтай бөгөөд аль нэг нисгэгчийн суудал эзэлсэн аюулгүй ажиллагаанд хяналт тавьж буй нисгэгч нь хүчин төгөлдөр нисгэгчийн үнэмлэхтэй байх;
- 2/ аюулгүй ажиллагаанд хяналт тавьж буй нисгэгч нь:
  - 2.1 агаарын хөлгийн урд ба хажуу талуудыг ажиглах боломжтой байх;
  - 2.2 хяналт тавих, ажиглалт хийх ур чадвартай байх.
- 3/ агаарын хөлөгт дараах тоног төхөөрөмж суурилуулсан байх:
  - 1.1 бүрэн ажиллагаатай хос удирдлага;
  - 1.2 аль ч нисгэгчийн суудлаас хөдөлгүүрийн чадлыг болон агаарын хөлгийн бүх тэнхлэгийн дагуух хөдөлгөөнийг удирдах удирдлага.

(б) Энэ зүйлийн (а)-ийн 3/-т заасан шаардлагыг биелүүлээгүй агаарын хөлгөөр дараах тохиолдолд хэрэглэлийн дууриамал нислэг үйлдэхийг зөвшөөрнө:

- 1/ хэрэглэлийн дууриамал нислэг нь хяналттай агаарын зайн гадна үйлдэгдэх бол;
- 2/ агаарын хөлгийн дарга хэрэглэлийн дууриамал нислэгийн нөхцөлийг богино хугацаанд өөрчилж, хэвийн нөхцөлийг сэргээх боломжтой бол.

**91.127. Аэродром ашиглах**

(а) Аэродромоор ашиглах талбай нь агаарын хөлөг хөөрч, буухад тохиромжгүй бол аливаа этгээд нь тухайн аэродромыг нислэгийн үйл ажиллагаанд ашиглахгүй.

(б) Дараах тохиолдолд аливаа этгээд, аль нэг аэродромд агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхийг хориглоно:

- 1/ тухайн аэродромын ашиглалтын талаар эзэмшигчээс тавьсан хязгаарлалт, нөхцөлүүдийг биелүүлэх боломжгүй бол;
- 2/ хөөрч буух зурвас, нисдэг тэрэгний талбай нь шөнийн цагт хөөрөлт, буулт үйлдэхэд тухайн агаарын хөлөгт тохирсон гэрэлтүүлгээр тоноглогдоогүй, эсхүл гэрэлтүүлэг нь ажиллагаагүй бол;
- 3/ тухайн аэродромын тодорхой хэсэг агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюултай гэж тэмдэглэгдсэн, эсхүл аэродром эзэмшигчээс энэ тухай мэдэгдсэн бол;
- 4/ аэродром дээрх үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй аливаа этгээд, машин техник, бусад саадууд нь хөөрч буух зурвасны ойролцоо, эсхүл талбайд байрлаж байвал.

(в) Нисгэгч нь дараах нөхцөлд агаарын хөлгөөр аэродром орчмын нислэгийн хөдөлгөөнд оролцохгүй:

- 1/ ямар нэг саад байвал;
- 2/ өөр бусад аэродром орчмын нислэгийн хөдөлгөөн, хэрэглэлийн нислэгээр ойртолт үйлдэх журамтай зөрчилдөж байвал.

(г) Аливаа этгээд нь энэ зүйлийн (а), (б), (в)-д зааснаас бусад тохиолдолд дараах зүйлийг бататгаагүй бол нисдэг тэргээр нислэг үйлдэхгүй:

- 1/ хот, суурингийн нутаг дэвсгэрт нисдэг тэрэгний хөөрч буух талбай, эсхүл дүүжин нислэг үйлдэх бүс болгон ашиглах газарт дор дурдсан тоног төхөөрөмж, тэмдэглэгээ суурилуулсан эсэхийг:
  - 1.1 орчны физик газарзүйн үзүүлэлт, саадын хязгаарлалт нь нислэг үйлдэж буй нисдэг тэргэний үзүүлэлтэд тохирсон ил харааны таних тэмдэг, гэрэлтүүлэг;
  - 1.2 тухайн нисдэг тэрэг хөөрөлт ба авторотациитай буулт үйлдэхэд газар дээр байгаа ямар нэг зүйлд хохирол учруулах эсэх.
- 2/ хот, суурингийн гадна нисдэг тэрэгний хөөрч буух талбай, эсхүл дүүжин нислэгийн бүс болгон ашиглах газар нь дараах шаардлагыг хангасан байна:
  - 2.1 нисдэг тэрэг дүүжин нислэг хийхэд тохиромжтой бөгөөд саадаас чөлөөтэй байх;
  - 2.2 талбай нь нисдэг тэрэг хөөрч буухад тохиромжтой байх.

#### **91.129. Хязгаарлалттай болон аюултай бүсэд нислэг үйлдэх**

(а) Нисгэгч нь ИНД-73-ын дагуу тогтоосон хязгаарлалттай бүсэд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- 1/ хяналт тавих эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан;
- 2/ хязгаарлалттай бүсэд тогтоосон нөхцөлийг биелүүлэх боломжтой.

(б) Нисгэгч нь ИНД-73-ын дагуу тогтоосон аюултай бүсэд нислэг үйлдэхээр төлөвлөсөн нислэг нь агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй болохыг тогтоогоогүй бол уг бүсэд нислэг үйлдэхгүй.

#### **91.133. Цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд нислэг үйлдэх**

(а) Нисгэгч нь цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- 1/ ИНД-73-ын дагуу эрх олгогдсон хяналт тавих байгууллагаас нислэг үйлдэх зөвшөөрөл аваагүй бол;
- 2/ цэргийн үйл ажиллагаанд зориулсан бүсэд тогтоосон нөхцөлийг биелүүлэх боломжгүй бол.

### **91.135 Мэдээлэл дамжуулах**

(а) Нисгэгч нь хяналтгүй агаарын зайд (б) ба (в)-д зааснаас бусад тохиолдолд дараах шаардлагыг биелүүлээгүй бол агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- 1/ тогтоосон радио холбооны үелзэлд дараах мэдээллийг өгсөн байна:
  - 1.1 тухайн бүсэд ороход - агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр ба мэдээлэл дамжуулах бүсэд үйлдэх нислэгийн төлөвлөгөө;
  - 1.2 аэродромын тойрогт ороход - агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр ба нислэгийн төлөвлөгөө;
  - 1.3 гүйцэтгэх шугаманд орохын өмнө – агаарын хөлгийн дуудлага, хөөрөлт үйлдэх зурвасны чиглэл, хөөрөлтийн дараах нислэгийн төлөвлөгөө;
  - 1.4 нислэгийн мэдээлэл дамжуулах шаардлагатай гэж үзсэн үед- агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр ба нислэгийн төлөвлөгөө.

2/ тогтмол ил харааны болон радио холбооны хяналттай байх;

3/ агаарын хөлөг суултын болон мөргөлдөхөөс сэргийлэх гэрлээр тоноглогдсон бол асаасан байх.

(б) Агаарын хөлгөөр группээр нисэх нисгэгч нь удирдлагагүй агаарын зайд (а) 1/ болон 2/ заалтыг үл харгалзан нислэг үйлдэж болно. Үүнд:

- 1/ группээр нисэж буй нисгэгчид (а) -ийн 3/ заалтыг мөрдөж байгаа бол;
- 2/ удирдан нисэж буй нисгэгч нь (а)-ийн 1/ болон 2/ заалтыг мөрдөж байгаа бол.

(в) Удирдлагагүй агаарын зайд радио холбоогүй агаарын хөлгөөр дараах тохиолдолд нислэг үйлдэхийг зөвшөөрнө. Үүнд:

- 1/ нисгэгч нь энэ зүйлийн (а) хэсгийн 3/ заалтыг биелүүлсэн бол;
- 2/ нисгэгч нь энэ зүйлийн (а)-ийн 1/-д шаардсан мэдээллийг аливаа этгээдээр дамжуулах боломжтой бол.

(г) Шүхэр буулгах үйл ажиллагааг удирдлагагүй агаарын зайд гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь агаарын хөлгийн дуудлага, байрлал, нислэгийн өндөр ба шүхрээр буух этгээдийн тоо, нислэгийн төлөвлөлтийг шүхэр буулгах ажиллагаа эхлэхээс өмнө мэдээлнэ.

### **91.137. Галт уулын бүсэд нислэг үйлдэх**

(а) Нисгэгч нь галт уулын аюултай бүсэд дараах тохиолдолд нислэг үйлдэхгүй:

- 1/ шөнийн цагаар, эсхүл
- 2/ хэрэглэлээр нисэх цаг агаарын нөхцөлд, эсхүл
- 3/ өдрийн цагт ил харааны цаг агаарын нөхцөлд галт уулын бүс нь нислэгийг аюулгүй гүйцэтгэх нөхцөл бүрэлдсэнийг дараах эх сурвалжаас авч бататгаагүй бол:
  - 3.1 NOTAM-д зарлагдсан цаг агаарын холбогдолтой мэдээлэл;
  - 3.2 SIGMET мэдээлэл;
  - 3.3 ИНД-174-т хамаарах байгууллагуудаас өгсөн бусад мэдээлэл.



**91.139. Байгаль, цаг агаарын аюултай үзэгдэл болон газрын ба навигацийн тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагааны талаар мэдээлэх**

(а) Нислэгийн үед тулгарсан байгаль, цаг агаарын аюултай үзэгдэл, эсхүл газрын болон навигацийн тоног төхөөрөмжийн хэвийн бус ажиллагаа нь бусад нислэгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлж болзошгүй гэж үзсэн тохиолдолд, агаарын хөлгийн дарга нь энэ талаар холбогдох Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад нэн даруй мэдээлнэ.

(б) Энэ зүйлийн (а)-д заасны дагуу мэдээлэл хүлээн авсан байгууллага нь энэ талаар холбогдох эрх бүхий байгууллагад шуурхай мэдээлнэ.

**В БҮЛЭГ. НИСЛЭГИЙН ЕРӨНХИЙ ДҮРЭМ****91.201. Агаарын хөлгийн даргын үүрэг**

(а) Агаарын хөлгийн дарга нь дараах үүрэгтэй:

- 1/ нислэгийн өмнө агаарын хөлөг нислэгт тэнцэх чадвартай гэдгийг бататгах;
  - 1.1 ИНД- 91.111-ийн шаардлагад нийцсэн баримт бичиг байгааг;
  - 1.2 Агаарын хөлөгт нислэгийн өмнөх шалгалт хийснийг.
- 2/ нислэгийн бүх хугацаанд агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа, тээвэрлэж буй хүмүүсийн аюулгүй байдлыг хангах;
- 3/ агаарын хөлөгт тохиолдсон эвдрэл гэмтэл, агаарын хөлөгт байгаа ямар нэг хүний амь насанд аюул тулгарсан буюу гэмтэл авсан, мөн агаарын хөлөгт аюул учруулах цаг агаарын үзэгдлүүдийг тухай бүрт холбооны хэрэгслээр эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх;
- 4/ нисэх багийн гишүүд иргэний нисэхийн дүрэм журмыг биелүүлж байгааг бататгах.

**91.203. Агаарын хөлгийн даргын эрх**

(а) Агаарын хөлгийн дарга нь агаарын хөлөг, түүний бүхээгт зорчигч болон эд зүйлсийн аюулгүй ажиллагаатай холбогдолтой тушаал, заавар өгөх, мөн агаарын хөлөг, зорчигчийн аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй гэж үзсэн тохиолдолд дараах этгээд болон ачааг тээвэрлэхээс татгалзах эрхтэй:

- 1/ мансууруулах бодис болон согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээд нь агаарын хөлөг болон зорчигчдод аюул учруулж болзошгүй гэж үзсэн бол;
- 2/ аливаа этгээд болон ачаа тээш нь агаарын хөлөг болон зорчигчдод аюул учруулж болзошгүй гэж үзсэн бол.

**91.205. Багийн гишүүдийн ажлын байр**

(а) Агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлгийн хөөрөлт, буултын үед багийн гишүүн нь:

- 1/ агаарын хөлгийн ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэхээс, эсхүл эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх чадваргүй болсноос бусад тохиолдолд ажлын байрандаа байна;
- 2/ ажлын байранд байх хугацаандаа хамгаалах бүсээ бүсэлсэн байна.

(б) Агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлгийн хөөрөлт, буултын үед багийн гишүүн нь мөрөвчит хамгаалах бүсийг бүсэлсэн байна. Энэ заалт нь дараах тохиолдолд хамаарахгүй:

- 1/ багийн гишүүний ажлын байрны суудал нь мөрөвчит хамгаалах бүсээр тоноглогдоогүй; эсхүл
- 2/ мөрөвчит хамгаалах бүсээ бүсэлсэн үед ажил үүрэг гүйцэтгэх боломжгүй бол.

#### **91.207. Хамгаалах бүс хэрэглэх**

(а) Агаарын хөлгийн дарга нь дараах нислэгийн үе шатуудад зорчигчдыг суудалдаа сууж, хамгаалах бүсээ бүслэхийг шаардана:

- 1/ хөөрөлт, буулт бүрийн үед;
- 2/ агаарын хөлөг газрын гадаргуугаас дээш 300м ба түүнээс нам өндөрт нислэг үйлдэх үед;
- 3/ аюулгүй байдлыг хангах үүднээс агаарын хөлгийн даргаас шаардлагатай гэж үзсэн бүх хугацаанд;
- 4/ уран жолоодлогын нислэгийн үед;
- 5/ бүхээгийн хаалтгүй агаарын хөлөгт.

(б) Агаарын хөлгийн дарга нь зорчигчдыг мөрөвчтэй хамгаалах бүсээ бүслэхийг нислэг үйлдэх явцад харшлах нөлөө үзүүлэхээргүй нөхцөлд шаардахгүй:

- 1/ хөөрөлт, буулт бүрийн үед;
- 2/ агаарын хөлөг газрын гадаргуугаас дээш 300м ба түүнээс нам өндөрт нислэг үйлдэх үед.

(в) Хөөрөлт, буултын үед агаарын хөлгийн дарга нь зорчигчдыг суудлын түшлэгийг хөөрөлт, буултын байрлалд тохируулахыг шаардана.

(г) Энэ зүйлийн (а)-ийн 1/, 2/, 3/ дахь заалтууд нь хоёроос доош насны хүүхдийн хувьд дараах тохиолдолд хамаарахгүй:

- 1/ асран хамгаалагч нь насанд хүрсэн, албан ёсоор зорчигчийн суудалд сууж хүүхдийг тэвэрч яваа, ба хүүхдэд бэхэлсэн хамгаалах бүс нь харгалзан яваа хүний хамгаалах бүсэнд бэхлэгдсэн бол;
- 2/ зорчигчийн суудал нь хүүхдийг хамгаалах хэрэгслээр тоноглогдсон, хүүхэд тухайн хэрэгсэлд тогтоосон жингийн хязгаарлалтаас хэтрээгүй, асран хамгаалагч нь нислэгийн явцад аюулгүй байдалд анхаарал тавих боломжтой бол.

(д) Энэ зүйлийн (а) заалт нь агаарын бөмбөлөгөөр зорчиж яваа болон шүхрээр буух этгээдэд хамаарахгүй.

#### **91.209. Хүчилтөрөгчийн тоноглол ашиглах**

(а) Битүүмжлэлгүй агаарын хөлгөөр, далайн түвшнээс дээш 3900-4200 метр (12500-14000 фут)-ийн өндөрт, 30 минутаас дээш хугацаагаар, эсхүл 4200 метр (14000 фут)-

ээс дээш өндөрт нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь нислэгийн бүх хугацаанд дараах зүйлийг шаардана:

- 1/ багийн гишүүд болон зорчигчид нэмэлт хүчилтөрөгч хэрэглэх;
- 2/ багийн гишүүд ажлын байрнаас холдох шаардлагатай үед зөөврийн хүчилтөрөгч хэрэглэх.

(б) Агаарын хөлөг нь битүүмжлэлийн системтэй тохиолдолд агаарын хөлгийн дарга:

- 1/ бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр 10000 фут (3050 метр)-ээс дээш байгаа бүх хугацаанд дараах зүйлийг шаардана:
  - 1.1 багийн гишүүдийг нэмэлт хүчилтөрөгч хэрэглэхийг;
  - 1.2 багийн гишүүд ажлын байрнаас холдох шаардлагатай үед хүчилтөрөгчийн баг, тохируулагч бүхий зөөврийн хүчилтөрөгч хэрэглэхийг;
- 2/ нислэгийн өндөр 10600-12500 метр (35000-41000 фут)-ийн хооронд байх үед дараах зүйлийг шаардана:
  - 2.1 бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр 13000 фут (4000 метр)-ээс хэтэрсэн үед нисгэгч бүр нэмэлт хүчилтөрөгчөөр автоматаар хангагддаг хүчилтөрөгчийн баг хэрэглэх;
  - 2.2 хоёр нисгэгч өөрсдийн ажлын байрнаас 5 секундын дотор хүчилтөрөгчийн баг авч хэрэглэх боломжтой байх.
- 3/ Нислэгийн өндөр 12500 метр (41000 фут)-ээс дээш үед нисгэгчийн суудалд үүрэг гүйцэтгэж буй аль нэг нисгэгчийг нислэгийн бүх хугацаанд хүчилтөрөгч хэрэглэхийг шаардана.

(в) Битүүмжлэлтэй агаарын хөлгийн битүүмжлэлийн системд гэмтэл гарсны дараа уг агаарын хөлөг 4 минутын хугацаанд далайн түвшнээс дээш 4200 м (14000 фут) ба түүнээс доош өндөрт орж чадахгүй тохиолдолд бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь 14000 фут (4200 метр)-ээс дээш байх хугацаанд бүх зорчигч нэмэлт хүчилтөрөгчийн баг хэрэглэхийг хөлгийн дарга шаардана.

#### **91.211. Зорчигчдод өгөх мэдээлэл**

(а) Агаарын хөлгөөр зорчигч тээвэрлэж буй тохиолдолд ашиглагч нь зорчигчдод дараах мэдээллүүдийг өгсөн байна:

- 1/ тамхи татахыг хориглох талаар;
- 2/ энэ дүрмийн 91.121 болон 91.207-д заасан шаардлагууд;
- 3/ үндсэн хаалгууд болон аврах гарцуудын байрлал, тэдгээрийг ашиглах заавар;
- 4/ дараах төхөөрөмж суурилуулсан бол:
  - 4.1 зорчигчдод зориулсан авран хамгаалах болон онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх тоноглолын байрлал;
  - 4.2 усан дээгүүрх нислэгийн үед энэ дүрмийн 91.525-д шаардсан хөвөгч төхөөрөмжийг хэрэглэх заавар;
  - 4.3 зорчигчдод зориулсан агаарын хөлөгт суурилуулсан хүчилтөрөгчийн төхөөрөмжийг ашиглах заавар.
- 5/ онцгой нөхцөлд буулт үйлдэх үед мөрдөх журам;
- 6/ энэ дүрмийн 91.7-д заасан зөөврийн цахим хэрэгслүүдийг ашиглах журам.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан мэдээллийг:

- 1/ агаарын хөлгийн дарга, багийн гишүүн болон ашиглагчаас томилогдсон этгээд өгнө, эсхүл дүрс бичлэг ашиглан танилцуулж болно;
- 2/ нислэгийн өндөр 7600 метр (25000 фут)-ээс дээш байх тохиолдолд хүчилтөрөгчийн төхөөрөмж ашиглах зааврыг танилцуулна;
- 3/ ослын үед аврах хантааз хэрэглэх заавар;
- 4/ шаардлагатай бол иргэний нисэхийн холбогдох дүрэмд шаардсаны дагуу гэрлэн тэмдэгтүүд буюу багийн гишүүдээс өгч буй заавар, мэдээллийг бүх зорчигчид дагаж мөрдөх тухай журам;
- 5/ дараах зүйлийг агуулсан танилцуулгыг зорчигч бүрт нэмэлт заавар болгон ашиглаж болно:
  - 5.1 аврах хаалгуудыг ашиглах аргачлалыг харуулсан зураг;
  - 5.2 аврах тоног төхөөрөмжийг ашиглахад шаардлагатай бусад зааврууд.

(в) Энэ зүйлийн (б)-ийн 5/-д заасны дагуу бусад зааврыг ашиглах тохиолдолд тохиромжтой газарт байрлуулж, агаарын хөлгийн маяг, загварт тохирсон мэдээллүүд агуулагдсаныг ашиглагч бататгана.

### **91.213. Гар тээшийг байрлуулах**

(а) Агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлөг ашиглаж буй этгээд нь хөөрөлт, буултын үед зорчигчийн гар тээшийг дор дурьдсан газар байрлуулна:

- 1/ гар тээш байрлуулах тавиур дээр; эсхүл
- 2/ зорчигчийн суудал дор дараах байдлаар:
  - 2.1 урагшаа гулсахгүйгээр;
  - 2.2 онцгой нөхцөл байдлын үед агаарын хөлгөөс зорчигчдыг яаралтай гаргахад саад болохгүйгээр.

### **91.215. Ачаа тээвэрлэх**

(а) Агаарын хөлөг ашиглагч ачааг тээвэрлэхдээ:

- 1/ ачааг суудал дээр, ачааны тавцан буюу ачаа тээшний хэсэгт байрлуулна;
- 2/ ачааг хамгаалалтын тор буюу бусад хэрэгслээр бэхэлсэн байна;
- 3/ зорчигчдод гэмтэл учруулахаас сэргийлэн ачааг баглаж боосон байна.

(б) Ашиглагч нь ачаа тээвэрлэхээр зөвшөөрөгдсөн бол дараах нөхцөлд агаарын хөлгөөр ачаа тээвэрлэхийг хориглоно:

- 1/ тээвэрлэх ачааны жин агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт заасан суудал, тавцан, шалны даацын хязгаарлалтаас хэтэрсэн бол;
- 2/ агаарын хөлгийн хаалга болон аврах гарцыг ашиглах боломжийг хязгаарлаж байрлуулсан бол.

### **91.217. Нислэгийн өмнөх мэдээлэл**

(а) Нислэг эхлэхийн өмнө агаарын хөлгийн дарга нь тухайн нислэгтэй холбогдсон, дараах мэдээлэлтэй бүрэн танилцсан байна:

- 1/ цаг агаарын мэдээлэл;
- 2/ шаардлагатай түлшний хэмжээ;
- 3/ төлөвлөгдсөн нислэгийг дуусгах боломжгүй болсон тохиолдолд сонгох хувилбар;
- 4/ НХУ-аас мэдэгдсэн, эсхүл гарч болзошгүй агаарын хөдөлгөөний саатал;

- 5/ нислэгт ашиглах газрын холбоо, навигацийн тоног төхөөрөмжийн нөхцөл байдал;
- 6/ нислэгт ашиглах аэродромын бодит нөхцөл байдал, хөөрч буух зурвасны урт;
- 7/ нислэгийн ашиглалтын зааварт байх хөөрөлт, буултын өгөгдөхүүн;
- 8/ олон хөдөлгүүрт агаарын хөлгийн хувьд
  - 8.1 нэг хөдөлгүүр татгалзсан үеийн заавар
  - 8.2 нэг хөдөлгүүр татгалзсан үеийн нислэгийн өгөгдөхүүн.

**91.219. Үйл ажиллагааны хязгаарлалт, аврах тоног төхөөрөмжтэй танилцах**

- (а) Нислэг эхлэхийн өмнө нисгэгч бүр дор дурдсан зүйлтэй танилцсан байна:
- 1/ тухайн агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын заавар;
  - 2/ үйлдвэрлэгчээс, эсхүл ИНЕГ-аас тухайн агаарын хөлгийн хувьд тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалтыг багтаасан тэмдэг, тэмдэглэгээ, жагсаалтууд;
  - 3/ тухайн агаарын хөлөгт суурилуулсан онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх тоног төхөөрөмж;
  - 4/ онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх тоног төхөөрөмжийг ажиллуулахаар томилогдсон багийн гишүүн;
  - 5/ онцгой нөхцөл байдлын үед зориулалтын тоног төхөөрөмжийг хэрэглэх журмууд;
  - 6/ тухайн маягийн агаарын хөлгийг хүйтний улиралд ашиглах тухай Иргэний нисэхийн ерөнхий газраас хүлээн зөвшөөрсөн журам.

**91.221. Нислэгийн тоног төхөөрөмж ба мэдээлэл**

(а) Агаарын хөлгийн дарга нисэх багийн бүх гишүүдийг дор дурдсан тоног төхөөрөмж болон гарын авлага, мэдээллийг хэрэглэх нөхцөлөөр хангасан гэдгийг бататгасан байна:

- 1/ цаг хугацаа заах хэрэгсэл;
- 2/ тухайн нислэгийн агаарын навигацийн зураг;
- 3/ хэрэглэлийн нислэгт зориулсан нисэн гарах, чиглэлийн, аэродромын бүсийн, ойртолт буултын үед ашиглагдах навигацийн гарын авлага, зургууд;
- 4/ шөнийн нислэгт зориулсан гар чийдэн (нисэх багийн гишүүдэд).

(б) Энэ зүйлийн (а)-д зааснаас гадна, 5700 кг-аас дээш хөөрөлтийн жинтэй агаарын хөлгийг ашиглагч нь уг агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт заасны дагуу нислэгийн хэвийн болон онцгой нөхцөлийн үед хэрэглэх хяналтын хуудас ашиглахыг нисэх багийн гишүүдээс шаардана.

**91.223. Аэродром дээр болон түүний ойролцоо нислэг үйлдэх**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, аэродром дээр болон түүний ойролцоо нислэг үйлдэж буй нисгэгч нь:

- 1/ аюултай ойртолт болон мөргөлдөхөөс сэргийлэх зорилгоор аэродромын орчны бусад агаарын хөлгийн хөдөлгөөнийг ажиглана;
- 2/ НХУ-аас өөр заавар өгсөн буюу зөвшөөрөл олгоогүй бол, аэродромын орчинд явагдаж буй бусад агаарын хөлгийн нислэгт нийцүүлэх буюу тэдгээрээс аюулгүй зайд ниснэ;

- 3/ Зүүн гар тийш эргэлтийг Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл /AIP/-д аэродром дээр буухаар ойртолт үйлдэх үед буюу уг аэродромоос хөөрсний дараа дор дурдсанаас бусад нөхцөлд:
  - 3.1 НХУ -аас өөр заавар өгсөн буюу зөвшөөрөл олгосон;
  - 3.2 хэрэглэлийн нислэгийн үед Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д аэродромд буухаар ойртолт үйлдэх үед буюу уг аэродромоос хөөрсний дараа баруун гар тийш эргэлт хийх зааварчилгаа тогтоогоогүй;
- 4/ Баруун гар тийш эргэлтийг Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д аэродромд буухаар ойртолт үйлдэх үед буюу уг аэродромоос хөөрсний дараа дор дурдсанаас бусад нөхцөлд:
  - 4.1 НХУ -аас өөр заавар өгсөн буюу зөвшөөрөл олгосон;
  - 4.2 хэрэглэлийн нислэгийн үед Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д аэродромд буухаар ойртолт үйлдэх үед буюу уг аэродромоос хөөрсний дараа зүүн гар тийш эргэлт хийх зааварчилгаа тогтоогоогүй;
- 5/ НХУ-аас өөр заавар өгөх буюу зөвшөөрөл олгоогүй бол, нисгэгч нь аэродромын орчин дахь хөдөлгөөний журмуудыг дагаж мөрдөнө.

(б) Энэ зүйлийн (а)-ийн 3/, 4/ 5/ нь энэ дүрмийн 91.703-т заасны дагуу үзүүлэх нислэгт оролцож буй агаарын хөлгийн даргад хамаарахгүй.

(в) Хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээгүй аль нэг аэродром дээр буухаар ойртолт үйлдэх үед буюу уг аэродромоос хөөрсний дараа, дор дурдсан нөхцөлд аль ч чиглэлд эргэлт хийж болно:

- 1/ ашиглаж буй аэродромын хөөрч буух зурвасны дохио, тэмдэгтүүд харагдаж байвал;
- 2/ аэродромын бусад хөдөлгөөнтэй зөрчилдөөгүй бол.

(г) Нисдэг тэрэгний дарга нь энэ зүйлийн (а)-г биелүүлэх **буюу /эсхүл/** онгоцны нислэгт ашиглаж буй аэродромын тойрог нислэгээс зайлсхийнэ.

#### **91.225. Нислэгийн хөдөлгөөний удирдлагатай аэродромд нислэг үйлдэх**

(а) Нислэгийн хөдөлгөөний удирдлагатай аэродром дээр буюу түүний ойролцоо нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга:

- 1/ НХУ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, НХУ албатай тогтоосон давтамж дээр хоёр талын радио холбоо барина;
- 2/ нислэгийн дор дурьдсан үе шатууд эхлэхээс өмнө, уг хяналтын үйлчилгээнээс зөвшөөрөл авна:
  - 2.1 маневрлах талбайн аль нэг хэсэгт явгалах;
  - 2.2 тухайн аэродромын хөөрч буух зурвас буюу нисдэг тэрэг хөөрч буух талбайд буух буюу түүнээс хөөрөх;
  - 2.3 шууд удирдлагын бүсэд орох.

(б) Нислэгийн мэдээллийн үйлчилгээ бүхий аэродром дээр буюу түүний ойролцоо нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга:

- 1/ тухайн агаарын хөлөг радио холбоогоор тоноглогдсон бол мэдээллийн үйлчилгээний албатай тогтоосон давтамж дээр хоёр талын радио холбоо барина;
- 2/ нислэгийн дор дурьдсан үе шатууд эхлэхээс өмнө, уг мэдээллийн үйлчилгээний албанд төлөвлөж буй үйлдлийнхээ талаар мэдэгдэнэ:
  - 2.1 маневрын талбайн аль нэг хэсэгт явгалах;

- 2.2 тухайн аэродромын хөөрч буух зурвас буюу нисдэг тэрэг хөөрч буух талбайд буух ба түүнээс хөөрөх;
- 2.3 тухайн аэродромын тойрог нислэгт орох.

(в) Радио холбоогоор тоноглогдоогүй агаарын хөлгөөр нислэгийн мэдээллийн үйлчилгээтэй аэродром дээр буюу түүний ойролцоо нислэг үйлдэж байгаа тохиолдолд агаарын хөлгийн дарга, нислэгийн дараах үе шатууд эхлэхээс өмнө тухайн аэродромын үйлчилгээний талаар мэдээлэл авсан байна:

- 1/ маневрлах талбайн аль нэг хэсэгт явгалах;
- 2/ тухайн аэродромын тойрог нислэгт орох.

#### **91.227. Өөр агаарын хөлгийн ойролцоо нислэг үйлдэх**

- (а) Нисгэгч нь дараах тохиолдлуудад агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:
- 1/ өөр агаарын хөлөгт хэт ойр, мөргөлдөх эрсдэл үүсгэж болзошгүй бол;
  - 2/ групп (жагсаалын) нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга тус бүртэй урьдчилан тохиролцоогүй бол;
  - 3/ шүхэрчид буулгахаас бусад, арилжааны зориулалттай зорчигч тээвэрлэх групп нислэг бол.

#### **91.229. Нислэгийн хөдөлгөөний давуу эрхийн дүрэм**

- (а) **Хөдөлгөөний давуу эрхийн дүрэм.** Нисгэгч нь:
- 1/ бусад агаарын хөлгийн хөдөлгөөнөөс зайлсхийх зорилгоор нислэгийг ХНД буюу ИХНД-ын дагуу үйлдэж байгаагаас үл хамааран, цаг агаарын байдал боломжтой байвал ил харааны ажиглалт хийнэ;
  - 2/ Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх системээс (ACAS) өгч буй анхааруулга, шийдвэрийг үндэслэн мөргөлдөөнөөс зайлсхийх маневр үйлдэх үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөхгүй;
  - 3/ өөр агаарын хөлөг өнгөрөн гарах үед дагалдах хуйлралын нөлөөг харгалзан үзээгүй бол уг агаарын хөлгийн эгц урдаас чиглэж, эсхүл түүний дээгүүр буюу доогуур гарахаас зайлсхийж, зам тавьж өгнө.

(б) **Эгц урдаас ойртох.** Өөр агаарын хөлөг эгц урдаас нь, уулзах чиглэлээр ойртож байгаа үед нисгэгч чиглэлийг баруун гар тийш өөрчилнө.

(в) **Агаарын хөлгүүдийн чиглэл огтлолцох.** Өөр агаарын хөлөгтэй ижил өндөрт, нэг цэгт огтлолцох чиглэлээр нисэж буй агаарын хөлгийн нисгэгч нь баруун гар талдаа байгаа агаарын хөлөгт зам тавьж өгнө. Энэ заалт нь дараах нөхцөлүүдэд хамаарахгүй:

- 1/ дирижабль, планер болон агаарын бөмбөлөг нь агаараас хүнд, хөдөлгүүрт агаарын хөлгөөс давуу эрхтэй;
- 2/ планер, агаарын бөмбөлөг нь дирижаблиас давуу эрхтэй;
- 3/ агаарын бөмбөлөг нь планераас давуу эрхтэй;
- 4/ планер чирч яваа агаарын хөлөг нь хөдөлгүүрт агаарын хөлгөөс давуу эрхтэй.
- 5/ шүхрээр бууж буй этгээд нь бүх төрлийн агаарын хөлгөөс давуу эрхтэй.

(г) **Агаарын хөлгийг гүйцэж түрүүлэх.** Гүйцэж түрүүлж буй агаарын хөлөг нь өмнөө байгаа агаарын хөлгөөс зайлсхийх эргэлт шаардлагатай тохиолдолд чиглэлийг баруун гар тийш өөрчилж гүйцэж түрүүлнэ.

*Тайлбар: Гүйцэж түрүүлж байгаа агаарын хөлөг гэж өмнөө байгаа агаарын хөлгийн ар талаас 70 градусуаас бага өнцгөөр тэгш хэмт шугам үүсгэн ойртож байгаа агаарын хөлгийг хэлнэ.*

(д) **Буух.** Агаарт болон газарт байрлаж буй агаарын хөлгийн нисгэгч нь:

- 1/ буултын үе шатанд буюу буулт үйлдэж буй агаарын хөлөгт бусад агаарын хөлөг зам тавьж өгнө;
- 2/ буулт хийхээр ойртолт үйлдэж буй хоёр буюу түүнээс дээш агаарын хөлгүүд нь нам өндөрт байгаа агаарын хөлөгтөө зам тавьж өгнө;
- 3/ буултын үе шатанд яваа агаарын хөлгийн урдуур өнгөрөх буюу уг агаарын хөлгийг гүйцэж түрүүлэхэд энэ хэсгийн 2/-т заасан давуу эрхийг эдлэхгүй.

(е) **Хөөрөх.** Бусад агаарын хөлөгтэй мөргөлдөх илэрхий аюул байвал хөөрөлт үйлдэхийг хориглоно.

(ж) **Явгалах.** Аэродромын талбайд явгалж буй агаарын хөлгийн нисгэгч нь:

- 1/ буулт, хөөрөлт үйлдэж байгаа болон хөөрөлт үйлдэх гэж байгаа агаарын хөлөгт зам тавьж өгнө;
- 2/ өөр агаарын хөлөгтэй эгц урдаас, эсвэл хэт ойртож байгаа тохиолдолд зогсох ба аюулгүй зайд холдох хүртэл чиглэлийг баруун гар тийш өөрчилнө;
- 3/ хоёр агаарын хөлгийн явгалах зам огтлолцож байвал, баруун гар талдаа байгаа агаарын хөлөгт зам тавьж өгнө;

(з) Бүх агаарын хөлгийн нисгэгч нь аюулд учирсан агаарын хөлөгт зам тавьж өгнө.

### **91.231. Нислэгийн төлөвлөгөө**

(а) Нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга нислэг эхлэхээс өмнө нислэгийн төлөвлөгөөг зохих НХҮ-ний байгууллагад хүргүүлнэ.

(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан нислэгийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг багтаасан байна:

- 1/ агаарын хөлгийн таних тэмдэг;
- 2/ агаарын хөлгийн маяг болон түүний арын салхины хуйлралын ангилал;
- 3/ агаарын хөлгийн радио холбоо, навигацын болон буултын тоног төхөөрөмж,
- 4/ нисэн гарах аэродром, нисэн гарах цаг;
- 5/ нислэгийн хурд, өндөр, маршрут;
- 6/ нисэн очих аэродром, нислэгийн тооцоолсон нийт цаг, бэлтгэл аэродром;
- 7/ НХҮ-д шаардагдах нэмэлт мэдээллүүд;
- 8/ шатахууны нөөц;
- 9/ агаарын хөлөгт байгаа хүмүүсийн тоо;
- 10/ агаарын хөлөгт байгаа ослын болон аврах тоног төхөөрөмж.

(в) Энэ зүйлийн (а)-д шаардсан нислэгийн төлөвлөгөөг хүргүүлсэн бол, агаарын хөлгийн дарга нь төлөвлөсөн аэродромоос нисэн гарах цагаас 30 минут хэтэрсэн саатлыг НХҮ-ний байгууллагад мэдэгдэнэ.



(г) Нислэгийн төлөвлөгөөг хүргүүлсэн агаарын хөлгийн дарга нь нисэн очих аэродром дээр буулт хийж нислэг дууссан тухай зохих НХУ-ний байгууллагад мэдэгдсэнээр уг нислэгийн төлөвлөгөөг дууссан гэж үзнэ.

### **91.233. Агаарын хөлгийн гэрэл**

(а) Нисгэгч нь:

- 1/ агаарын хөлгийн навигацийн гэрлийг асаалгүйгээр шөнийн цагт нислэг үйлдэхгүй;
- 2/ энэ дүрмийн Е Бүлэгт шаардсаны дагуу тухайн агаарын хөлөгт суурилуулсан мөргөлдөхөөс сэргийлэх гэрлийн систем нь ажиллагаагүй бол шөнийн цагаар нислэг үйлдэхгүй.

(б) Аливаа этгээд дараах тохиолдолд, аэродромын талбайд шөнийн цагаар агаарын хөлгийг байрлуулах буюу шилжүүлэн зөөхгүй:

- 1/ агаарын хөлгийн гэрэл тод биш;
- 2/ агаарын хөлгийн навигацийн гэрэл асаагүй;
- 3/ агаарын хөлөг нь саадын гэрлэн тэмдэглэгээгүй талбайд байвал.

### **91.235. Агаарын хөлгөөс эд зүйл унагах ба цацах**

(а) Хүмүүс, эсхүл бусдын эд хөрөнгөнд гэмтэл, аюул учруулахгүй гэдгийг бататгаагүй бол нислэгийн үед агаарын хөлгөөс аливаа эд зүйлс унагах болон цацахыг хориглоно.

### **91.237. Агаарын хөлгийн хурдны хязгаарлалт**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд агаарын хөлгөөр далайн дундаж түвшнээс дээш 3000 м (10000 фут) ба түүнээс доош өндөрт 460 км/ц (250 kts)-аас их хэрэглэлийн хурдтайгаар нисэхийг хориглоно:

- 1/ D, E, эсхүл G ангиллын агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж байвал;
- 2/ C, D, E эсхүл G ангиллын агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэж байвал.

(б) Дараах тохиолдолд (а) заалт хамаарахгүй:

- 1/ нислэгийн ашиглалтын зааварт агаарын хөлгийн аюулгүй бага хурд нь 460 км/ц (250 kts)-аас их бөгөөд тухайн агаарын хөлөг аюулгүй бага хурдаар нислэг үйлдэж байвал;
- 2/ энэ дүрмийн 91.703-т заасны дагуу тухайн агаарын хөлөг үзүүлэх нислэгт оролцож байвал.

### **91.239. Өндөр хэмжигчийг тохируулах**

(а) Нисгэгч нь НХУ-аас зөвшөөрсний дагуу өндөр хэмжигчийг тохируулан агаарын хөлгийн нислэгийн үнэмлэхүй өндөр буюу нислэгийн өндрийн цувааг дараах байдлаар тогтоон зохицуулна:

- 1/ тухайн аэродромд тогтоосон шилжих өндөр буюу түүнээс дээш нислэгийн өндөрт нисэх үед өндөр хэмжигчийн даралтыг 1013.25 гПа (760 мм.муб)-д шилжүүлнэ;
- 2/ тухайн аэродромд тогтоосон шилжих өндрийн цуваа буюу түүнээс доош өндөрт нисэх үед аэродромын QNH ба QFE даралтад шилжүүлнэ;
- 3/ шилжих өндөр ба шилжих өндрийн цувааны хооронд нислэг үйлдэх үед НХУ-аас зөвшөөрсөн өндрийг хадгална.

(б) Нислэгийн өндөр нь нисэн гарсан аэродромын шилжих өндрөөс нам бол өндрийн хэмжээг НХУ-аас өгсөн даралт ба өндрөөр хадгалж, НХУ-ын бүсээс гарсны дараа 1013.25 гПа (760 мм.муб)-д тохируулна.

**91.241. НХУ-аас өгсөн зөвшөөрөл, зааврыг биелүүлэх**

(а) Агаарын хөлгөөр нисэж буй нисгэгч нь ИНД-71 дагуу тогтоогдсон агаарын зайд:

- 1/ ACAS болон GPWS ба TAWS-аас өгөгдсөн зааврын дагуу маневр хийгдсэнээс бусад тохиолдолд НХУ-аас өгсөн зөвшөөрөл, зааврыг биелүүлнэ;
- 2/ НХУ-аас өгсөн зөвшөөрөл, заавар нь агаарын хөлөг аюулгүй нисэх шаардлагад нийцэхгүй байвал энэ тухай НХУ-д аль болох хурдан хугацаанд мэдэгдэнэ.

(б) НХУ-ын зөвшөөрөл, заавар нь энэ дүрмийн заалтуудыг зөрчиж байвал нисгэгч тэдгээр зөвшөөрөл, зааврыг дагаж мөрдөхгүй;

(в) Нисгэгч нь (б) зүйлд заасан НХУ-аас өгсөн заавар зөвшөөрлийг дагаж мөрдөөгүй бол энэ тухай НХУ-д яаралтай мэдэгдэнэ.

**91.243. НХУ-аас өгөх гэрлэн дохио**

(а) Нисгэгч нь Хүснэгт 1-д заасан, НХУ-аас өгсөн гэрлэн дохионы зөвшөөрөл, зааврыг биелүүлнэ.

**Хүснэгт 1. НХУ-аас өгөх гэрлэн дохионууд**

Гэрлэн дохио	Агаарт байгаа онгоцонд	Газарт байгаа онгоцонд
Үргэлжилсэн ногоон гэрэл	Буухыг зөвшөөрнө.	Хөөрөхийг зөвшөөрнө.
Үргэлжилсэн улаан гэрэл	Бусад агаарын хөлөгт зам тавьж өгөөд, тойрог нислэгийг үргэлжлүүл.	Зогс
Анивчсан ногоон гэрэл	Буухаар буцаж эргэ (буух зөвшөөрлийг тухайн үед нь өгнө)	Явгалахыг зөвшөөрнө.
Анивчсан улаан гэрэл	Аэродром аюултай, бууж болохгүй.	Ашиглаж буй буултын талбайгаас зайтай явгалалт үйлд
Анивчсан цагаан гэрэл	Энэ аэродром дээр буугаад, зогсоол руу оч. (явгалах зөвшөөрлийг тухайн үед нь өгнө)	Аэродром дээрх гарааны цэг рүү буц.
Улаан, ногоон гэрэл ээлжлэн анивчих	Анхаар, аюултай	Анхаар, аюултай.

**91.245. Хяналттай агаарын зайд нислэг үйлдэх**

(а) Агаарын хөлгийн дарга нь ИНД-71-ийн дагуу тогтоосон хяналттай агаарын зайд (д)-д зааснаас бусад тохиолдолд нэвтрэхийн өмнө НХУ-аас зөвшөөрөл авна.

(б) А ангиллын агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь:

- 1/ ХНД-ийн дагуу нислэг үйлдэнэ;
- 2/ НХУ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, тогтоосон давтамж дээр НХУ-тай хоёр талын радио холбоо барина;
- 3/ агаарын хөлөг нь автоматаар өндөр дамжуулах төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

(в) Дор заасан агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь тогтоосон давтамж дээр НХУ-тай хоёр талын радио холбоо барина:

- 1/ С, ба D ангиллын агаарын зайд;
- 2/ ХНД-р E ангиллын агаарын зайд.

(г) Өөр ангиллын агаарын зай нь ойролцоо өндөрт, босоо хилээр нийлж байвал, нисгэгч бага хязгаарлалттай ангилал бүхий агаарын зайн шаардлагыг дагаж мөрдөж болно.

(д) ИХНД-ээр нислэг үйлдэж буй нисгэгч нь E ангиллын агаарын зайд НХУ-аас зөвшөөрөл авахгүй.

#### **91.247. Автомат хариулагч, өндрийг мэдээлэх төхөөрөмж ашиглах**

(а) Агаарын зайд НХУ-аас өөр заавар, зөвшөөрөл олгоогүй бол, энэ зүйлийн (г)-д зааснаас бусад тохиолдолд автомат хариулагч шаардсан хяналттай агаарын зайд нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь:

1/ автомат хариулагч нь:

- 1.1 С эсхүл А горимд ажиллах; ба
- 1.2 агаарын хөлөг нь “S” горимд ажиллахаар тоногдсон бол (б) заалтыг баримтална.

2/ S горимд ажиллах төхөөрөмж энэ хэсгийн 3/-т зааснаас бусад тохиолдолд SSR код тохируулагч нь;

- 2.1 НХУ-аас өгсөн зохих код дээр; эсхүл
- 2.2 НХУ-аас код өгөөгүй бол Хүснэгт 2-т заасны дагуу байна.

3/ онцгой болон ноцтой байдал бий болсон нөхцөлд код тохируулагчийг Хүснэгт 3-т заасны дагуу тавих боломжтой.

(б) НХУ-аас тухайн агаарын хөлөгт оноож S горимд ажиллах автомат хариулагчийн онцгой хаягийн код олгоогүй бол S горимд ажиллах автомат хариулагчаар тоноглогдсон агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй.

(в) Автомат хариулагч шаардсан хяналттай агаарын зайд автомат хариулагчгүй нислэг үйлдэхээр төлөвлөсөн агаарын хөлгийн дарга тухайн НХУ-аас тусгай зөвшөөрөл авна.

(в) Автомат хариулагч шаардсан хяналттай агаарын зайд нислэг үйлдэх үед уг төхөөрөмжийн ажиллагаа доголдох ба татгалзсан тохиолдолд агаарын хөлгийн дарга тухайн НХУ-д яаралтай мэдэгдэнэ.

(г) Групп нислэгт зөвхөн нэг агаарын хөлөг энэ зүйлийн (а)-д заасны дагуу автомат хариулагч ашиглах шаардлагатай.

**Хүснэгт 2. Хяналттай агаарын зайд автомат хариулагчид ашиглах кодууд**

Нислэг үйлдэх дүрэм	Агаарын хөлгийн төрөл	Код
ХНД	Бүх	2000
ИХНД	Бүх	1200

**Хүснэгт 3. Онцгой нөхцөл байдлын үед автомат хариулагчид ашиглах кодууд**

Ашиглах нөхцөл	Код
Хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед	7500
Радио холбоо алдагдах үед	7600
Ослын болон яаралтай үед	7700

**91.249. Агаарын хөлгийн дуудлага**

(а) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь дор дурдсан радио холбооны таних дуудлагыг хэрэглэнэ:

- 1/ тухайн агаарын хөлөг ашиглагчийн батлагдсан радио холбооны таних дуудлагын дараа нислэгийн дугаар буюу таних тэмдэг;
- 2/ тухайн агаарын хөлгийн бүртгэлийн тэмдгийн сүүлийн 3 тоо, эсхүл үсэг.

(б) Энэ зүйлийн (а)-ийн 2/-ыг үл харгалзан, зохих НХҮ-ний байгууллагатай хоёр талын холбоо барьсны дараа, агаарын хөлгийн дарга нь тухайн агаарын хөлгийн бүртгэлийн тэмдгийн сүүлийн 3 тооноос бүрдсэн товчилсон дуудлагыг хэрэглэж болно.

(в) Энэ зүйлийн (а)-ийн заалтуудыг ИНД-119 буюу ИНД-129-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч нь дараах үйл ажиллагаанд хэрэглэнэ:

- 1/ агаарын тээврийн тогтмол үйл ажиллагаа;
- 2/ эрэн хайх, авран туслах нислэг;
- 3/ эмнэлгийн тусламжийн нислэг.

**91.251 Автомат бичлэг хийх төхөөрөмжийн ажиллагаа**

(а) Аливаа этгээдийг агаарын хөлөгт ИНД-91.509-ийн (б)-д заасны дагуу тоногдсон автомат бичлэг хийх төхөөрөмжийн ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.

**91.253. Агаараас талбай сонгож буух**

(а) Бүх төрлийн нисдэг тэрэг, 3250 кг-аас бага хөөрөлтийн жинтэй онгоц нь агаараас талбай сонгож бууж болно.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэхэд дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ сонгосон талбайн хэмжээ нь тухайн онгоцны нислэгийн ашиглалтын зааварт заасан хязгаарлалтаас урт нь 1,5 дахин их байх;
- 2/ орчны саадууд нь аюулгүй буулт, хөөрөлт үйлдэх нөхцөлийг хангасан байх;
- 3/ агаараас салхины чигийг тодорхойлох боломжтой арга хэрэгслийг ашиглах;
- 4/ Стандарт ангиллын НТЧ гэрчилгээтэй агаарын хөлгийн дарга нь ИНД-61-ийн дагуу багшлах, эсхүл спортын нисгэгчийн зэрэглэлтэй байна.

(в) Талбай сонгож буух үеийн цаг агаарын хязгаарлалт нь энэ дүрмийн 91.301-д заасан утгаас багагүй байна.

(г) Байнгын болон түр байрлалаасаа 50 км зайд нисэж байгаа спортын болон хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгөөс бусад агаарын хөлгийн дарга талбай сонгож буусан тухайгаа буулт үйлдсэнээсээ хойш 30 минутын дотор НХҮ-ний байгууллагад мэдэгдэнэ.

(д) Нислэгийн төлөвлөгөөний дагуу зогсох хугацаа, эсхүл төлөвлөгөө өөрчлөгдсөн үед нисэн гарах хугацааг НХҮ-ний байгууллагад мэдээлнэ.

#### **91.255. RNP агаарын зайд нислэг үйлдэх**

(а) Аливаа этгээд иү дараахь шаардлагыг хангаагүй тохиолдолд RNP агаарын зайд нислэг үйлдэхгүй:

- 1/ энэ дүрмийн дагуу холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан, тухайн агаарын хөлөг, түүний навигацийн системийг RNP агаарын зайн нислэгт ашиглах заавар агаарын хөлөгт байх;
- 2/ RNP агаарын зайд, батлагдсан зааварт заасан журам, хязгаарлалтын хүрээнд нислэгийг гүйцэтгэх;
- 3/ RNP нислэгт ашиглах, энэ дүрмийн 91.519-д шаардсан хэрэглэл, тоног төхөөрөмжид батлагдсан хөтөлбөрийн дагуу техник үйлчилгээ хийж, үзлэг шалгалт хийгдсэн байх;
- 4/ нисэх багийн гишүүд нь дор дурдсан зүйлтэй танилцаж, тэдгээрийн талаар зохих мэдлэг эзэмшсэн байх:
  - 4.1. нислэг гүйцэтгэх агаарын хөлөг;
  - 4.2. тухайн агаарын хөлгийн навигацийн систем;
  - 4.3. урьдчилан төлөвлөгдөөгүй журмуудыг багтаасан, нислэгт хэрэглэгдэх журам, горимууд;
- 5/ агаарын хөлгийн дарга нь, RNP нислэгт ашиглах агаарын хөлөг, түүний навигацийн систем ИНЕГ-аар батлагдсан, RNP-ийн үзүүлэлт нь төлөвлөсөн агаарын зам болон нөөц агаарын замд тохирно гэдгийг баталгаажуулсан байх;
- 6/ ICAO-гийн стандарт нислэгийн төлөвлөгөөний 10-рт бичигдсэний дагуу нислэгийн төлөвлөгөөнд дараахь тэмдэглэгээг хийж зохих НХҮ-ний байгууллагад хүргүүлсэн байх:
  - 6.1. RNP нислэгт зөвшөөрөгдсөн агаарын хөлөгт 'R' тэмдэглэгээ;
  - 6.2. зөвшөөрөгдсөн GNSS-ээр тоноглогдсон агаарын хөлөгт 'G' тэмдэглэгээ.

(б) Агаарын хөлөг ашиглагч нь RNP нислэгт мөрдөх журам, зааврыг ажлын үндсэн байрандаа хадгалж, ИНЕГ-аас шаардсан үед шалгуулна.

(в) RNP нислэгт мөрдөх зааврыг батлуулах, эсхүл батлагдсан зааварт өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргаж буй этгээд нь уг заавар, эсхүл өөрчлөлтийн төслийг ИНЕГ-т хүргүүлнэ.

(г) RNP нислэгт мөрдөх заавар болон түүнд оруулах аливаа өөрчлөлтийг ИНЕГ-ын дарга батална.

(д) RNP нислэг гүйцэтгэх зааварт дор дурдсан зүйлүүд багтсан байна:

- 1/ ашиглагчийн нэр;
- 2/ RNP нислэгт ашиглаж буй агаарын хөлгийн бүртгэл, төрөл, маяг;
- 3/ агаарын хөлгийн навигацийн системийн төрөл, маяг болон үйлдвэрлэгч;
- 4/ дараах журмуудыг агуулсан техник үйлчилгээний хөтөлбөр:
  - 4.1 RNP нислэгт ашиглах, энэ дүрмийн 91.519-д шаардсан хэрэглэл, тоног төхөөрөмжид хийх үзлэг, шалгалт;
  - 4.2 техник үйлчилгээний тэмдэглэл, огноо, нисэн гарах ба очих буудал, хэрэглэл болон тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийн улмаас RNP нислэг тасалдсан шалтгаан;
- 5/ дараах зүйлүүдэд хамаарах журам, зааврууд:
  - 5.1 тоног төхөөрөмжийн эвдрэл, эсхүл ашиглалтын улмаас гарч болзошгүй навигацийн их хэмжээний алдааг багасгах аргачлал;
- 6/ НХУ-аас зөвшөөрсөн замаас санамсаргүй хазайхаас сэргийлэх үүднээс, навигацийн алдаа гарсан эсэхийг тогтоох зорилгоор харьцуулан шалгалт хийх журмыг багтаасан нислэгийн үед мөрдөх журмууд;
- 7/ RNP гэж тогтоогдсон агаарын зайд нисэх үед RNP-ийн шаардлагатай үзүүлэлтийг хадгалахын тулд навигацийн системийн хэрэглэлийн заалтыг сэргээх;
- 8/ RNP системийн, RNP агаарын зайд зөвшөөрөгдөх максимум хазайлт;
- 9/ RNP-ийн шаардлагад нийцэх цагийн хязгаарлалтын тооцоо;
- 10/ хэрэглэл, тоног төхөөрөмжийн гэмтлийг анхааруулах систем;
- 11/ системийн гэмтэл, саатал;
- 12/ найдвартай ажиллагааны болон өгөгдлийн үзүүлэлтийг цуглуулах, хянах систем;
- 13/ ИНЕГ-аас шаардлагатай гэж үзсэн бусад журам, заавар, хязгаарлалт.

(е) Энэ зүйлийн (а), (б), (в) болон (д)-д шаардсан журам, заавар нь ИНД-119-ийн дагуу Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт багтсан байж болно.

(ж) Агаарын хөлгийн дарга нь:

- 1/ хоёр тусдаа ажиллагаа бүхий Алсын зайн навигацийн систем нь /LRNS/ найдвартай, өндөр нарийвчлалтай ажиллаж байгаа эсэхийг нислэгийн дор дурьдсан үе шатуудад баталгаажуулна:
  - 1.1 тогтоосон RNP агаарын зайд орохоос 30 минутын өмнө;
  - 1.2 тогтоосон RNP агаарын зайд орох үед.
- 2/ тогтоосон RNP агаарын зайд нэвтрэхээс 30 минутын өмнө, эсхүл уг агаарын зайд нислэг үйлдэж байгаа үед:
  - 2.1. тухайн агаарын хөлөг RNP шаардлагыг хангах боломжгүй тохиолдолд НХУ-д мэдэгдэнэ;
  - 2.2. тухайн агаарын хөлөг нь нэг LRNS-тэй нислэг үйлдэж буй үед НХУ-д мэдэгдэнэ
  - 2.3. НХУ-тай холбоо барих боломжгүй бол, Бүс нутагт мөрдөх нэмэгдэл журам "ICAO Regional Supplementary Procedures, Doc 7030"-ын дагуу ажиллана.

**Г БҮЛЭГ. ИЛ ХАРААНЫ НИСЛЭГИЙН ДҮРЭМ****91.301. Ил харааны нислэгийн цаг агаарын хязгаарлалт**

(а) Энэ дүрэмд зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлгийн дарга нь дор дурдсан нөхцөлд ил харааны нислэгийн дүрмээр нислэг үйлдэхгүй:

- 1/ алсын барааны харагдац, агаарын хөлгөөс үүл хүртэлх зай нь Хүснэгт 4-т заасан агаарын зайн зохих ангилалд заасан хэмжээнээс бага бол;
- 2/ далайн дундаж түвшнээс 6150 м- ээс дээш нислэгийн өндрийн цуваачлалд;
- 3/ нар ургаснаас хойш тэгш тал газарт нар шингэхээс 30 минутын өмнө, дов толгод уулагхаг газарт нар шингэх хүртэл.

(б) Алсын барааны харагдац, үүлний доод суурийн өндөр нь энэ дүрмийн хүснэгт 4-т зааснаас бага байвал агаарын хөлгийн дарга ИХНД-ээр хөөрөх, буух, аэродромын тойрог нислэгийн хөдөлгөөнд орох, эсвэл аэродромын ойролцоо нислэг үйлдэхгүй.

(в) Агаарын хөлгийн дарга нь дор дурдсан тохиолдолд нислэг үйлдэж болно:

- 1/ бусад агаарын хөлөг, эсвэл аливаа саадтай мөргөлдөхөөс зайлсхийх зорилгоор тэдгээрийг ажиглаж илрүүлэх бололцоотой хурдтайгаар маневр хийж байвал нисдэг тэрэгний дарга G ангиллын агаарын зайд, алсын барааны харагдац 5 км-ээс багагүй үед;
- 2/ хөдөө аж ахуйн зориулалттай нислэг үйлдэж байгаа тохиолдолд агаарын хөлгийн дарга нь G ангиллын агаарын зайд, алсын барааны харагдац 5 км-ээс багагүй үед;
- 3/ нислэгийн сургалт, дадлага өгч байгаа тохиолдолд агаарын хөлгийн дарга нь алсын барааны харагдац 5 км-ээс багагүй үед нам өндрийн нислэгт.

**Хүснэгт 4. ИХНД-ийн цаг агаарын хязгаарлалт**

<b>Агаарын зайн ангилал</b>	<b>C, D, E</b>	<b>G</b>
Үүл хүртэлх зай	Хэвтээ чиглэлд 2 км, Босоо чиглэлд 300 м	Далайн дундаж төвшнөөс дээш 1200 м, эсхүл газрын гадаргуугаас 300м-ээс дээш үед аль ихээр нь хэвтээ чиглэлд 2 км, босоо чиглэлд 300 м, үүлгүй, газрын гадаргуу харагдаж байх үед Далайн дундаж төвшнөөс дээш 1200 м буюу түүнээс доош, эсхүл газрын гадаргуугаас дээш 300 м-ийн аль ихээр нь.
Алсын барааны харагдац	Далайн дундаж төвшнээс дээш 3000 м буюу түүнээс дээш өндөрт 8 км; Далайн дундаж	5 км

	төвшнөөс дээш 3000м-ээс доош өндөрт 5 км.	
--	--	--

**91.303. Нөөц****91.305. Ил харааны нислэгт шаардлагатай шатахуун**

(а) Цаг агаарын урьдчилсан мэдээллээр нислэг явагдах өндрийн салхийг тооцож төлөвлөсөн нислэгийн хурдтайгаар эхний буудалд нисэн очсоноос хойш 45 минутаас багагүй хугацаанд нисэхэд хангалттай шатахуунгүй бол уг агаарын хөлгийн дарга ИХНД-ээр нислэг үйлдэхгүй.

(б) Эхний буудал хүртэл цаг уурын урьдчилсан мэдээллээр төлөвлөсөн нислэгийн хурдтайгаар нисэхэд хүрэлцэхүйц шатахуунгүй, мөн дор дурдсан нөхцөлийг хангаагүй бол уг нисдэг тэрэгний дарга ИХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- 1/ эхний цэгт нисэн очсоноос хойш 30 минутаас доошгүй хугацаанд нисэхэд хүрэлцэх шатахуунгүй бол;
- 2/ нислэгийн үргэлжлэх хугацаа 45 минутаас бага бол нисэн очих эхний цэгээс хойш төлөвлөсөн нислэгийн цагтай тэнцэх хугацаанд нисэхэд хүрэлцэхүйц шатахуунгүй бол.

**91.307. Нөөц****91.309. Байрлал илтгэх**

(а) Ил хараагаар нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь удирдлагатай агаарын зайд нислэг үйлдэхэд НХУ-аас шаардсан, тогтоосон цэгүүдийг нисэн өнгөрөхөд НХУ-д мэдээлнэ.

**91.311. Ил харааны нислэгийн аюулгүй өндөр**

(а) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд, ИХНД-ээр нислэгийг үйлдэхгүй:

- 1/ хүн ам шигүү суурьшсан хот, суурин дээгүүр, эсвэл хүмүүс олноор цугларсан бүс нутаг дээрхи агаарын зайд, тухайн агаарын хөлгөөс 600 метрийн хэвтээ радиус доторх хамгийн өндөр саадаас дээш 300 м-ээс нам өндөрт ;
- 2/ бусад аль нэг бүс нутгийн дээгүүр:
  - 2.1 газрын гадаргуугаас дээш 150 м-ээс нам өндөрт;
  - 2.2 аль нэг саад, машин механизм, барилга байгууламж, хүмүүсээс 150 метрийн хэвтээ радиус доторх 150 м-ээс нам өндөрт.
- 3/ хөдөлгүүрт эвдрэл, гэмтэл гарсан үед газар дээр байгаа хүмүүс болон эд зүйлд аюул учруулахгүй буулт үйлдэхэд шаардагдах өндрөөс нам өндөрт;

(б) Энэ зүйлийн (а) нь дор дурдсан агаарын хөлгийн даргад хамаарахгүй:

- 1/ хөөрөлт, буулт үйлдэж буй агаарын хөлөг;
- 2/ явгалж байгаа;
- 3/ хоёрдугаар тойрогт гарч байгаа, эсхүл ойртолтыг үргэлжлүүлэх боломжгүй болсон агаарын хөлөг.



(в) Энэ зүйлийн (а)-гийн 2/ нь энэ заалтаас нам өндөрт нисэх шаардлагатай агаарын хөлгөөр дор дурдсан нөхцөлд нислэг үйлдэж буй агаарын хөлгийн даргад хамаарахгүй:

- 1/ тухайн нам өндрийн нислэгийг газар дээр байгаа хүмүүс болон эд зүйлд аюул учруулахгүйгээр үйлдэж байвал;
- 2/ тухайн нам өндрийн нислэгийн үйл ажиллагаанд шууд холбогдох хүмүүсийг тээвэрлэж байвал;
- 3/ нислэг нь шаардагдах өндрөөс багагүй нисэж байгаа бол
- 4/ агаарын хөлөг нь тухайн нислэгийн үйл ажиллагаанд үл хамаарах аливаа этгээд, машин техник, гадны биетээс 150 м-ийн хэвтээ радиусын гадна байвал.

(г) Энэ зүйлийн (а)-гийн 2/ нь дор дурдсан агаарын хөлгийн даргад хамаарахгүй:

- 1/ ИНД-61-ийн дагуу багш нисгэгчийн хүчин төгөлдөр зэрэглэл эзэмшигч нь сургалт, дадлагын зорилгоор дор дурдсан нислэг үйлдэж байвал:
  - 1.1 газрын гадаргуугаас дээш 300 м-ээс нам өндөрт эхэлсэн хөөрөлтийн дараахь хөдөлгүүрийн дууриамал гэмтэл, дутагдал;
  - 1.2 газрын гадаргуугаас 300 м-ээс дээш өндөрт эхэлсэн хөдөлгүүрийн дууриамал гэмтэлтэй, 91.131-д заасны дагуу нам өндрийн нислэгийн бүсэд 150 м-ээс доош өндөр алдалтыг гүйцэтгэж байвал.
- 2/ ИНД-61-ийн дагуу хэрэглэлийн нислэгийн зэрэглэл эзэмшигч нь ХНД-ээр сургалт, шалгалт, эсхүл ИХНД-ээр дадлагын нислэгийг 91.413, 91.423, 91.425-д заасны дагуу үйлдэж байвал;
- 3/ 91.703-т заасан үзүүлэх нислэгт оролцож байгаа агаарын хөлгийн дарга.

### **91.313. Ил харааны нислэгийн үнэмлэхүй өндөр ба өндрийн цуваачлал**

(а) Монгол Улсын агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь, НХУ-ний байгууллагаас өөрөөр зөвшөөрөл олгоогүй бол, дор дурьдсан үнэмлэхүй өндөр буюу нислэгийн өндрийн цуваачлалыг баримтална:

- 1/ тухайн агаарын замд мөрдөх доод цувааны өндрөөс дээш, 1013.25 гПа-ын (760.0 мм.муб) түвшингээр хэмжигдэх 6000 м ба түүнээс доош өндрийн цуваанд:
  - 1.1 Соронзон чиглэлийн 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, 1500 м-ээс эхлэн 600 м-ээр ихсэх 5700м хүртэлх сондгой тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа (1500, 2100, 2700 г.м);
  - 1.2 Соронзон чиглэлийн 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, 1800 м-ээс эхлэн 600 м-ээр ихсэх 6000м хүртэлх тэгш тоотой зуут бүхий нислэгийн өндрийн цуваа (1800, 2400, 3000 г.м ).

(б) Монгол Улсын агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь НХУ-аас өөрөөр зөвшөөрөөгүй бол, аэродромын шилжих үнэмлэхүй өндөр болон шилжих цувааны хоорондох өндөрт байвал чиг шулуун нислэг үйлдэхгүй.

(в) НХУ-аас өгсөн зөвшөөрлийн дагуу хүлээх бүсэд нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт энэ зүйлийн (а), (б) хэсэг хамаарахгүй.

(г) Агаарын хөлгийн дарга нь:

- 1/ тухайн аэродромд тогтоогдсон шилжих өндрөөс дээш өндөр авах үед өндөр хэмжигчийг 1013.25 гПа-д (760.0 мм.муб) тохируулна;
- 2/ тухайн аэродромд тогтоосон шилжих цуваанаас доош өндөр алдах үед, өндөр хэмжигчийг тухайн аэродромын QNH, эсхүл QFE-д тохируулна.

**91.315. Цас, мөстэй үед тавигдах шаардлага**

(а) Агаарын хөлгийн далавч, стабилизатор, эсхүл удирдлагын гадаргууд цас, мөс, цан тогтсон үед агаарын хөлгийн дарга ИХНД-ээр хөөрөлт үйлдэхийг хориглоно.

**Д БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛИЙН НИСЛЭГИЙН ДҮРЭМ****91.401. Нисэх багийн гишүүдийн тоо**

(а) Агаарын хөлгийн дарга нь дараах тохиолдолд хамтран нисгэгчгүйгээр ХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- 1/ тухайн агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт зөвшөөрөөгүй бол;
- 2/ холбооны тоног төхөөрөмжийг агаарын хөлгийн жолоодлогоос хөндийрэхгүйгээр нислэгийн үед ашиглах боломжгүй бол.

**91.403. Хэрэглэлийн нислэгийн үед шаардлагатай шатахуун**

(а) Аливаа этгээд нь энэ дүрмийн б)-д зааснаас бусад нөхцөлд, ХНД-ээр нисэхэд (цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээлэлийг харгалзан) дор зааснаас бага шатахуунтайгаар агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- 1/ буулт үйлдэхээр төлөвлөсөн эхний аэродром дээр нисэн ирэхэд хангалттай;
- 2/ уг аэродромоос бэлтгэл аэродром хүртэл нисэхэд хангалттай;

3/ онгоц болон нисдэг тэрэг бэлтгэл аэродромоос дээш 600 м (2000ft)-ийн өндөрт хүлээх бүсэд 30 минут нисэх.

(б) Энэ зүйлийн (а)-ийн 2/ заалт нь дараах нөхцөлд хамаарахгүй:

- 1/ буулт үйлдэхээр төлөвлөсөн эхний аэродром нь ИХНД-95-ын дагуу ХНД-ээр ойртолт үйлдэх стандарт журам тогтоогоогүй бол;
- 2/ буулт үйлдэхээр төлөвлөсөн эхний аэродромын цаг агаарын нөхцөл нь нисэн ирэх тооцоот цагаас 1 цагийн өмнө ба хойно ИХНД-ээр нислэг үйлдэхэд тохирч байвал.

**91.405. ХНД-ээр үйлдэх нислэгийн нөөц аэродромд тавигдах шаардлага**

(а) Дор дурдсан тохиолдолд ХНД-ээр нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн дарга нэгээс доошгүй нөөц аэродромыг сонгоно:

- 1/ нислэгийн төлөвлөгөөгөөр буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродром нь хэрэглэлээр ойртолт, буулт үйлдэх стандарт журамгүй бол;
- 2/ нислэгийн төлөвлөгөө өгөх үед цаг агаарын урьдчилсан мэдээ нь буулт үйлдэхээр төлөвлөсөн аэродромд нисэн очихоор тооцоолсон хугацаанаас нэг цагийн өмнө ба хойно дор дурдсан нөхцөлд тохирохгүй бол:
  - 2.1 нисэн очихоор төлөвлөж буй аэродром дээрх үүлний өндөр нь тухайн ойртолт үйлдэхээр төлөвлөсөн хязгаарлалтаас дээш 300 м-ээс багагүй байх;
  - 2.2 алсын барааны харагдац 5 км-ээс багагүй, эсхүл тухайн аэродромын алсын барааны харагдацын хязгаарлалтаас 2км-ээр их байх тохиолдлын аль ихийг нь сонгоно.

(б) Нислэгийн төлөвлөгөөг өгөх үед цаг агаарын урьдчилсан ба бодит мэдээгээр нөөц аэродром дээрх үүлний өндөр, алсын барааны харагдац нь уг аэродромд нисэн

очих тооцоолсон цагт дор дурдсан цаг агаарын хязгаарлалтад тохирохгүй бол агаарын хөлгийн дарга уг аэродромыг нөөц аэродромоор сонгохгүй:

- 1/ тухайн аэродромыг нөөц буудлаар сонгоход тусгайлан тогтоосон цаг агаарын хязгаарлалт;
- 2/ цаг агаарын хязгаарлалт нь:
  - 2.1 нарийвчлалтай /ILS/ ойртолт, буултын хувьд үүлний доод суурийн өндөр 200 м, эсхүл шийдвэр гаргах өндрөөс 60м (200 фут)-ийн аль ихээр нь, алсын барааны харагдац 3000 м, эсхүл аэродромын хязгаарлалтаас 1000м-ийн аль ихээр нь хязгаарлалтыг баримтална;
  - 2.2 нарийвчлалтай бус ойртолт, буултын хувьд, үүлний доод суурийн өндөр 300 м /1000 фут/, эсхүл доошилж болох өндөр /MDA/-өөс дээш 100 м /300 фут/-ийн аль өндөр нь ба алсын барааны харагдац 4000 м, эсхүл тогтоогдсон хязгаарлалтаас 1500 метрээр их байх тохиолдлын аль ихээр нь тогтоосон хязгаарлалт;
- 3/ тухайн нөөц аэродромд хэрэглэлийн нислэгээр ойртолт, буулт үйлдэх журмыг тогтоогоогүй бол 91.423-ын заалтын дагуу аюулгүй нам өндрөөс доош өндөр алдахад Г. Бүлэгт заасан ИХНД-ийн үед мөрдөх үүлний өндөр ба алсын барааны харагдацын хязгаарлалтаас бага бол.

(в) Нөөц аэродром нь дараахь төхөөрөмжийг хангах нөөц цахилгаан хангамжаар тоноглогдоогүй бол агаарын хөлгийн дарга нь энэ зүйлийн (а)-д заасны дагуу аливаа аэродромыг нөөц аэродромоор сонгохгүй:

- 1/ ойртолт үйлдэх газрын навигацийн тоног төхөөрөмж цахилгааны тэжээлгүй бол;
- 2/ шөнийн нислэгт аэродромын шөнийн гэрэлтүүлэггүй бол.

#### **91.407. Нөөц**

#### **91.409. Нислэгийн төлөвлөгөөг дагаж мөрдөх**

(а) Хэрэглэлээр нисэх нислэгийн төлөвлөгөөг хүргүүлсэн үед агаарын хөлгийн дарга, дор дурьдсанаас бусад үед нислэгийн хүчин төгөлдөр төлөвлөгөөг дагаж мөрдөнө:

- 1/ өөрчлөлт оруулах тухай хүсэлт гаргаагүй бөгөөд НХУ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол;
- 2/ нислэгийн төлөвлөгөөг яаралтай өөрчлөх онцгой нөхцөл байдал бий болоогүй бол.

(б) ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь:

- 1/ Нисэхийн мэдээлэлийн эмхэтгэл (AIP)-д заасан агаарын замаар нисэхээр төлөвлөсөн бол уг тогтоосон агаарын зам дагуу нислэг үйлдэнэ;
- 2/ бусад агаарын замаар нислэг үйлдэхээр төлөвлөсөн бол навигацийн төхөөрөмж болон уг агаарын замын дагуух цэгүүдийг холбосон шугамаар нислэг үйлдэнэ;
- 3/ агаарын замтай зэрэгцээ шугамаар нислэг үйлдэхээр төлөвлөсөн бол, НХУ-ний байгууллагын зөвшөөрлийн дагуу нислэг үйлдэнэ.

(в) Энэ зүйлийн (а)-гийн 2/-т зааснаар нислэгийн төлөвлөгөөг өөрчлөх шаардлагатай бол агаарын хөлгийн дарга зохих НХУ-ний байгууллагад аль болох хурдан хугацаанд мэдэгдэнэ.

**91.411. Нислэгийн төлөвлөгөө өөрчлөгдөх**

(а) Мөрдөж буй нислэгийн төлөвлөгөө нь өөрчлөгдсөн тохиолдолд, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь:

1/ НХҮ-ний байгууллагад дор дурдсан зүйлийг мэдээлнэ:

- 1.1 маршрутад гарсан аливаа өөрчлөлт;
- 1.2 нислэгийн төлөвлөгөөнд өгөгдсөн жинхэнэ хурдны 5% буюу эсвэл тоогоор илэрхийлэгдэх дууны хурд (MAX) тооны +0.01 ба түүнээс илүү гарсан өөрчлөлт;
- 1.3 НХҮ-ний байгууллагад мэдээлсэн, дараагийн төлөвлөсөн цэгийг нисэн өнгөрөх тооцоолсон цагт 2 минутаас их алдаа гарсан тохиолдолд, түүнийг засаж шинэчилсэн тооцоот цаг.

2/ шинэ маршрутын замд аль болох хурдан орох .

**91.413. ХНД-ээр хөөрөх, буух**

(а) **Аэродромд хэрэглэлээр ойртолт, буулт үйлдэх.** Аливаа аэродромд ХНД-ийн дагуу ойртолт, буулт үйлдэх шаардлагатай гэж үзвэл агаарын хөлгийн дарга нь тухайн аэродромд ойртолт, буулт үйлдэх хэрэглэлийн нислэгийн стандарт журмыг ашиглана.

(б) **Зөвшөөрөгдсөн DA, DH, ба MDA.** Энэ зүйлийн (а)-д заасан ХНД-ийн дагуу ойртолт, буулт үйлдэх журамд шийдвэр гаргах үнэмлэхүй өндөр /DA/, шийдвэр гаргах харьцангуй өндөр /DH/, эсхүл доошилж болох хамгийн бага өндөр /MDA/-үүдийн аль нэгийг ашиглах агаарын хөлгийн дарга нь дор дурдсан DA, DH, эсхүл MDA -ийн аль ихийг нь ашиглана:

- 1/ тухайн аэродромд ХНД-ээр ойртолт, буулт үйлдэх журамд тусгасан DA, DH эсхүл MDA;
- 2/ агаарын хөлгийн даргын DA, DH, эсхүл MDA;
- 3/ тухайн агаарын хөлгийн DA, DH эсхүл MDA.

(в) **DA, DH буюу MDA-аас доош үйлдэх нислэг.** Агаарын хөлгийн дарга аливаа аэродром дээр DA, DH буюу MDA-г хэрэглэж байгаа тохиолдолд дор дурдсанаас бусад нөхцөлд MDA-аас доош буюу (б)-д заасан DA, DH-аас доош өндөрт ХНД-ээр нислэгийг үргэлжлүүлэхгүй:

- 1/ агаарын хөлөг нь хэвийн маневраар, доошлолтын хэвийн босоо хурдтайгаар өндөр алдаж, хөөрч буух зурвасны газардах бүсэд бууж болохоор тохирч байвал;
- 2/ алсын барааны харагдац нь ХНД-ийн дагуу ойртолт, буулт үйлдэх журамд заасан алсын барааны харагдацаас их байвал;
- 3/ CAT II буюу CAT III-аар ойртолт, буулт үйлдэх журмаас бусад тохиолдолд уг аэродромд ил харааны баримжаа авахад зориулсан дараах тэмдэгтүүдийн аль нэг нь нисгэгчид тод харагдаж танигдахгүй бол:
  - 3.1 ойртолтын гэрлүүд; эсхүл
  - 3.2 босгоны тэмдэглэгээ; эсхүл
  - 3.3 босгоны гэрлүүд; эсхүл
  - 3.4 зурвасны төгсгөл хэсгийн гэрлүүд; эсхүл
  - 3.5 ойртолтын налууг ил хараагаар тодорхойлох гэрэл /VASI, PAPI/; эсхүл
  - 3.6 газардах бүс буюу газардах бүсийн тэмдэглэгээ; эсхүл
  - 3.7 газардах бүсийн гэрлүүд; эсхүл
  - 3.8 хөөрч буух зурвас буюу түүний тэмдэглэгээ; эсхүл
  - 3.9 хөөрч буух зурвасны гэрлүүд.

(г) **Буулт.** Алсын барааны харагдац нь ХНД-ийн дагуу ойртолт, буулт үйлдэх журамд заасан утгаас бага байвал агаарын хөлгийн дарга буулт үйлдэхгүй.

(д) **2-р тойрогт гарах журам.** Агаарын хөлгийн дарга нь 2-р тойрогт гарах журмыг дараахь тохиолдолд дагаж мөрдөнө:

- 1/ энэ зүйлийн (в)-д заасан шаардлага хангагдаагүй бол:
  - 1.1 агаарын хөлөг MDA-ээс доош өндөрт нисэх үед; эсхүл
  - 1.2 шийдвэр гаргах өндөрт /DA, DH/, тэдгээрийг ашиглаж 2 дугаар тойрогт гарах цэгт (MAP) ирэх үед, мөн түүний дараа газардах хүртэл.
- 2/ MDA буюу түүнээс дээш өндөрт эргэлтийн маневр хийж байхад уг аэродромын тодорхой хэсгүүд нь нисгэгчид ил, тод харагдахгүй байвал.

(е) **Хөөрөлтийн цаг агаарын хязгаарлалт.** Энэ зүйлийн (ж)-д зааснаас бусад тохиолдолд болон цаг агаарын дараахь нөхцөл бүрдээгүй бол агаарын хөлгийн дарга нь ХНД-ээр хөөрөлт үйлдэж болохгүй:

- 1/ цаг агаарын нөхцөл нь тухайн аэродромын хувьд ХНД-ээр хөөрөлт үйлдэх журамд заасан цаг агаарын хязгаарлалтаас дээш байх;
- 2/ хэрэв ХНД-ээр хөөрөлт үйлдэхэд тохирох цаг агаарын хязгаарлалтыг тухайн аэродромд тогтоогоогүй бол, үүлний өндөр 100 м-ээс доошгүй, алсын барааны харагдац 1500 м-ээс багагүй байх

(ж) **Хөөрөлтөд багасгасан цаг агаарын хязгаарлалт хэрэглэх.** Дараах нөхцөл бүрдсэн үед агаарын хөлгийн дарга аль нэгэн аэродромоос үүлний өндрийг үл харгалзан алсын барааны харагдац 800 м буюу түүнээс дээш байхад ХНД-ээр хөөрөлт үйлдэж болно:

- 1/ хөөрч буух зурвасны голын шугам нь тэмдэглэгээ буюу гэрэлтүүлэгтэй байвал; эсхүл
- 2/ хөөрч буух зурвасны голын шугамны тэмдэглэгээ буюу гэрэлтүүлгийг ажигласны үндсэн дээр агаарын хөлгийн дарга алсын барааны харагдацыг баталгаажуулсан бол;
- 3/ тухайн хөөрч буух зурвасанд хөөрөлтийн багасгасан хязгаарлалт хэрэглэхийг зөвшөөрсөн бол;
- 4/ хөөрөлтийн замд байгаа саадыг анхааралдаа авсан бол;
- 5/ хэрэв агаарын хөлөг нь сэнст хоёр хөдөлгүүртэй онгоц бөгөөд автофлюгерийн ажиллагаа бүхий системээр тоноглогдсон бол.

#### **91.415. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх журам**

(а) Аливаа этгээд дараахь нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд CAT II, эсхүл CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэхгүй:

- 1/ нисэх багийн гишүүн бүр тухайн агаарын хөлөг болон ажиллах журмын талаар зохих мэдлэггүй буюу тэдгээртэй бүрэн танилцаагүй бол;
- 2/ агаарын хөлгийг удирдаж буй нисгэгчийн өмнөх нислэгийг хянах самбар нь тохирсон хэрэглэлгүй бол;

(б) ИНЕГ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, тухайн нислэгийн үйл ажиллагаанд шаардагдах газрын болон агаарын хөлгийн тоног төхөөрөмжүүд суурилуулаагүй, эсхүл

ажиллагаагүй байвал аливаа этгээд CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэж болохгүй.

(в) Зөвшөөрөгдсөн DH. Энэ дүрмийн зорилго нь, нарийвчлалтай ойртолт үйлдэх журамд DH-ийг ашиглах шаардлагатай гэж заасан бол дор дурдсан зөвшөөрөгдсөн DH-ийг хэрэглэнэ:

- 1/ тухайн аэродромд ХНД-аар ойртолт, буулт үйлдэх журамд заасан DH; эсхүл
- 2/ агаарын хөлгийн даргад зориулсан DH; эсхүл
- 3/ зохих төхөөрөмжөөр тоноглогдсон агаарын хөлөгт зориулсан DH;

(г) ИНЕГ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, DH-ийг ашиглах шаардлагатай CAT II, эсхүл CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэж буй нисгэгч нь дор дурдсан шаардлагыг хангаагүй байвал зөвшөөрөгдсөн DH-аас доош ойртолтыг үргэлжлүүлж болохгүй:

- 1/ агаарын хөлөг нь хэвийн маневраар, доошлолтын хэвийн босоо хурдтайгаар өндөр алдаж, хөөрч буух зурвасны газардах бүсэд бууж болохоор тохирч байвал;
- 2/ хөөрч буух зурвасны дор дурдсан ил харааны баримжаа тогтоох тэмдэгтээс аль нэг нь нисгэгчид тод харагдаж танигдахуйц байх ёстой:
  - 2.1 хөөрч буух зурвасны босго;
  - 2.2 хөөрч буух зурвасны босгоны тэмдэглэгээ;
  - 2.3 хөөрч буух зурвасны босгоны гэрэлтүүлэг;
  - 2.4 хөөрч буух зурвасны газардах бүсийн тэмдэглэгээ;
  - 2.5 хөөрч буух зурвасны газардах бүсийн гэрэлтүүлэг.

(д) ИНЕГ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, энэ зүйлийн (г)-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд нисгэгч, газардахаас өмнө 2-р тойрогт яаралтай гарна.

(е) ИНЕГ-аас зөвшөөрөл олгогдоогүй агаарын хөлгөөр аливаа нисгэгч нь DH-гүй CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэхгүй.

#### **91.417. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх заавар**

(а) Дор дурдсан нөхцөлд Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр аливаа этгээд CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэхгүй:

- 1/ уг агаарын хөлөгт дараах зааврууд байхгүй бол:
  - 1.1. 91.419-т заасны дагуу баталсан CAT II хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх үед тухайн агаарын хөлгөөр нислэг үйлдэх хүчин төгөлдөр заавар; эсхүл
  - 1.2. 91.419-т заасны дагуу баталсан CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх үед тухайн агаарын хөлгөөр нислэг үйлдэх хүчин төгөлдөр заавар.
- 2/ батлагдсан журам, хязгаарлалтын дагуу CAT II буюу CAT III хязгаарлалтаар ойртолт, буултыг үйлдэнэ.
- 3/ батлагдсан зааварт тусгасан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу, CAT II, CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх шаардлагатай хэрэглэл, тоног төхөөрөмжид үзлэг, үйлчилгээ хийнэ.

(б) CAT II буюу CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх агаарын хөлгийг ашиглагч байгууллага нь үйл ажиллагаа явуулж буй үндсэн байрандаа батлагдсан

зааврын хүчин төгөлдөр хувийг хадгалж, үзэж шалгах зорилгоор ИНЕГ-аас шаардсан үед бэлэн байлгана.

(в) Энэ зүйлийн (а), (б)-д шаардсан зааврыг ИНД-119-ийн дагуу Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны заавартай нэгтгэж болно.

**91.419. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх зааврыг батлах**

(а) CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх зааврыг батлуулахаар буюу батлагдсан зааварт нэмэлт өөрчлөлт оруулахаар өргөдөл гаргаж буй этгээд нь уг заавар буюу өөрчлөлтийн төслийг ИНЕГ-т хүргүүлнэ.

(б) Хэрэв өргөдөл гаргагч нь CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт, буултын үзүүлэх нислэг үйлдэх тохиолдолд өргөдөлд дараахь зүйлийг тусгасан байна:

- 1/ агаарын хөлгийн байрлал, үзүүлэх нислэг үйлдэх газар;
- 2/ үзүүлэх нислэг эхлэх өдөр.

(в) CAT II, эсхүл CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх зааварт дор дурдсан зүйлийг багтаасан байна :

- 1/ тухайн зааварт хамаарагдах агаарын хөлгийн бүртгэл, маяг загвар;
- 2/ дараахь үйл ажиллагааны журмыг багтаасан Техник үйлчилгээний хөтөлбөр:
  - 2.1 CAT II буюу CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэхэд хэрэглэгдэх бүх хэрэглэл, тоног төхөөрөмжид 3 сар тутамд хийх үзлэг, шалгалт;
  - 2.2 CAT II буюу CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэхэд хэрэглэгдэх бүх хэрэглэл, тоног төхөөрөмжид 12 сар тутамд хийх лабораторийн шалгалт;
  - 2.3 ИНД-43-т заасны дагуу бүх статик даралтын системд 12 сар тутамд хийх үзлэг, шалгалт;
  - 2.4 техник үйлчилгээ хийсэн өдөр, нисэх буудал, хэрэглэл буюу тоног төхөөрөмжийн алдааны улмаас CAT II буюу CAT III хязгаарлалтаар ойртолт, буулт үргэлжлэх боломжгүй болсон талаарх тайлан, тэмдэглэл;

3/ дараах зүйлсэд хамаарах журам, зааварчлагууд:

- 3.1 шийдвэр гаргах өндрийг хүлээн зөвшөөрөх;
- 3.2 зурвасны дагуух харагдац /RVR/-ын мэдээллийг ашиглах;
- 3.3 ойртолтыг хянах;
- 3.4 шийдвэр гаргах бүсэд ILS-ын заалтад зөвшөөрөгдсөн хазайлтын хамгийн их хязгаар;
- 3.5 2 дугаар тойрогт явах;
- 3.6 нам өндрийн нислэгийн тоног төхөөрөмжийг ашиглах;
- 3.7 автопилотыг ашиглахад зөвшөөрөгдөх аюулгүй нам өндөр ;
- 3.8 хэрэглэл болон тоног төхөөрөмжийн алдааг анхааруулах систем;
- 3.9 хэрэглэлийн эвдрэл, гэмтэл;
- 3.10 шаардлагатай гэж үзсэн бусад журам, заавар, хязгаарлалт.

(г) Энэ зүйлийн (в)-ийн 2/-ын 2.1-ийг үл харгалзан, нислэгт шалгах ажиллагаа нь шалгалтын бусад хувилбарыг орлож болох ба энэ үед техник үйлчилгээний хөтөлбөрт уг шалгах нислэгийг гүйцэтгэсэн журам болон энэ талаарх бүртгэл, тэмдэглэлийг багтаасан байна.

**91.421. Мөстөлттэй үед нислэг үйлдэх**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь тухайн агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- 1/ хөөрөлт үйлдэхэд:
  - 1.1 сэнс, цонхны урд шил, хөдөлгүүрийн агаар орох хэсэг, эсхүл хурд болон өндрийн хэрэглэлд хамаарах систем, өндөр авах босоо хурд буюу авиагоризонтын системд цас, мөс тогтсон буюу цантсан байвал; эсхүл
  - 1.2 далавч, стабилизатор буюу удирдлагын гадаргууд цас, мөс тогтсон буюу цантсан байвал хөөрөлт үйлдэхгүй.
- 2/ тухайн агаарын хөлөг нь мөстөлтөөс хамгаалах төхөөрөмжгүй бол, мэдэгдэж байгаа буюу урьдчилсан мэдээгээр мөстөлттэй бүсэд нислэг үйлдэхгүй.

(б) Тухайн агаарын хөлгөөр цас, мөс, цанталттай үед хөөрөлт үйлдэж болох нь үйлдвэрлэгчээс зөвшөөрөгдсөн, мөн үйл ажиллагааны журмыг нислэгийн ашиглалтын зааварт нарийвчлан заасан бол ийм нөхцөлд агаарын хөлгийн дарга хөөрөлт үйлдэж болно.

(в) Цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр нислэг мөстөлттэй нөхцөлд явагдах байсан боловч цаг агаарын өөрчлөлтийн улмаас тухайн нислэгийн хугацаанд мөстөлтийн нөхцөл бий болохгүй тухай нислэгийн өмнөх цаг агаарын сүүлчийн мэдээллийг агаарын хөлгийн дарга авсан бол, урьдчилсан нөхцөлд үндэслэсэн энэ зүйлийн (а)-ийн 2/-т заасан хязгаарлалт хамаарахгүй.

#### **91.423. ХНД-д мөрдөх аюулгүй нам өндөр**

(а) Хөөрөлт, буулт үйлдэхээс бусад тохиолдолд, агаарын хөлгийн дарга дор дурдсан өндрөөс доош өндөрт ХНД-ээр нислэг үйлдэхгүй:

- 1/ нислэгийн мэдээлэлийн эмхэтгэл (AIP)-д заасан аюулгүй нам өндрөөс доош бол;
- 2/ хэрэв AIP-д аюулгүй нам өндрийг заагаагүй бол:
  - 2.1 Секторын хамгийн бага үнэмлэхүй өндрийг газрын гадаргуу болон саад нь далайн дундаж төвшнөөс дээш 2000 м хүртэл хамгийн өндөр саадаас дээш аюулгүй өндрийг 300 м, газрын гадаргуу болон саад нь 2001 м-с дээш саадаас дээш аюулгүй өндрийг 600 м-ээс нам өндөрт;
  - 2.2 Агаарын замын дагуу газрын гадаргуу болон саад нь 2000 м хүртэл аюулгүй өндрийг 300 м, газрын гадаргуу болон саад нь 2001 м-с дээш саадаас дээш аюулгүй өндрийг 600 м-ээс нам өндөрт.

#### **91.425. ХНД-ийн үнэмлэхүй өндөр болон өндрийн цуваачлал**

(а) Эрх бүхий байгууллагаас 8900 метрээс 12500 метрийн өндрийн агаарын зайг RVSM агаарын зайгаар тогтоосон, эсвэл зарласан тохиолдолд Монгол Улсын агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь дор дурдсан үнэмлэхүй өндөр буюу нислэгийн өндрийн цуваачлалыг хэрэглэнэ:

- 1/ Монгол улсын нисэхийн мэдээллийн эмхэтгэл (AIP)-д тухайн аэродромын шилжих үнэмлэхүй өндөр болон 1013.25 гПа-ийн (760 мм.муб) түвшингээс дээшхи доод цувааны өндрийн аль ихээр нь 8400 метр, түүнээс доош өндрийн цуваанд:
  - 1.1 Соронзон чиглэлийн 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, 2100 метр, эсвэл газрын гадаргуугаас дээш 900 м-ийн аль их үед 600 метрээр ихсэх 8100 метр хүртэлх сондгой тоотой зуут бүхий үнэмлэхүй өндөр (1500, 2100, 2700 г.м);



1.2 Соронзон чиглэлийн 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, 1800 метр, эсвэл газрын гадаргуугаас дээш 900 м-ийн аль их үед 600 метрээр ихсэх 8400 метр хүртэлх тэгш тоотой зуут бүхий үнэмлэхүй өндөр (1800, 2400, 3000 г.м);

2/ 1013.25 гПа-ийн (760 мм.муб) түвшингээс дээш 8900-12500 метрийн хоорондох өндрийн цуваанд нислэг үйлдэж байвал:

2.1 Соронзон туйлын 360 градусаас цагийн зүүний дагуу 179 градуст, далайн түвшнээс дээш 8900 метрээс эхлэн 600 метрээр ихсэх 12500 метр хүртэл сондгой тоотой зуут бүхий цувааны өндөр;

2.2 Соронзон туйлын 180 градусаас цагийн зүүний дагуу 359 градуст, далайн түвшнээс дээш 9200 метрээс эхлэн 600 метрээр ихсэх 12200 метр хүртэл тэгш тоотой зуут бүхий цувааны өндөр;

3/ 1013.25 гПа-ийн (760 мм.муб) түвшингээс дээш 12500м буюу түүнээс дээш өндөрт 600 м-ийн босоо цуваачлал тогтооно.

(б) НХУ-аас зөвшөөрөөгүй бол Монгол Улсын агаарын зайд ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь аэродромын шилжих үнэмлэхүй өндөр болон шилжих цувааны хоорондох аливаа өндөрт чиг шулуун нислэг үйлдэхгүй.

(в) НХУ-аас өгсөн зөвшөөрлийн дагуу хүлээх бүсэд нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт энэ зүйлийн (а), (б) хэсэг хамаарахгүй.

(г) Агаарын хөлгийн дарга нь:

1/ Тухайн аэродромд тогтоогдсон шилжих өндрөөс дээш өндөр авах үед, өндөр хэмжигчийг 1013.25 гПа-д (760.0 м.у.б) тохируулна;

2/ Тухайн аэродромд тогтоогдсон шилжих цуваанаас доош өндөр алдах үед, өндөр хэмжигчийг тухайн аэродромын QNH буюу QFE-д тохируулна.

#### **91.427. ХНД-ийн үед радио холбоо барих**

(а) НХУ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь:

1/ холбоо барьж буй давтамж дээр тогтмол сонсоно;

2/ дараахь мэдээллийг холбоо барьж буй НХУ-д аль болох хурдан хугацаанд мэдээлнэ:

2.1 илтгэл өгөх тогтоосон замын цэгүүдийг нисэн өнгөрч байгаа цаг, нислэгийн өндөр, эсвэл НХУ-аас онцолж заасан мэдээлэл өгөх замын цэгүүд;

2.2 нислэгийн аюулгүй байдалд хамаарах бусад мэдээлэл.

(б) Энэ зүйлийн (а)-ийн 2/-ыг үл харгалзан, ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь радиолокаторын хяналтанд байх үед НХУ-аас тусгайлан хүссэн илтгэл өгөх замын цэгүүдийн өнгөрөлтийг мэдээлнэ.

#### **91.429. ХНД-ийн үед радио холбоо алдагдах**

(а) НХУ-аас өөрөөр зөвшөөрөл олгоогүй бол, ил хараагаар нисэх цаг агаарын нөхцөл /VMC/-д ХНД-ээр нислэг үйлдэж байх хугацаанд радио холбоо алдагдсан, эсхүл радио холбоо алдагдсаны дараа ил харааны нислэгийн цаг агаарын нөхцөл /VMC/

шилжсэн бол уг агаарын хөлгийн дарга нислэгийг ИХНД-ээр үргэлжлүүлж, хамгийн ойрын тохиромжтой аэродромд бууна.

(б) НХУ-аас өөрөөр зөвшөөрөл олгоогүй бол, хэрэглэлээр нисэх цаг агаарын нөхцөл /ИМС/-д ХНД-ээр нислэг үйлдэж байх, эсхүл ил харааны нислэгийн цаг агаарын нөхцөл /VMC/ нь цааш үргэлжлэх найдваргүй үед радио холбоо алдагдсан бол агаарын хөлгийн дарга нь нислэгийг төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлж, энэ хугацаанд дор дурдсан арга хэмжээг авна:

- 1/ хэрэв хөөрөлтийн дараа радио холбоо алдагдсан бол сүүлд зөвшөөрөгдсөн нислэгийн өндрийг тухайн цэг хүртэл хадгалж дараа нь нислэгийг төлөвлөгөөний дагуу үйлдэнэ;
- 2/ хэрэв хөөрөлтийн дараа радиолокаторын хяналтанд НХУ-аас өгсөн курсээр нисэх үед радио холбоо алдагдсан бол уг курсыг газрын гадаргуун саадыг өнгөрсний дараа хоёр минутын турш хангалж дараа нь нислэгийг төлөвлөгөөний дагуу үйлдэнэ;
- 3/ хэрэв радио холбоо нь крейсер нислэгийн үед алдагдвал:
  - 3.1 НХУ-аас тусгайлан өгсөн, эсхүл тодорхой цэг өгөгдөөгүй бол хэрэглэлийн ойртолт эхлэх цэг дээр хамгийн сүүлд заагдсан өндөрт;
  - 3.2 хэрэв шаардлагатай бол нисэн ирэхээр тооцоолсон цагт өндөр алдаж хүлээх тойрогт орж хэрэглэлийн ойртолтын зааврыг дагаж мөрдөнө;
- 4/ хэрэв ойртолт үйлдэх эхний үед радио холбоо алдагдсан ба НХУ-аас ойртолт үйлдэх зөвшөөрөл өгөөгүй бол, ойртолтыг үргэлжлүүлэх, зөвшөөрсөн өндөр хүртэл доошилж, шаардлагатай бол хүлээх тойрог хийж уг өндрөө хадгалан ойртолтын чиг шулуунд орсны дараа ойртолт үйлдэх зааврыг мөрдөнө;
- 5/ хэрэв НХУ-ын радиолокаторын хяналтанд эхлэх болон завсрын цэгийн хооронд радио холбоо алдагдсан бол зөвшөөрсөн өндөр хүртэл доошилж, өндрөө хадгалан ойртолтын чиг шулуунд орсны дараа ойртолт үйлдэх зааврыг мөрдөнө;
- 6/ хэрэв радио холбоо алдагдсан нь агаарын хөлөг хүлээх тойрогт нисэх үед, цаг агаар нь ойртолт үйлдэх хязгаарлалтаас доош, аэродром ямар нэгэн шалтгаанаар хаагдсан бол:
  - 6.1 НХУ-аас тогтоож өгсөн хугацааг дуустал хүлээх тойрогт нисэх;
  - 6.2 Нислэгийн төлөвлөгөөний дагуу бэлтгэл аэродром руу нисэх;
  - 6.3 Хэрэглэлийн ойртолт үйлдэх зааврыг мөрдөх.

#### **91.431. Төхөөрөмжийн эвдрэл, гэмтлийг мэдэгдэх**

(а) ХНД-ээр нислэг үйлдэж буй агаарын хөлгийн дарга нь аэронавигацийн болон холбооны төхөөрөмж нислэгийн үед эвдэрч гэмтсэн тохиолдолд нэн даруй НХУ-д мэдэгдэнэ.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан мэдээлэлд дор дурдсан зүйлийг багтаасан байна:

- 1/ агаарын хөлгийн маяг;
- 2/ агаарын хөлгийн бүртгэл, нислэгийн дугаар;
- 3/ агаарын хөлгийн даргын нэр;
- 4/ агаарын хөлгийн ашиглагчийн нэр;
- 5/ агаарын хөлгийн байрлал, өндөр;
- 6/ нислэгийн үе шат;
- 7/ эвдэрч гэмтсэн төхөөрөмж;
- 8/ гэмтлийн талаарх товч мэдээ;
- 9/ нислэгт үзүүлсэн нөлөө.

**91.433 Нислэгийн чиглэл**

(а) НХУ-аас өөрөөр зөвшөөрөл олгогдоогүй бол аливаа этгээд ХНД-ээр хяналттай агаарын зайд дор заасны дагуу нислэгийг үйлдэнэ:

- 1/ агаарын зайд тогтоогдсон агаарын замын тэнхлэгээр;
- 2/ бусад газрын навигацын тоноглол болон тогтоосон цэгийг холбосон агаарын замын тэнхлэгээр;

**Е БҮЛЭГ. ХЭРЭГЛЭЛ БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА****91.501. Ерөнхий зүйл**

(а) Аливаа этгээд дор шаардсанаас бусад нөхцөлд агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- 1/ тухайн агаарын хөлөгт, энэ Бүлэгт шаардсан маяг, тоо бүхий хэрэглэл, тоног төхөөрөмжийг суурилуулсан байх;
- 2/ **тухайн агаарын хөлөгт суурилуулсан хэрэглэл, тоног төхөөрөмж нь дор дурдсан бичиг баримтад тусгасан онцлог болон загварын нислэгт тэнцэх чадварын стандартыг хангасан байх:**
  - 2.1 энэ дүрмийн Хавсралт А;
  - 2.2 ИНД-21-ийн **Хавсралт В**;
  - 2.3 ИНД-26;
  - 2.4 ИНЕГ-аас баталсан бусад загварын НТЧ-ын стандартууд.
- 3/ тухайн агаарын хөлгийн хэрэглэл, тоног төхөөрөмжийг уг агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс өгсөн заавар, эсхүл ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн бусад зааврын дагуу суурилуулсан байх;
- 4/ тухайн агаарын хөлөгт суурилуулсан хэрэглэл, тоног төхөөрөмж нь энэ дүрмийн 91.537-д зааснаас бусад тохиолдолд хэвийн ажиллагаатай байх.

**91.503. Хэрэглэл, тоног төхөөрөмжийн байрлал**

(а) Ашиглагч нь дор дурдсан зүйлийг баталгаажуулсан байна:

- 1/ нэг нисгэгч ажиллуулж буюу ашиглаж байгаа аливаа хэрэглэл, тоног төхөөрөмж нь уг нисгэгчийн суудлын хэвийн;
- 2/ хоёр нисгэгч ажиллуулж буюу ашиглаж байгаа аливаа хэрэглэл, тоног төхөөрөмж нь нисгэгч бүрийн суудлын хэвийн байрлалаас тэдгээрийг харахад чөлөөтэй, ажиллуулахад хялбар байна.

**91.505. Суудал, хамгаалах бүс**

(а) Агаарын бөмбөлөгөөс бусад агаарын хөлөгт дор дурьдсан суудал, хамгаалах бүсийг суурилуулсан байна:

- 1/ агаарын хөлөгт байгаа бүх хүмүүст зориулсан түшлэгтэй суудал;
- 2/ суудал бүрийн хамгаалах бүс;
- 3/ багийн бүх гишүүдэд зориулсан мөрөвчтэй хамгаалах бүсийг:
  - 3.1 14 буюу түүнээс дээш суудал бүхий агаарын хөлөгт;
  - 3.2 уран жолоодлогын нислэг үйлдэж буй агаарын хөлөгт.
- 4/ сургалтын нислэг үйлдэх агаарын хөлгийн нисэх багийн бүх гишүүдэд зориулсан мөрөвчтэй хамгаалах бүс, эсхүл ташуу даруулга.

(б) Энэ зүйлийн (а)-ийн 1/, 2/-ыг үл харгалзан, дараах тохиолдолд суудал, хамгаалах бүсийг шаардахгүй:

- 1/ энэ дүрмийн 91.207-гийн (г)-гийн 1/-д заасны дагуу агаарын хөлөгт сууж буй этгээд;
- 2/ шүхрээр буухад.

#### **91.507. Зорчигчдод мэдээлэх тэмдэглэгээ**

(а) Агаарын бөмбөлөгөөс бусад, 12 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлгийн зорчигчийн тасалгаа нь нисэх багийн бүхээгээс тусгаарлагдсан бол агаарын хөлгийн үйлчлэгч болон зорчигчдод зориулсан дараах мэдээлэл, таних тэмдгийг харагдахуйц газар байрлуулсан байх ба тэдгээрийг нисэх багийн бүхээгээс ажиллуулах боломжтой байна:

- 1/ тамхи татахыг хориглох тухай;
- 2/ хамгаалах бүс хэрэглэх тухай.

#### **91.509. Зайлшгүй шаардлагатай хэрэглэл ба тоног төхөөрөмж**

(а) Хөдөлгүүрт планераас бусад НТЧ-ын гэрчилгээтэй хөдөлгүүрт агаарын хөлөг бүрийг дараах зүйлсийг заах хэрэглэлээр тоноглогдсон байна:

- 1/ нислэгийн хурд;
- 2/ нислэгийн ашиглалтын зааварт хурдны хязгаарлалтыг М тоогоор илэрхийлсэн бол М тоо;
- 3/ метр болон футээр илэрхийлсэн өндөр хэмжигч;
- 4/ соронзон чиглэл заагч;
- 5/ түлшний багтаамж /нэмэгдэл бакнаас бусад/;
- 6/ хөдөлгүүр бүрийн эргэлтүүд;
- 7/ тосолгооны системтэй хөдөлгүүр бүрийн тосны даралт;
- 8/ шингэн хөргөлттэй хөдөлгүүрийн хөргөлтийн хэм, цельсийн градусуар;
- 9/ 250-иас дээш морины чадалтай хөдөлгүүр бүрийн тосны хэм, цельсийн градусуар;
- 10/ хөдөлгүүр бүрийн насосоос гарах түлшний даралт;
- 11/ 250-иас дээш морины чадалтай, агаараар хөрдөг поршинт хөдөлгүүр бүрийн цилиндрийн халуун;
- 12/ закрылкны байрлалыг нисэх баг харж тодорхойлох боломжгүй бол, закрылкны байрлал заагч;
- 13/ хэрэв агаарын хөлөг эвхэгддэг хөл ангитай бол хөл ангийн байрлал заагч;
- 14/ цахилгаан системийн ажиллагааг хянах самбар;
- 15/ хэрэв агаарын хөлгийн бүхээг нь хөдөлгүүрээс гарах хийн халаагуур, эсхүл дотоод шаталтын халаагч ашигладаг бол бүхээг дэх нүүрсхүчлийн хэт ислийн хэмжээг заагч.

(б) Монгол Улсын бүртгэлд бүртгэгдэж, Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгогдсон дараах агаарын хөлгүүдийг, нислэгийн цагийг бүртгэж хадгалах автомат төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- 1/ ИНД-137-гийн дагуу хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа нисдэг тэрэг;
- 2/ ИНД-135-ын дагуу ашиглагдаж байгаа нисдэг тэрэг;

3/ тусгай ангиллын туршилтын Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй, эсхүл сонирхогчийн бүтээсэн тусгай ангиллын Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэйгээс бусад, аливаа зориулалтаар ашиглагдаж буй нисдэг тэрэг;

4/ ИНД-137-гийн дагуу хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглагдаж байгаа онгоц.

(в) Агаарын хөлөг нь зорчигчийн болон ямар нэг тасалгаа руу нэвтрэн орох хаалгатай бөгөөд тэдгээр нь түгжигддэг бол нисэх багийн гишүүд түгжээг онгойлгож болох хэрэгслээр тоногдсон байна.

### **91.511 Нөөц**

#### **91.513 ИХНД-д шаардлагатай холбооны төхөөрөмж**

(а) Радио холбоогүйгээр ИХНД-ээр нисэх зөвшөөрлийг НХУ-аас нисгэгчид олгоогүй бол, НХУ-тай агаарын зайд ИХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг нь зохих НХУ-тай хоёр талын радио холбоог тасралтгүй барих боломжтой, энэ дүрмийн Хавсралтын А9-д заасан стандартад нийцсэн радио холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

(б) НХУ-тай агаарын зайн гадна ИХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг нь энэ дүрмийн Хавсралтын А9-д заасан стандартад нийцсэн радио холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

### **91.515 Нөөц**

#### **91.517 ХНД-д шаардлагатай хэрэглэл, төхөөрөмж**

(а) Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй, ХНД-ээр нислэг үйлдэх хөдөлгүүрт агаарын хөлгийг 91.509-д заасны дагуу тоноглохоос гадна дараах хэрэглэлүүдтэй байна:

- 1/ гироскоп болон инерциал хэлбэрээр ажиллах авиагоризонт;
- 2/ гироскоп болон инерциал хэлбэрээр ажиллах соронзон чиглэл заагч;
- 3/ гироскоп хэрэглэлийн цахилгаан тэжээлийн хэвийн байдал;
- 4/ гПа /mb/ -аар тохируулсан метр /фут/-ээр илэрхийлэх барометрийн өндөр хэмжигч;
- 5/ гаднах агаарын температур хэмжигч;
- 6/ цаг, минут, секундээр илэрхийлэх цаг;
- 7/ конденсаци, мөстөлтөөс сэргийлэх хэрэгсэл бүхий узелиэр илэрхийлэх хурд хэмжигч;
- 8/ өндөр авах болон алдах босоо хурдны хэмжээ;
- 9/ агаарын хөлгийн суултын гэрэл /2ширхэг/.

#### **91.519 ХНД-ийн үед шаардлагатай холбоо, навигацийн төхөөрөмж**

(а) ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг нь зохих НХУ-ний нэгж буюу аэронавигацийн болон холбооны төхөөрөмжтэй хоёр талын радио холбоог тасралтгүй барих боломжтой, энэ дүрмийн Хавсралтын А9-д заасан стандартад нийцэх холбооны төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

(б) ХНД-ээр нислэг үйлдэх агаарын хөлөг нь дараах навигацийн системээр тоноглогдсон байна:

- 1/ энэ дүрмийн Хавсралтын А9-д заасан стандартад нийцсэн байх;

2/ агаарын хөлгийг дор дурдсан шаардлагын дагуу нисэх нөхцлийг бүрдүүлэх:

- 2.1 нислэгийн төлөвлөгөө;
- 2.2 тогтоосон RNP агаарын зайд;
- 2.3 НХУ-ын шаардлагын дагуу.

(в) Холбогдох навигацийн шаардлагатай үзүүлэлт (RNP) шаардсан агаарын зам болон тогтоосон RNP агаарын зайд нисэх агаарын хөлөг болон ашиглах агаарын хөлгийн навигацийн системийг ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн байна.

(г) ICAO-гийн Doc 7030-д заасны дагуу тогтоосон /minimum navigation performance specification/ MNPS бүхий агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийг:

- 1/ маршрутын дагуух аль нэг цэг дээр замаас хазайхад нисэх багийн гишүүдэд үнэн зөв заах навигацийн төхөөрөмжөөр тоноглогдсон байна;
- 2/ MNPS нислэгийн үйл ажиллагааг ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн байна.

(д) FL 290-ээс дээш өндөрт 300м (1000 фут)-ийн багасгасан босоо зайчлалын хязгаарлалт /RVSM/-ыг НХУ-аас хэрэглэж буй агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлөг нь:

- 1/ ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөгдсөн байна;
- 2/ доорх төхөөрөмжөөр тоноглогдсон байна:
  - 2.1 нислэгийн өндрийг заагч;
  - 2.2 нислэгийн сонгосон өндрийг автоматаар хадгалагч;
  - 2.3 сонгосон нислэгийн өндрийн цуваанаас 60м (200 фут)-ээр гажсан тохиолдолд нисэх багт дуут болон гэрлэн дохио өгөгч;
  - 2.4 энэ хэсэгт шаардсан өндөр хэмжих аль ч системээс шилжин ажиллах чадвар бүхий, өндрийг автоматаар мэдээлэгч.

(е) Энэ зүйлийн (д)-ийн 2.1-д шаардсан өндөр хэмжих төхөөрөмж нь хоёроос доошгүй системээс бүрдсэн байна.

(ж) RNP, MNPS агаарын зайд нисэх агаарын хөлгийн холбоо, навигацийн системд гэмтэл гарсан тохиолдолд үлдсэн төхөөрөмж нь агаарын хөлгийн нислэгийг энэ зүйлийн (а), (б), (в), (г)-д заасан шаардлагын дагуу үргэлжлүүлэх боломжийг хангасан, (а), (б), (в), (г)-ийн 1/-д шаардсан бие даасан ажиллагаа бүхий тоног төхөөрөмж байна.

**91.521. CAT II ба CAT III хязгаарлалтаар ойртолт үйлдэхэд шаардлагатай төхөөрөмж**

(а) CATII ба CATIII - хязгаарлалтаар ойртолт, буулт үйлдэх агаарын хөлөг бүр нь 91.509, 91.511, 91.517-д заасны дагуу тоноглогдохоос гадна дараах хэрэглэлүүдтэй байна:

- 1/ курсын ба глиссадын радиомаякийн дохиолол хүлээн авагч хоёр систем нь:
  - 1.1. нисгэгч бүрийн суудлаас ILS-ийн үндсэн заалтыг хянах;
  - 1.2. курсын болон глиссадын радиомаякийн дохиолол хүлээн авах антен тус бүр нэгээс доошгүй.
- 2/ агаарын хөлгийн холбооны төхөөрөмжийн ажиллагаанд үл нөлөөлөх 1/-д заагдсан ILS систем нэгээс доошгүй;
- 3/ холын ба ойрын чиглүүлэх радиостанцыг дуу болон гэрлээр ялгавартай заах маркерын хүлээн авагч;
- 4/ гироскоп буюу инерциал ажиллагаатай, авиагоризонт хоёр;
- 5/ гироскоп буюу инерциал ажиллагаатай, соронзон чиглэл заагч хоёр;

- 6/ хэт хөрсөн усан дусал буюу мөстөлтийн улмаас гарч болох гэмтэл, буруу заалтаас урьдчилан сэргийлэх халаалга бүхий узелиэр тохируулсан хурд заагч хэрэглэл хоёр;
- 7/ метр /фут/-ээр тохируулсан, тус бүртээ таблицаар засвар хийгдэх өндөр хэмжигч хоёр;
- 8/ өндөр авах болон алдах босоо хурд заагч хоёр ширхэг;
- 9/ дараах зүйлсээс бүрдсэн нислэгийг удирдан чиглүүлэх систем:
  - 9.1 ILS-ийн курсын чиглүүлэгчийн дохиололтой харьцуулан автоматаар жолоодон ойртолт, буулт хийх хүчин чадал бүхий автопилот нэгээс доошгүй байх; эсхүл
  - 9.2 ILS-ийн курс ба глиссадын радиомаякийн дохиоллыг хүлээн авч тооцоолсон мэдээллээ дэлгэц эсхүл нислэгийн хэрэглэл дээр харуулан заалтыг харьцуулж чиглэл ба глиссадын налууг тохируулах команд өгөх нислэгийн удирдлагын систем;
- 10/ шийдвэр гаргах өндөр нь 50м /150 фут/ -ээс доош нислэгт:
  - 10.1 ойрын чиглүүлэх радио станцын дохиоллыг дуугаар болон гэрлээр хянах маркерын хүлээн авагч;
  - 10.2 радио өндөр хэмжигч.
- 11/ системийн алдаа, буруу ажиллагааг нисгэгч түргэн олж илрүүлэхэд зориулсан анхааруулах систем:
  - 11.1 энэ хэсгийн 1/, 4/, 5/, 9/-д шаардсан зүйлүүдийн хувьд;
  - 11.2 CAT III ойртолт буултад ашиглахаар суурилуулсан бол, радио өндөр хэмжигч болон хөдөлгүүрийн хүчийг автоматаар удирдах системийн хувьд.
- 12/ бүрэн ажиллагаатай хос удирдлага;
- 13/ гадна орчинтой холбогдсон нөөц эх үүсвэр бүхий статик даралтын систем;
- 14/ газардах болон буултын дараах гүйлтэнд аль ч нисгэгчийн талаас гадагш харах нөхцөлийг сайжруулах шил арчигч, эсхүл түүнтэй адилтгах хэрэгсэл;

(б) Энэ зүйлийн (а)-гийн 4/-8/-д шаардсан хэрэглэл, төхөөрөмжийн тоонд 91.517-д заасан ХНД-ийн үед шаардагдах хэрэглэл, төхөөрөмжийг багтаасан байна.

### **91.523. Ослын үед хэрэглэх төхөөрөмж**

(а) 12 буюу түүнээс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлгийг дараах хэрэглэлээр тоногдсон байна:

- 1/ Хүснэгт 7-д заасан, эмнэлгийн анхны тусламжийн хэрэгслүүдийг нислэгийн үед өвдөх, хөнгөн бэртэж гэмтэхэд анхны тусламж үзүүлэхэд агаарын хөлгийн бүх тасалгаанд байрлуулсан байх;
- 2/ Хүснэгт 8-д заасан тоо бүхий, тасалгаануудад байрлуулсан авч хэрэглэхэд бэлэн зөөврийн гал унтраагч.

(б) 20-иос дээш зорчигчийн суудалтай агаарын хөлөг нь багийн гишүүд ашиглахад зориулагдсан аврах сүхээр тоноглогдсон байна.

(в) 60-аас дээш зорчигчийн суудалтай агаарын хөлгийг дараах шаардлагыг хангасан, зайгаар ажилладаг зөөврийн чанга яригчаар тоногдсон байна:

- 1/ агаарын хөлгийн үйлчлэгчийн суудалд ойр, зорчигчдыг яаралтай гаргахаар томилогдсон багийн гишүүн авч ажиллуулахад хялбар дөхөмтэй байх;
- 2/ Хүснэгт 9-д заасны дагуу суурилуулсан байх.

(г) Энэ зүйлийн (а)-гийн 2/, (в)-д шаардсан төхөөрөмжүүд нь тэдгээрийг ажиллуулах зааварчилгатай байна.

(д) Энэ зүйлийн (а)-д шаардсан хэрэглэлийг тусгай саванд хийж, жагсаалтыг тэмдэглэсэн байна.

(е) Энэ зүйлийн (в) хэсэг нь зорчигчийн аль нэгэн тасалгааг ачаа тээвэрлэх зорилгоор бүхэлд нь өөрчилж, зөвхөн ачаа тээвэрлэх үед үл хамаарна.

#### **Хүснэгт 7. Эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл**

<i>Зорчигчийн тоо</i>	<i>Анхны тусламжийн хэрэгслийн тоо</i>
1 -ээс 100	1
101 -ээс 200	2
201 -ээс 300	3
301 -ээс 400	4
401 -ээс 500	5

#### **Хүснэгт 8. Зөөврийн гал унтраагч**

<b>Байрлал</b>	<b>Тоо</b>
Зорчигчийн болон ачааны тасалгаа бүрт, эсхүл үндсэн болон аваарын хаалга бүрийн дэргэд	1
Нислэгийн бүхээгт буюу түүний ойролцоо нисэх багийн гишүүдэд хэрэглэхэд бэлэн байрлалд	1
Гал тогооны тасалгаанд	1
<b>Зорчигчийн тоо</b>	
1-ээс 30	1
31-ээс 60	2
61-ээс 200	3
201-ээс 300	4
301-ээс 400	5
401-ээс 500	6

#### **Хүснэгт 9. Чанга яригч**

<i>Суудлын багтаамж</i>	<i>Хуваарилалт</i>	
	<i>Урд талд</i>	<i>Ард талд</i>
61–ээс 99		1
100 буюу түүнээс дээш	1	1

#### **91.525. Усан дээгүүрх нислэг**

(а) Усан дээгүүр нисэх агаарын хөлөгт аливаа этгээд тус бүрдээ суудлаас авч хэрэглэх боломжтой дараах төхөөрөмжөөр тоногдсон байна:



- 1/ нэг хөдөлгүүртэй агаарын хөлөгт хөдөлгүүр нь ажиллаагүйн улмаас өндөр алдаж эрэгт хүрэх алслалтаас их бол агаарын хөлгөөр зорчиж буй хүн тус бүрт нэг аврах хантааз;
- 2/ олон хөдөлгүүртэй агаарын хөлгийн нэг хөдөлгүүр нь ажиллаагүйн улмаас далайн түвшнээс дээш 300м /1000фут/ өндрийг хадгалах боломжгүй өндөр алдаж эрэгт хүрэх нислэг үйлдэх боломжгүй бол зорчиж буй хүн тус бүрт нэг аврах хантааз;
- 3/ олон хөдөлгүүртэй агаарын хөлгийн нэг хөдөлгүүр нь ажиллаагүйн улмаас далайн түвшнээс дээш 300м /1000фут/ өндрийг хадгалж эргээс 90км-ээс цааш зайд нислэг үйлдэх бол зорчигч хүн тус бүрт нэг аврах хантааз.

(б) Далайн түвшнээс дээш 300м /1000фут/ өндрийг хадгалж эргээс 185 км-ээс алс зайд нислэг үйлдэх нэг ба олон хөдөлгүүрт агаарын хөлөгт:

- 1/ тухайн агаарын хөлгөөр зорчиж буй бүх хүмүүсийг багтаах хөвөх чадвартай аврах завь /хангалттай хэмжээгээр/;
- 2/ аврах хантаас бүр дээр байрлал тодорхойлох гэрэл;
- 3/ завь бүрт суурилуулсан авран туслах хэрэгслүүд;
- 4/ завь тус бүрт дохионы хэрэгсэл;
- 5/ ослын үед байрлал дамжуулагч / ELT/ нэг.

(в) Олон хөдөлгүүрт агаарын хөлөгт усны эргээс 370км-ээс алс зайд нисэх бол нэг буюу түүнээс олон хөдөлгүүр нь ажиллахгүй болсон тохиолдолд (б)-д заасан төхөөрөмжөөр тоногдсон байна.

(г) Усны эргээс 370км-ээс цааш зайд нисэх 5700 кг-аас илүү хөөрөлтийн жинтэй агаарын хөлөгт (б)-д заасан нэмэлт ELT.

(д) Аврах завь, хантааз болон дохионы төхөөрөмжийг нүдэнд харагдах газар байрлуулж, усан дээр ослын буулт хийх үед тэдгээрийг хэрэглэхэд бэлэн байх ёстой.

### **91.527 Нөөц**

#### **91.529. Ослын байршил дамжуулагч /ELT/**

(а) Энэ зүйлийн (б), (в), (г)-д зааснаас бусад тохиолдолд, агаарын хөлөг бүрт ELT-ийг суурилуулсан байна.

(б) Зорчигч тээвэрлээгүй тохиолдолд тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны үндсэн байрлалаас, түүнд ELT суурилуулах газар уруу ELT-гүй нислэг үйлдэж болно.

(в) Энэ дүрмийн 91.501-ийн 4/-р заалттай ELT ажиллагаагүй бол дараах тохиолдолд хамаарахгүй:

- 1/ ELT нь ажиллагаагүй болсон агаарын хөлгийг засварлах буюу солих боломжгүй тухайн байрлаж буй газраас нь засварлах, солих боломжтой газар уруу нислэг үйлдэж байвал;
- 2/ зорчигч тээвэрлээгүй бол.

(г) Агаарын хөлгийн бүхээгт ELT эсхүл PLB-тэй этгээд байвал агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагааг 7 хоногоос ихгүй хугацаатай үйлдэхэд энэ дүрмийн 91.501, 4/-р болон (а) заалт нь хамаарахгүй.

(д) Энэ зүйлийн (а) нь дараах агаарын хөлөгт хамаарахгүй:

- 1/ 1-ээс илүүгүй суудалтай агаарын хөлгийн нисгэгч нь ELT, эсхүл PLB-тэй бол;
- 2/ планер болон хэт хөнгөн агаарын хөлгийн 1 зорчигч нь ELT, эсхүл PLB-тэй бол;
- 3/ планер, хөдөлгүүрт агаарын хөлөг болон хэт хөнгөн агаарын хөлгүүд нь 2-оос илүүгүй суудлаар тоноглогдсон бол хөөрөлт үйлдсэн аэродромоос 20 км-ийн дотогш нислэг үйлдэх бол;
- 4/ нисгэгчтэй агаарын бөмбөлөг.

(е) Аливаа этгээд нь Монгол Улсад болон гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөгт суурилуулсан, эсхүл авч нисэхэд 406 Мгц –ийн ELT нь дор заасны дагуу кодлогдоогүй бол агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- 1/ бүртгэл хийгдсэн улсын олон улсын цахилгаан холбооны код;
- 2/ дор заагдсан аль нэг:
  - 2.1 ELT – ийн серийн дугаар;
  - 2.2 агаарын хөлгийн 24 bit-ийн хаяг;
  - 2.3 агаарын хөлөг ашиглагчийн ICAO-ын хаягийн дагуу;
  - 2.4 агаарын хөлгийн улсын бүртгэлийн дугаар.

### **91.531. Хүчилтөрөгчийг заах хэрэгсэл**

(а) Далайн түвшнээс дээш 3900м /13000 фут/-ээс дээш өндөрт, эсхүл 3000- 3900м /10000-13000фут/-ийн хооронд 30 минутаас дээш хугацаагаар нислэг үйлдэх агаарын хөлөг бүрийг дараах хэрэгслээр тоногдсон байна:

- 1/ нисэх багийн гишүүдэд:
  - 1.1. хүчилтөрөгчөөр хангагч нь хангалттай хэмжээний хүчилтөрөгчтэй болон зохих хэсэгт хүчилтөрөгч хуваарилагдаж буй эсэхийг заагч;
  - 1.2. битүүмжлэл бүхий агаарын хөлгийн бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь далайн түвшнээс дээш 3000 м /10000 фут/-ээс их болсон үед, дуун болон харагдах анхааруулах төхөөрөмж.
- 2/ хүчилтөрөгч хуваарилах хэрэглэгч тус бүрт хангалттай хэмжээний хүчилтөрөгч байгаа болон хуваарилах хэсэгт хүчилтөрөгч очиж буй эсэхийг заах.

### **91.533. Битүүмжлэлгүй агаарын хөлгийн хүчилтөрөгч**

(а) Далайн түвшнээс дээш 3000 метрийн дээш өндөрт нисэх, битүүмжлэлгүй агаарын хөлгийг дараах хэрэгслээр тоногдсон байна:

- 1/ 3900м /13000 фут/ хүртэл өндөрт:
  - 1.1 30 минутаас дээш хугацаанд багийн бүх гишүүд ба зорчигчийн 10%-ийг байнга хангах нэмэлт хүчилтөрөгч;
  - 1.2 зорчигчийн 3-аас доошгүй хувь нь байнга хэрэглэх эмчилгээний хүчилтөрөгч.
- 2/ Далайн түвшнээс дээш 3900-7600м /13000-25000фут/-ийн хоорондох өндөрт:
  - 2.1 багийн бүх гишүүд болон зорчигчид байнга хэрэглэх нэмэлт хүчилтөрөгч;
  - 2.2 зорчигчийн 1-ээс дээш хувь нь байнга хэрэглэх эмчилгээний хүчилтөрөгч;
  - 2.3 бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь 10000 фут (3050 метр)-ээс их болох үед бэлэн байх 120 л-ээс их буюу хангалттай хэмжээний хүчилтөрөгч агуулсан, яаралтай, байнга хэрэглэхэд шаардагдах, багийн гишүүдэд зориулсан амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж.

(б) Эмчилгээний хүчилтөрөгчийг нэмэлт хүчилтөрөгчтэй ижил хэмжээгээр буюу нэмэлт хүчилтөрөгчийг эмчилгээний хүчилтөрөгчтэй ижил хэмжээгээр орлуулснаар энэ зүйлийн (а)-д заасан шаардлагыг хангаж болно.

**91.535. Битүүмжлэл бүхий агаарын хөлгийн хүчилтөрөгч**

(а) Далайн дундаж төвшнөөс дээш 3000-7600м /10000-25000 фут/-ийн өндөрт нислэг үйлдэх, битүүмжлэлийн систем бүхий агаарын хөлгийг дараах хэрэгслээр тоноглон байна:

- 1/ даралтын системд гэмтэл гарсны улмаас бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь 10000 фут (3050 метр) -ээс хэтрэх үед нисэх багийн гишүүд бүрийн суудалд ойр авч хэрэглэхэд хялбар нэмэлт хүчилтөрөгчөөр тасралтгүй хангаж чадах, хүчилтөрөгчийн баг;
- 2/ агаарын хөлгийн үйлчлэгчид суудалд ойр авч хэрэглэхэд хялбар дараах төхөөрөмж;
  - 2.1 зорчигчийн хүчилтөрөгчийн баг;
  - 2.2 бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр 10000фут (3000 метр)-ээс их болох үед байнга хэрэглэхэд шаардлагатай 120 л-ээс багагүй хүчилтөрөгч агуулсан зөөврийн төхөөрөмж. хүчилтөрөгч.
- 3/ байрлал хамаарахгүйгээр, багийн бүх гишүүдийг хүчилтөрөгчөөр яаралтай хангах хангалттай тооны хүчилтөрөгчийн нөөц баг буюу амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж;
- 4/ дор дурьдсан (б) заалтаас багагүй хэмжээний нэмэлт хүчилтөрөгч:
  - 4.1 нисэх багийн гишүүн бүрийг 45 минутын хугацаанд хангах; эсхүл
  - 4.2 нисэх багийн гишүүд болон зорчигчдийг 12 минутын хугацаанд хангах.
- 5/ дараах тохиолдолд нэмэлт, эсхүл эмчилгээний хүчилтөрөгч их хэмжээгээр шаардагдана:
  - 5.1 хэрэв агаарын хөлөг нь 4 минутанд далайн дундаж төвшнөөс дээш 4200 м /14000 фут/-ээс доош өндөр алдах боломжтой байвал, бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь далайн дундаж төвшнөөс дээш 10000 фут (3000 метр)-ээс их байх аль ч тохиолдолд зорчигчийн 10%-ийг хангах хүчилтөрөгч;
  - 5.2 хэрэв агаарын хөлөг нь 4 минутын хугацаанд далайн дундаж төвшнөөс дээш 4200 метр /14000 фут/-ээс доош өндөр алдаж чадахгүй байвал, бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь Далайн дундаж төвшнөөс дээш 4200 м /14000 фут/ -ээс их байх тохиолдолд бүх зорчигчийг хангах хүчилтөрөгч;
  - 5.3 зорчигчдын 10 хувийг 30 минутын хугацаанд хангах хүчилтөрөгч;
  - 5.4 зорчигчдын 1 хувийг тогтмол хангах хүчилтөрөгч.

(б) Энэ зүйлийн (а)-ийн 4/ ба 5/-ыг харгалзан, багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж нь дараах тохиолдолд шаардлагагүй:

- 1/ хэрэв амьсгал хамгаалах нөөц төхөөрөмж нь 15 минутын хугацаанд хүчилтөрөгчөөр хангах хүчин чадалтай бол;
- 2/ тухайн агаарын хөлөгт зөвхөн нэг нисгэгч байвал;
- 3/ тухайн агаарын хөлөгт багийн бусад гишүүд байхгүй бол;
- 4/ зорчигчид нь нисгэгчид харагдахаар нэг тасалгаанд суусан байвал.

(в) Энэ зүйлийн (а)-ийн 5/, 6/-г мөрдөхдөө битүүмжлэлийн системд гэмтэл гарсан тохиолдолд шаардлагатай хүчилтөрөгчийг тооцохдоо дараах зүйлийг анхааралдаа авна:

- 1/ яаралтай өндөр алдан аюулгүйн өндөрт хүрэхэд шаардлагатай хугацаа;

- 2/ агаарын хөлөг буухаас өмнө 3000 м-ээс дээш өндөрт нисэх шаардлагатай гэж үзсэн бол, нислэгийн дараагийн үе шат.

(г) Далайн дундаж төвшнөөс дээш 7600-9100м /25000-30000фут/ түүнээс дээш өндөрт нисдэг, битүүмжлэлийн систем бүхий агаарын хөлгийг (а)-д заасан болон дараах төхөөрөмжөөр тоногловсон байна:

- 1/ нисэх багийн гишүүд суудлаасаа авч хэрэглэхэд хялбар хүчилтөрөгчийн баг;
- 2/ нэмэлт хүчилтөрөгчөөр хангах хүчилтөрөгчийн баг:
  - 2.1 нисэх багийн гишүүдээс бусад багийн гишүүд болон бүх зорчигчийг;
  - 2.2 угаалгын ба ариун цэврийн тусгаарлагдсан өрөө бүрийг.
- 3/ зорчигчдын 10 хувийг 45 минутаас багагүй хугацаанд хангах эмчилгээний хүчилтөрөгч.

(д) Далайн дундаж төвшнөөс дээш 9100 м /30000фут/-ээс дээш өндөрт ажилладаг битүүмжлэлийн систем бүхий агаарын хөлгийг энэ зүйлийн (а), (в)-д заасан болон дараах төхөөрөмжөөр тоногловсон байна:

- 1/ зорчигчийн тасалгаа, ариун цэврийн өрөөний хүчилтөрөгчийн багуудын нийт тоо нь зорчигчийн суудлын тооноос наад зах нь 10%-иар илүү байна;
- 2/ бүхээгийн даралтаар илэрхийлэгдэх өндөр нь 4200м /14000фут/-ээс илүү болох үед, зорчигчдийн тасалгаа, нисэх багийн бүхээг дэх хүчилтөрөгчийн баг автоматаар бууна;
- 3/ автомат систем гэмтсэн үед хүчилтөрөгчийн багийг гар ажиллагаагаар буулгахад шаардлагатай хэрэгслээр нисэх багийн гишүүдийг хангана.

### **91.537. Ажиллагаагүй хэрэгсэл ба тоног төхөөрөмж**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад үед дараах нөхцөл бүрдээгүй бол ажиллагаагүй хэрэглэл, эсхүл тоног төхөөрөмж суурилуулсан агаарын хөлгөөр нисэхгүй:

- 1/ тухайн агаарын хөлгийн MEL-ыг 91.539-д заасны дагуу батлуулсан;
- 2/ ИНД-43-ын дагуу ажиллагаагүй байж болох тоноглолтой агаарын хөлгийг техник үйлчилгээнээс гаргасан бол;
- 3/ агаарын хөлөг нь MEL-д агуулсан бүх нөхцөл, хязгаарлалтын дагуу ниссэн.

(б) Хөөрөлтийн жин нь 5700 кг-аас хэтрээгүй бөгөөд 91.539-ын дагуу батлагдах MEL-гүй агаарын хөлөг нь ажиллагаагүй хэрэглэл буюу төхөөрөмжтэйгээр энэ дүрмийн дагуу дараах тохиолдолд нислэг үйлдэж болно:

- 1/ тэдгээр ажиллагаагүй хэрэглэл төхөөрөмж нь:
  - 1.1 тухайн агаарын хөлгийн маягийн гэрчилгээний дагуу НТЧ-ын холбогдох шаардлагад нийцсэн, өдрийн цагт ИХНД-ээр нисэхэд шаардагдах хэрэглэл, төхөөрөмжийн хэсэг биш бол ;
  - 1.2 тэдгээр нь энэ бүлгийн дагуу тусгай үйл ажиллагаанд шаардлагатай биш бол;
  - 1.3 тэдгээр нь НТЧ-ын удирдамж (AD)-ийн дагуу ажиллагаатай байх нөхцөл шаардаагүй бол.
- 2/ тэдгээрийг Ажиллагаагүй гэж тэмдэглэсэн, ИНД-43-т заасны дагуу шаардлагатай техник үйлчилгээний бүртгэл, мэдээлэл байгаа бол.

(в) Энэ дүрмийн (а), (б)–д заасан шаардлагыг хангаагүй агаарын хөлөг нь ИНД-21-ийн дагуу тусгай НТЧ гэрчилгээтэй бол тухайн агаарын хөлгөөр нислэг үйлдэж болно.

**91.539. MEL-ийг батлах**

(а) MEL батлуулахаар өргөдөл гаргагч нь ИНЕГ-ын холбогдох маягыг бөглөн өргөдлийн хураамжийн хамт ИНЕГ-т ирүүлнэ.

(б) MEL-ийг мастер MEL -д үндэслэн боловсруулах ба дараах зүйлсийг багтаасан байна:

- 1/ ашиглах агаарын хөлгийн маяг, загвар;
- 2/ ажиллагаагүй үед ашиглаж болох тоног төхөөрөмжийн дараах жагсаалт:
  - 2.1 тухайн агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс баталсан;
  - 2.2 тухайн агаарын хөлөгт маягийн гэрчилгээ олгосон Чикагогийн конвенцийн Хэлэлцэн тохирогч улсаас баталсан;
  - 2.3 ИНЕГ-аастухайн агаарын хөлгийн ажиллагаагүй хэрэглэл болон тоног төхөөрөмж нь агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй гэж хүлээн зөвшөөрсөн.

(в) MEL-д дараах тоног төхөөрөмжийг багтаахгүй:

- 1/ агаарын хөлгийн маягийн гэрчилгээний дагуу НТЧ-ын шаардлагад тусгайлан шаардаж буй төхөөрөмж; эсхүл
- 2/ энэ бүлгийн дагуу тусгай үйл ажиллагаанд шаардагдах төхөөрөмж; эсхүл
- 3/ ажиллах нөхцөл нь НТЧ-ын удирдамж (AD)-ын дагуу шаардагдах төхөөрөмж.

(г) ИНЕГ-аас аюулгүй ажиллагааны үүднээс зайлшгүй гэж үзвэл MEL-д тавих хязгаарлалт, нөхцлүүдийг тодруулан заавар, зөвлөлтөө өгч болно.

**91.541. Автомат хариулагч ба өндөр мэдээлэх төхөөрөмж**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, НХУ-аас өөр зөвшөөрөл олгоогүй бол автомат хариулагчийг ашиглах агаарын зайд нисэх агаарын хөлгийг дараах автомат хариулагчаар тоноглоно:

- 1/ НХУ-аас онцлон заасан кодонд 3/A горимд хариулах хүчин чадалтай 3/A 4096 автомат хариулагч;
- 2/ 30 м /100 фут/ нарийвчлалттай нислэгийн өндрийг дамжуулж, С горимд хариулах хүчин чадалтай С горимд ажиллах автомат хариулагч.

(б) Энэ зүйлийн (а)-гийн 1/ нь бүх төрлийн планер, нисгэгчгүй агаарын бөмбөлөгт хамаарахгүй.

(в) S горимд ажиллах автомат хариулагч шаардлагатай агаарын зайд нислэг үйлдэх агаарын хөлгийг S горимд ажиллах хүчин чадалтай дараах автомат хариулагчаар тоногдосон байна:

- 1/ НХУ-аас заасан кодыг дамжуулж 3/A горимд хариулах
- 2/ завсрын горим;
- 3/ S горимд хариулагч.

**91.543. Тийрэлтэт хөдөлгүүрт агаарын хөлгийн нислэгийн өндөр дохиологч систем ба төхөөрөмж**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд тийрэлтэт хөдөлгүүрт агаарын хөлөг бүр нь өндрийг дохиологч дараах систем, эсхүл төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- 1/ өндөр авах буюу өндөр алдах аль ч тохиолдолд, урьдчилан сонгосон өндөрт ойртох үед нисгэгчид дохио өгдөг дараах төхөөрөмж:
  - 1.1 хангалттай хугацааны өмнө, урьдчилан сонгосон өндөрт чиг шулуун нислэгийг тогтоож болох сонсогдох ба харагдах дохиолол өгөх;
  - 1.2 хангалттай хугацааны өмнө, урьдчилан сонгосон өндөрт чиг шулуун нислэгийг тогтоох сонсогдох ба харагдах дохиолол өгөх бөгөөд урьдчилан сонгосон өндрөөс дээш, эсхүл доош өөрчлөлт гарах үед дуут дохиолол өгөх.
- 2/ тухайн онгоцонд далайн дундаж төвшнөөс дээш зөвшөөрөгдсөн хамгийн их өндөр хүртэл шаардлагатай дохио өгөх;
- 3/ урьдчилан сонгосон өндрийн өсөлтийг тухайн онгоц нисэх өндөрт зохицуулан ашиглах боломж олгох;
- 4/ өндөр дохиологчийн зөв ажиллаж байгаа эсэхийг тодорхойлох шалгалт нь тусгай төхөөрөмжгүйгээр хийгддэг байх;
- 5/ уг систем буюу төхөөрөмж нь барометрийн даралтаар ажиллаж байвал, барометрийн даралтын тохируулгатай байх.

(б) Энэ зүйлийн (а) нь дараах үйл ажиллагаанд хамаарахгүй:

- 1/ НТЧ-ын хязгаарлагдмал буюу тусгай гэрчилгээтэй онгоцны нислэгийн үйл ажиллагаа;
- 2/ дараах зорилгоор ашиглах онгоцны нислэгийн үйл ажиллагаа:
  - 2.1 шинээр авсан онгоцыг түүний үндсэн байрлалаас өндөр дохиолох систем, эсхүл төхөөрөмж суурилуулах байрлал руу нисгэх ;
  - 2.2 тухайн агаарын хөлгийн НТЧ-ыг шалгах нислэг явуулах;
  - 2.3 тухайн агаарын хөлгийг гадаад улсад бүртгүүлэхээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс нисгэх;
  - 2.4 тухайн агаарын хөлгийг худалдах зорилгоор үзүүлэх нислэг хийх;
  - 2.5 тухайн агаарын хөлгийг гадаад улсад бүртгүүлэх зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрээс нисгэхээс өмнө уг нислэгт оролцох гадаадын нисэх багийн сургалтын нислэг.

#### **91.545. Тогтоосон өндрийг заагч**

(а) ХНД-ээр нисэх агаарын хөлөг нь өндөр дохиолох систем, төхөөрөмжөөр тоноглогдоогүй бол, түүнийг НХУ-аас тогтоосон өндрийг заах хэрэглэлээр тоногдсон байна.

(б) Энэ зүйлийн (а)-д шаардсан өндөр заах хэрэгсэл нь:

- 1/ аль ч нисгэгчийн суудлаас тохируулгыг хялбар хийж болох байрлалд байна;
- 2/ тогтоосон өндрийг хянах үүрэг бүхий нисэх багийн бүх гишүүдэд хэрэглэл, дэлгэц дээр тодорхой харагдахаар байна;
- 3/ урьдчилан сонгосон өндрийн өсөлтийг тухайн онгоц нисэх өндөрт зохицуулан ашиглах боломж олгосон байна.

#### **91.547 Газар ойртолтыг анхааруулах систем**

(а) Хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин 5700 кг-аас их, турбинт хөдөлгүүр бүхий онгоцнууд нь сайжруулсан газар ойртолтыг анхааруулах систем (EGPWS)-ээр тоногдсон байна.

(б) Онгоцны нислэгийн зааварт дараах зааварчилгааг оруулсан байна:

- 1/ газар ойртолтыг анхааруулах системийн ашиглалтын талаар;
- 2/ газар ойртсоныг анхааруулан дохио өгөхөд нисгэгчийн хийх үйлдэлийг тодорхой зааварчилсан байх.

## **Ж БҮЛЭГ. ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

### **91.601. Үйлчлэх хүрээ**

(а) Энэ бүлэгт, Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн техник үйлчилгээний шаардлагыг тусгасан болно.

(б) Энэ бүлгийн 91.605 (д) 2/, 91.605 (д) 3/, 91.605 (д) 8/, 91.616, 91.617, 91.621, 91.623-д заасан шаардлагууд нь ИНД-103-т заасан хэт хөнгөн агаарын хөлөгт хамаарахгүй.

(в) Энэ бүлгийн 91.605 (д), 91.613, 91.615, 91.616, 91.617, 91.621, 91.623-д заасан шаардлагууд нь ИНД-104-т заасан планерт хамаарахгүй.

### **91.602 Нислэгийн өмнөх техник үйлчилгээний шаардлага**

(а) Энэ бүлгийн (б) ба 91.611-д зааснаас бусад тохиолдолд, 91.603, 91.605, 91.615-ын заалтуудыг биелүүлээгүй аливаа этгээд агаарын хөлгийг ашиглахгүй.

(б) Энэ бүлгийн (а) заалт нь ИНД-21-ийн Е Бүлгийн дагуу НТЧ-ын гэрчилгээ авсан этгээд агаарын хөлгийг ашиглах тусгай зөвшөөрөл авсан бол хамаарахгүй.

### **91.603. Техник үйлчилгээний ерөнхий шаардлагууд**

(а) Агаарын хөлөг ашиглагч нь дараах зүйлүүдийг бататгана:

- 1/ агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвар хадгалагдаж байгааг;
- 2/ ИНД-39-д холбогдох НТЧ-ын удирдамж (AD) мөрдөгдөж байгааг;
- 3/ агаарын хөлөг энэ бүлэгт заасны дагуу шалгагдсан гэдгийг;
- 4/ ажиллагаагүй ашиглаж болох хэрэглэл тоног төхөөрөмж нь энэ дүрмийн 91.537-д зааснаас бусад тохиолдолд нислэгийн өмнө засагдсан байхыг;
- 5/ 91.537-д заасан ажиллагаагүй ашиглаж болох аливаа эд анги, тоног төхөөрөмжийг тухайн агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу хийгдэх дараагийн үзлэг, шалгалтын үеэр зассан, сольсон, буулгасан буюу үзлэг шалгалт хийгдсэнийг;
- 6/ агаарын хөлгийн техник үйлчилгээ ИНД-43 болон холбогдох бусад дүрэмд заасны дагуу хийгдсэнийг;
- 7/ агаарын хөлөгт хийгдсэн аливаа техник үйлчилгээний дараа ИНД-43-ын шаардлагын дагуу техник үйлчилгээнээс гаргах баталгаажилт хийгдсэнийг.

(б) Үйлдвэрлэгчээс гаргасан НТЧ-ын хязгаарлалтыг дагаж мөрдөж байгааг Ашиглагч бататгана.

(в) Энэ зүйлийн (г) ба (д)-д зааснаас бусад тохиолдолд Ашиглагч нь үйлдвэрлэгчээс тогтоосон их засварыг хугацаанд нь хийгдсэнийг бататгана.

(г) ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн, эсхүл ИНД-91.607-гийн дагуу баталсан техник үйлчилгээний хөтөлбөрт үйлдвэрлэгчээс тогтоосон их засварын хоорондох хугацаанд тавигдах техник үйлчилгээний шаардлагаас багасгалгүй аливаа эд ангийг их засварын хоорондох хугацаанаас цааш ашиглаж болно.

(д) Энэ зүйлийн (г) заалтыг үндэслэн, поршинт хөдөлгүүр бүхий онгоцыг ашиг олох зорилгоор биш бол ИНЕГ-аас зөвшөөрсөн хөтөлбөр нь үйлдвэрлэгчээс гаргасан их засварын хоорондох хугацаанд тавигдах техник үйлчилгээний шаардлагаас багасгалгүй поршинт хөдөлгүүрийг их засварын хоорондох хугацаанаас цааш ашиглаж болно.

#### **91.605. Техник үйлчилгээний хөтөлбөр ба төлөвлөгөө**

(а) Агаарын хөлөг ашиглагч нь энэ зүйлийн (б), (в), ба (г)-д заасан агаарын хөлгийн техник үйлчилгээг дараах заалтын дагуу гүйцэтгэнэ:

- 1/ ИНД-119 хүрээнд батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу; эсхүл
- 2/ ИНД-91.607-ийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу; эсхүл
- 3/ Үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний хуваарийн дагуу; эсхүл
- 4/ Хэрэв поршинт хөдөлгүүрт агаарын хөлгийн хөөрөлтийн зөвшөөрөгдөх дээд жин нь 2730 кг-аас бага бол, ИНЕГ-аас зөвшөөрсөн техник үйлчилгээний хөтөлбөрт дараах зүйлийг багтаасан байна:
  - 4.1 агаарын хөлгийн техник үйлчилгээний стандарт болон үүрэг хариуцлага нь холбогдох дүрмийн шаардлагад нийцсэн бол;
  - 4.2 нислэгийн өмнөх үзлэг;
  - 4.3 хуваарьт техник үйлчилгээний үзлэг шалгалт.

(б) Агаарын хөлөг ашиглагч нь:

- 1/ ИНД-119-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-119-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэнэ;
- 2/ тусгай ангилалын НТЧ-ын гэрчилгээ эзэмшигч нь 91.607-гийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэнэ.

(в) Хэрэв энэ зүйлийн (а)-гийн 3/-т заасан, үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний хуваарийн хугацаанд агаарын хөлгийн ашиглалт 1 жилд 100 цаг хүрээгүй бол агаарын хөлгийг ашиглагч нь үйлдвэрлэгчийн 100 цагийн үзлэг, эсхүл түүнтэй адилтгах үзлэгийг үргэлжилсэн 12 сарын дотор хийж гүйцэтгэнэ.

(г) Хэрэв энэ зүйлийн (а)-гийн 3/-т заасан, үйлдвэрлэгчээс гаргасан техник үйлчилгээний хуваарийг хангалтгүй гэж үзвэл ИНЕГ-ын дарга нь тухайн агаарын хөлөг ашиглагчийг 91.607-ийн дагуу техник үйлчилгээний хөтөлбөрийг батлуулахаар ирүүлэхийг шаардаж болно.

(д) Агаарын хөлөг ашиглагч нь 91.611-ийн (е)-д зааснаас бусад дараах тохиолдолд агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:



- 1/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е.Бүлгийн дагуу суурилуулсан ХНД-д ашиглах холбооны төхөөрөмж нь ИНД-43-ын Хавсралт Б-ийн дагуу 24 сар тутмын үзлэг хийгдээгүй бол;
- 2/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е.Бүлгийн дагуу суурилуулсан статик даралтын систем, автомат хариулагч, өндөр мэдээлэх төхөөрөмж ба транспонд нь ИНД-43-ын Хавсралтын дагуу шалгаж баталгаажуулаагүй бол:
  - 2.1 24 сар тутамд;
  - 2.2 нөөц статик даралтын системийн цоргыг юүлэхээс бусад статик даралтын системийг задалж угсарсны дараа;
  - 2.3 автомат хариулагч системд техник үйлчилгээ хийж суурилуулсны дараа;
- 3/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е Бүлгийн дагуу суурилуулсан транспонд нь ИНД-43-ын Хавсралтын дагуу 24 сар тутмын үзлэг хийгдэж баталгаажуулаагүй бол;
- 4/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е Бүлгийн дагуу суурилуулсан ослын байршил дамжуулагч нь:
  - 4.1 406 Мгц ослын байршил дамжуулагчийг ИНД-43-ын Хавсралт Ж-гийн дагуу өмнөх 12 сар, эсхүл агаарын хөлгийн нислэгийн 100 цаг тутамд шалгаж баталгаажуулаагүй бол;
  - 4.2 406 Мгц ослын байршил дамжуулагчийг үйлдвэрлэгчээс гаргасан заалтын дагуу 24 сар тутамд шалгаагүй бол;
  - 4.3 406 Мгц ослын байршил дамжуулагчийн зай хураагуурыг үйлдвэрлэгчээс гаргасан заалтын дагуу баталгаат хугацаа нь дуусахад солиогүй бол;
  - 4.4 121.5 Мгц ослын байршил дамжуулагчийг ИНД-43-ын Хавсралт Ж-гийн дагуу өмнөх 12 сард шалгаж баталгаажуулаагүй бол;
  - 4.5 121.5 Мгц ослын байршил дамжуулагчийн зай хураагуурыг нөөцлөгдсөн хугацаа 1 цаг ажилласны дараа солиогүй бол;
  - 4.6 121.5 Мгц ослын байршил дамжуулагчийн зай хураагуурыг үйлдвэрлэгчээс гаргасан заалтын дагуу баталгаат хугацаа нь дуусахад солиогүй бол.
- 5/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е Бүлгийн дагуу суурилуулсан луужин бүрт тохируулгыг:
  - 5.1 24 сар тутамд;
  - 5.2 тохируулга хийх шаардлага гарсан бол.
- 6/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е Бүлгийн дагуу суурилуулсан эмнэлгийн анхны түргэн тусламжийн хэрэгслийг:
  - 6.1 12 сар тутамд зохих тоо хэмжээгээр нь, мөн хугацаа нь дууссан зүйлүүдийг сольж хийгээгүй бол;
  - 6.2 ашигласан зүйлээ нөхөж хийгээгүй бол.
- 7/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е Бүлгийн дагуу суурилуулсан гал унтраагуурыг үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу, эсхүл адилтгах ИНЕГ-аас хүлээн зөвшөөрч болох зааврын дагуу 12 сар тутам шалгаж баталгаажуулаагүй бол;
- 8/ агаарын хөлөгт энэ дүрмийн Е.Бүлгийн дагуу суурилуулсан хөвөгч төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу, эсхүл адилтгах ИНЕГ-аас хүлээн зөвшөөрч болох зааврын дагуу 12 сар тутам шалгаж баталгаажуулаагүй бол;
- 9/ агаарын хөлгийн хийцийн жин болон төвлөрөлтийг дахин тодорхойлоогүй бол:
  - 9.1 агаарын хөлгийн хийцийн жин болон төвлөрөлтөд нөлөөлж болох өөрчлөлт хийгдсэн;
  - 9.2 нислэгийн ашиглалтын зааврын дагуух тооцоолсон нарийвчлал алдагдсан байж болох мэдээлэл өгсөн тохиолдолд.

10/ зөвшөөрөгдөх суудлын тоо 4 болон түүнээс дээш, хөдөлгүүрт агаарын хөлгийн хийцийн хоосон жинг 10 жилийн хугацаанд дахин тодорхойлоогүй бол.

(е) Хэрэв агаарын хөлгийн ашиглагч нь энэ зүйлийн (а)-гийн 1/,эсхүл 2/-т заасан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэхдээ энэ зүйлийн (д)-гийн шаардлагыг үл харгалзан, техник үйлчилгээний хөтөлбөртэй адилтгах үзлэг хийсэн бол (д) заалтыг гүйцэтгэхгүй байж болно.

(ж) Агаарын хөлөг ашиглагч дараах үүрэгтэй:

- 1/ агаарын хөлөгт энэ зүйлийн (а)-д заасны дагуу техник үйлчилгээ хийгдсэнийг техник үйлчилгээний журналд тэмдэглэх;
- 2/ хэрэв Техник үйлчилгээний хөтөлбөр нь ИНД-119, эсхүл ИНД-91.607-гийн дагуу батлагдсан бол Техник үйлчилгээний хөтөлбөрт эрх бүхий этгээд техник үйлчилгээний хуваарийг тусгасан байх;
- 3/ техник үйлчилгээний хөтөлбөрт, эсхүл энэ зүйлийн (ж)-гийн 1/-д өөрчлөлтийг (а) заалтын өөр хөтөлбөрт сольж хийгдэх болбол агаарын хөлгийн НТЧ-ыг хадгалах зорилгоор шинээр хөтөлбөр, эсхүл хуваарь боловсруулсан байх;
- 4/ батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөр, эсхүл хуваарийг агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэх этгээдэд хүргүүлсэн байх.

#### **91.607. Техник үйлчилгээний хөтөлбөрийг батлах**

(а) 91.605-ын (а)-гийн 2/ -т заагдсан техник үйлчилгээний хөтөлбөр батлуулахаар хүсэлт гаргаж буй этгээд нь энэ зүйлийн (б)-д шаардсан баримт бичиг, ИНБД-д тусгагдсан өргөдлийн маягт, төлбөрийн баримтыг ИНЕГ-т ирүүлнэ.

(б) Техник үйлчилгээний хөтөлбөрт дараах бичиг баримтыг багтаасан байна:

- 1/ техник үйлчилгээний хөтөлбөрийн тайлбар;
- 2/ техник үйлчилгээнд хяналт тавих заавар;
- 3/ үзлэг шалгалтыг хариуцагч, бичилт мэдээллийн цуглуулга, хадгалалт, техникийн лавлах материалыг оролцуулсан хөтөлбөрийн тайлбар;
- 4/ шаардлагатай үзлэг, шалгалтыг багтаасан, тухайн агаарын хөлөгт гүйцэтгэх техник үйлчилгээний заавар, журам;
- 5/ нэмэлт үзлэгийн хуваарьт:
  - 5.1 үйлдвэрлэгчээс гаргасан зөвлөмж;
  - 5.2 үйлчилгээний дадал туршлага;
  - 5.3 тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааны төрөл.
- 6/ үзлэг хоорондын хугацааг 91.611-ийн дагуу сунгах заавар (шаардлагатай бол);
- 7/ хөдөлгүүр, сэнсний эд ангийг их засварт орох үзлэг хоорондын хугацааг өөрчлөх заавар (шаардлагатай бол);
- 8/ техник үйлчилгээний дадлага туршлагын улмаас үзлэг хоорондын хугацааг өөрчлөх заавар.

#### **91.609. Техник үйлчилгээний хөтөлбөр ба хуваарьт өөрчлөлт оруулах**

(а) Агаарын хөлөг ашиглагч нь техник үйлчилгээний хөтөлбөр ба хуваарьт өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг бичгээр гаргаж, ИНЕГ-аас шаардлагатай гэж үзвэл агаарын хөлгийн техник үйлчилгээний хөтөлбөрийг өөрчилнө.

(б) 91.607-гийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийг түр зогсоож буй ашиглагч нь:

- 1/ хөтөлбөрийг түр зогсоохоор төлөвлөсөн өдрөөс 7 хоногийн өмнө энэ тухай ИНЕГ-т бичгээр мэдэгдэнэ;
- 2/ батлагдсан техник үйлчилгээний өөр хөтөлбөрөөр сольж байвал, тухайн агаарын хөлгийн сүүлд хийсэн техник үйлчилгээний хугацаанаас хуваарийг хийнэ.

#### **91.611. Үзлэг төлөвлөх**

(а) Дүрмээр хориглосноос бусад тохиолдолд үйлдвэрлэгчээс гаргасан зөвлөмж, НТЧ-ын удирдамжийн дагуу 91.605-д шаардсан үзлэг хоорондын хугацааг 10% хүртэл сунгаж болно.

(б) Хэрэв энэ зүйлийн (а) заалтыг агаарын хөлөгт хэрэгжүүлэх бол:

- 1/ шинээр сунгасан огноо, агаарын хөлгийн нийт ажилласан цаг ба циклийн аль тохирохыг нь техник үйлчилгээний журналд, эсхүл техникийн бүртгэлд тэмдэглэсэн бол;
- 2/ дараагийн үзлэгийн хоорондох эхлэх хугацааг сунгалт хийгдсэн хугацаанаас давхардуулахгүй байхаар төлөвлөснийг бататгана.

#### **91.613. Шалгах нислэг**

(а) ИНД-43-ын дагуу техник үйлчилгээнээс гарсан агаарын хөлгөөр шалгалтын нислэг үйлдэх этгээд нь:

- 1/ зохих маягийн зэрэглэл эзэмшсэн нисгэгчийн үнэмлэхтэй байх;
- 2/ техник үйлчилгээ нь агаарын хөлгийн нислэгийн үзүүлэлтэд нөлөөлөхгүй гэдгийг шалгах;
- 3/ шалгах нислэгийн явцад гарсан дутагдлыг техникийн бүртгэлд тэмдэглэх.

(б) Энэ зүйлийн (а)-гийн дагуу шалгах нислэг үйлдэх нисгэгч нь тухайн шалгах нислэгт биечлэн оролцох үүрэг хүлээсэн этгээдийг нислэгт хамт явахыг зөвшөөрнө.

#### **91.615. Жил тутмын НТЧ-ын үзлэг**

(а) Энэ зүйлийн (б) ба (в)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд агаарын хөлгөөр нислэг үйлдэхгүй:

- 1/ хуанлийн, өмнөх 365 хоногийн дотор агаарын хөлөгт жил тутмын НТЧ-ын гэрчилгээ ИНД-43-ын Хавсралт Ж-гийн дагуу олгогдсон байх;
- 2/ хуанлийн, өмнөх 365 хоногийн дотор агаарын хөлөгт жил тутмын НТЧ гэрчилгээ ИНД-21-ийн дагуу олгогдсон байх.

(б) Энэ зүйлийн (а) хэсэг ИНД-119-ийн дагуу гэрчилгээ эзэмшсэн дараах агаарын тээвэрлэгчид хамаарахгүй:

- 1/ ИНД-121-ийн дагуу үйл ажиллагаа явуулдаг;
- 2/ ИНД-135-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээвэрлэгчийн агаарын хөлөг нь 135.67 (а) дагуу техник үйлчилгээний дүгнэлт хийгдсэн бол.

(в) Аливаа этгээд энэ зүйлийн (а)-гийн 1/ -д заасны дагуу жил тутмын үзлэг хийгдсэн агаарын хөлгөөр дараах тохиолдолд нислэг үйлдэж болно:

- 1/ дараагийн техник үйлчилгээг төлөвлөх хүртэл жил тутмын НТЧ-ын үзлэгийг техникийн бүртгэлд тэмдэглэснээс 36 хоногийн дотор байгаа бол; эсхүл
- 2/ жил тутмын НТЧ-ын үзлэгийг агаарын хөлгийн эзэмшигч бие даан гүйцэтгэсэн бол.

**91.616. Техник үйлчилгээний дэвтэр**

(а) Хэт хөнгөн онгоцноос бусад агаарын хөлөг ашиглагч нь дараах үүрэгтэй:

- 1/ агаарын хөлөг бүрт техник үйлчилгээний дэвтэртэй байх;
- 2/ техник үйлчилгээний дэвтрийг онгоцонд авч явахгүй байх.

**91.617. Техник үйлчилгээний тэмдэглэл хийх**

(а) Хэт хөнгөн онгоцноос бусад агаарын хөлөг ашиглагч нь их бие, эд анги, бусад туслах тоноглолуудын тухай агаарын хөлгийг үйлдвэрлэгчээс гаргасан их засвар хоорондох хугацааг шаардсан ажилласан цаг, циклийг техник үйлчилгээний дэвтэрт тодорхой тэмдэглэнэ.

(б) Хэт хөнгөн онгоцноос бусад агаарын хөлөг ашиглагч нь эд анги, бусад тоноглолуудад техник үйлчилгээ хийгдсэнийг ИНД-43-т заасны дагуу тэмдэглэл хийж бататгана.

(в) Агаарын хөлөг ашиглагч нь аливаа осол, зөрчилд орж эвдэрч гэмтсэн бол техник үйлчилгээний дэвтэрт тодорхой тэмдэглэл хийнэ.

(г) Энэ зүйлийн (а), (б), ба (в)-гийн шаардлагуудыг бичгээр, эсхүл кодолсон маягт, эсхүл бусад маягт дээр тэмдэглэн хадгална.

**91.619. Техникийн бүртгэл**

(а) Энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд ашиглагч нь агаарын хөлгийн техникийн бүртгэл /борт журнал/-д дараах зүйлсийг тэмдэглэнэ:

- 1/ тээвэрлэгчийн нэр;
- 2/ агаарын хөлгийн бүртгэл, төрөл, маяг;
- 3/ техник үйлчилгээ хийгдсэн агаарын хөлгийн 91.605-ын (а)-д заасан тодорхойлолт;
- 4/ агаарын хөлгийн техник үйлчилгээний талаарх тайлан:
  - 4.1 дараагийн хуваарьт үзлэгийн төрөл ба төлөвлөсөн огноо;
  - 4.2 ИНД-43-ын дагуу техник үйлчилгээнээс гаргасан агаарын хөлгийг шалгах нислэг хийгдсэн талаар.
- 5/ дараагийн хуваарьт үзлэгээс өмнө өөр техник үйлчилгээ хийх шаардлагатай огноо, эсхүл хугацаа;
- 6/ жил тутмын НТЧ, эсхүл техник үйлчилгээний дараагийн шалгалт хийх шаардлагатай өдөр;
- 7/ өдөр тутмын нислэгийн цаг;
- 8/ ашиглалтын нийт цаг;
- 9/ хэрэв шаардлагатай бол:

- 9.1 өдөр тутмын ажилласан цикл;
- 9.2 нийт цикл.

- 10/ нисгэгч нислэгийн үед, эсхүл нислэгийн дараа илрүүлсэн аливаа дутагдал;
- 11/ хуваарьт үзлэгүүдийн хооронд гарсан дутагдлуудыг зассан тухай, тэдгээр дутагдлуудыг арилган үйлчилгээнд гарахыг зөвшөөрсөн тэмдэглэл;
- 12/ 91.537-д заасны дагуу ажиллагаагүй төхөөрөмжтэй нислэг үйлдэх зөвшөөрөл олгогдсон агаарын хөлгийн ажиллагаагүй тоног төхөөрөмжийн засварыг хойшлуулсан тухай нарийвчилсан тэмдэглэл.

(б) Агаарын хөлөг ашиглагч нь энэ зүйлийн (а)-д заасан мэдээллийг техникийн бүртгэлд тэмдэглэн, уг мэдээллийн үнэн зөвийг баталгаажуулна.

(в) ИНД-119-ийн дагуу агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-аас зөвшөөрсөн бол техникийн бүртгэлээс өөр хэлбэрээр дараах мэдээллийг тэмдэглэнэ:

- 1/ дараагийн техникийн үзлэг явуулах огноо болон цаг;
- 2/ техникийн үзлэг хийгдэхээс өмнөх техник үйлчилгээний огноо ба цаг;
- 3/ ашиглалтын нийт цаг;
- 4/ нийт цикл.

#### **91.621. Техник үйлчилгээний бичиг баримтыг шилжүүлэх**

(а) ИНД-47-гийн дагуу өөр этгээдэд бүртгэл шилжүүлж буй Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч нь бүртгэл шилжүүлэх тухайн хугацаанд дараах зүйлийг бусад этгээдэд шилжүүлнэ:

- 1/ 91.617-гийн (б)-д заасан тэмдэглэл;
- 2/ энэ хэсгийн 1/-ийн дагуу шилжүүлж буй бүртгэлд хамрагдаагүй 91.617-гийн (а)-ийн 1/-д тусгасан тэмдэглэл.

#### **91.623. Бичиг баримтыг хадгалах**

(а) Энэ дүрмийн (б), (в)-д зааснаас бусад тохиолдолд агаарын хөлөг ашиглагч нь 91.617-д тусгасан баримт бичгийг тухайн агаарын хөлгийн эд ангиудыг ашиглалтаас хассанаас хойш 12 сарын хугацаанд хадгална.

(б) ИНД-43.69-ийн (а)-гийн дагуу бичиг баримтын хөтлөлтийг техник үйлчилгээг давтагдах, ижил цар хүрээ бүхий өөр ажлаар орлуулах, эсхүл тухайн ажлыг гүйцэтгэж дууссанаас хойш 5 жил буюу эдгээр хугацааны аль нэг нь эхэлж тохиох хүртэл хадгална.

(в) Энэ зүйлийн (а), (б) хэсэг нь агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, сэнс болон роторт үл хамаарана.

(г) Ашиглагч нь 91.619 –д шаардсан техникийн бүртгэлийг дууссанаас хойш 12 сарын хугацаанд хадгална.

### **3 БҮЛЭГ. ТУСГАЙ НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

#### **91.701. Уран жолоодлогын нислэг**

(а) Энэ зүйлийн (д)-д зааснаас бусад тохиолдолд, дор дурдсан бүсэд аливаа этгээд уран жолоодлогын нислэг үйлдэхгүй:

- 1/ хот, тосгон буюу суурин газрын дээгүүр 600 метрийн /2000фут/ хэвтээ зайд;
- 2/ хүн ам шигүү суурьшсан бүсийн дээгүүр 600 метрийн /2000фут/ хэвтээ зайд;
- 3/ НХУ-аас зөвшөөрөл олгоогүй бол, аливаа удирдлагатай агаарын зайд.

(б) Аливаа этгээд, харьцангуй өндөр нь 900 метр /3000фут/-ээс нам үед энэ зүйлийн (в)-д зааснаас бусад тохиолдолд уран жолоодлогын нислэг үйлдэхгүй.

(в) Нисгэгч дараах тохиолдолд харьцангуй өндөр нь 900 метр /3000фут/-ээс нам үед уран жолоодлогын нислэг үйлдэж болно:

- 1/ хэрэв ИНД-61-ийн дагуу уран жолоодлогын зэрэглэл эзэмшсэн бол газрын газаргуугаас 450 метрээс дээш өндөрт;
- 2/ хэрэв дараах нөхцлийг хангасан бол газрын гадаргуугаас 450 метрээс нам өндөрт:
  - 2.1 ИНД-61-ийн дагуу, нам өндөрт уран жолоодлогын нислэгт зөвшөөрөгдсөн зэрэглэл эзэмшсэн;
  - 2.2 уран жолоодлогын зэрэглэлд зөвшөөрөгдсөн өндөр нь 450-аас доош бол;
  - 2.3 үзүүлэх нислэгт оролцож байвал.

(г) Агаарын хөлгөөр уран жолоодлогын нислэгт аливаа этгээдийг дор зааснаас бусад тохиолдолд тээвэрлэхгүй:

- 1/ ИНД-61-ийн дагуу уран жолоодлогын зэрэглэл эзэмшсэн бол;
- 2/ нислэгийг газрын гадаргуугаас 900 метрээс дээш өндөрт гүйцэтгэх бол.

(д) Хэрэв нисгэгч нь энэ дүрмийн 91.703-д заасны дагуу үзүүлэх нислэгт оролцож байвал үзэгчдээс 600 метрийн зайд нислэг үйлдэж болно.

### **91.703. Үзүүлэх нислэг**

(а) ИНЕГ-аас зөвшөөрөл олгоогүй бол, аливаа этгээд үзүүлэх нислэг зохион байгуулах буюу үзүүлэх нислэгт оролцохгүй.

(б) Үзүүлэх нислэг зохион байгуулах зөвшөөрөл авахаар өргөдөл гаргаж буй этгээд нь уг арга хэмжээг эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө төлөвлөгөөгөө ИНЕГ-т ирүүлнэ.

(в) Энэ зүйлийн (б)-д шаардсан төлөвлөгөө нь:

- 1/ дараах мэдээллийг агуулсан байна:
  - 1.1. зохион байгуулагчийн нэр, албан тушаал, хаяг;
  - 1.2. зохион байгуулах газар, огноо, цаг;
  - 1.3. арга хэмжээний хэлбэр;
  - 1.4. зохион байгуулалтын талаарх нарийвчилсан мэдээлэл ба арга хэмжээнд хяналт тавих этгээд;
  - 1.5. нислэгийн хөтөлбөрийн талаарх нарийвчилсан мэдээлэл;
  - 1.6. энэ зүйлийн (г)-д заасан шаардлагыг биелүүлэхийн тулд арга хэмжээ зохиогдох газрын талаарх нарийвчилсан төлөвлөгөө ба танилцуулга;
  - 1.7. шоуг сонирхогчдын аюулгүй байдлыг хангах талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
  - 1.8. аваарын болон шуурхай үйлчилгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

2/ ИНЕГ-ын даргаас хүлээн зөвшөөрөгдсөн байна.

(г) Үзүүлэх нислэгт оролцож буй агаарын хөлгийн дарга нь:

- 1/ хөдөө аж ахуйн буюу нисдэг тэрэгний нислэгээс бусад, дэлгэцээр хянаж болох хэрэглэлийн нислэгт газрын гадаргуугаас дээш 30 метрээс доошгүй өндөрт ниснэ;
- 2/ аливаа этгээдийг тээвэрлэхгүй;
- 3/ үзэгчдийн байрлаж буй газрын ойролцоо нислэг үйлдэхгүй;
- 4/ хамгаалалтын шугам болон үзэгчийн талбайн хооронд ямар нэгэн маневр үйлдэхгүй;
- 5/ дүүжин нислэг үйлдэж байгаа буюу явгалж буй нисдэг тэрэгнээс бусад тохиолдолд, үзэгчдийн талбайн ойролцоо ямар нэгэн маневр үйлдэхгүй.

#### **91.705. Шүхэр буулгах нислэг**

(а) Шүхэрчид буулгах нислэг үйлдэж буй нисгэгч нь ИНД-61-ийн дагуу шүхэр буулгах тусгай зэрэглэл эзэмшсэн байна.

(б) Шүхэрчид буулгах нислэг үйлдэж буй нисгэгч нь дараах зүйлийг баталгаажуулсан байна:

- 1/ шүхэрчид буулгах нислэг үйлдэж байгаа тухайн агаарын хөлөг нь НТЧ-ын стандарт ангиллын хүчин төгөлдөр гэрчилгээтэй;
- 2/ тухайн агаарын хөлгийн бүтэц, тоноглол нь шүхэр буулгах нислэгт тохирсон;
- 3/ тухайн агаарын хөлөг нь шүхэрчдэд тохирсон шаардлага хангасан тасалгаа, хаалгатай;
- 4/ тухайн агаарын хөлөгт шүхэр задлах буюу шүхэрчинг хаалгаар гарах үед нөлөөлж болох бариул, дэгээ байхгүй;
- 5/ агаарын хөлгөөс шүхрийг албадан задлах уяаг бэхлэх төхөөрөмж байрлуулсан;
- 6/ тухайн агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт, нислэгийн үед хаалгыг салгаж тусгаарлах эсхүл нээх үйлдлийг зөвшөөрсөн.
- 7/ шүхэрчдээс бусад этгээд нь:
  - 7.1 хөөрөх, буух үед суудалдаа сууж, хамгаалах бүсийг бэхэлсэн;
  - 7.2 аврах буюу нөөц шүхрийг зүүсэн;
  - 7.3 аврах буюу нөөц шүхрийг ашиглах талаар бэлтгэгдсэн;
  - 7.4 онцгой нөхцлийн үед агаарын хөлөгт дагаж мөрдөх ерөнхий журмын талаар мэдээлэл авсан байна.
- 8/ шүхрээр буух хүмүүс нь:
  - 8.1 агаарын хөлгийн аюулгүй байдалд ноцтой нөлөөлж болох байрлалд суугаагүй;
  - 8.2 онцгой нөхцлийн үед агаарын хөлөгт дагаж мөрдөх ерөнхий журмын талаар мэдээлэл авсан байна.

(в) Дараах тохиолдолд шүхэрчид буулгах нислэг үйлдэж буй нисгэгч нь аливаа этгээдийг агаарын хөлгөөс шүхрээр буулгахгүй:

- 1/ тухайн этгээд нь буултын талаарх төлөвлөсөн мэдээллийг агаарын хөлөг хөөрөхөөс өмнө нисгэгчид өгөөгүй бол;
- 2/ тухайн нисгэгч нь:
  - 2.1 ИНД-149-ийн дагуу олгосон гэрчилгээ эзэмшигчээс зөвшөөрөл аваагүй бол;
  - 2.2 төлөвлөсөн буултыг ИНЕГ-аас зөвшөөрөөгүй бол.

**91.707. Нөөц шүхэр**

(а) Агаарын хөлгийн дарга, онцгой нөхцөл байдлын үед хэрэглэх нөөц шүхэр нь доорх шаардлагыг хангаагүй бол түүнийг нислэгт ашиглахыг зөвшөөрөхгүй:

- 1/ шүхэр нь энэ дүрмийн Хавсралт 24-д заасан шаардлагыг хангаагүй бол;
- 2/ шүхрийг хийсэн материалд сөрөг нөлөө үзүүлж болох аливаа нөхцөл болон бодисоос тэдгээрийг зохих ёсоор хамгаалаагүй бол;
- 3/ үйлдвэрлэгчээс өгсөн зааврын дагуу хадгалж, дараах этгээд урьд нь эвхэж боогоогүй бол:
  - 3.1 ИНД-149-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч байгууллагаас зөвшөөрсөн шүхэртэй харьцах тусгай эрх эзэмшигч;
  - 3.2 тухайн шүхрийг үйлдвэрлэгч;
  - 3.3 ИНЕГ-аас бусад, эрх мэдэл бүхий албан тушаалтнаас эрх олгогдсон этгээд.
- 4/ тухайн шүхрийг хадгалсан буюу эвхэж боосон этгээдээс ажиллагаатайг нь гэрчлэх бичиг баримтыг дагалдуулж ирүүлээгүй бол.

**91.709. Планер чирэх**

(а) ИНД-61-ийн дагуу планер чирэх зэрэглэлгүй аливаа этгээд планер чирэхийг хориглоно.

(б) Дараах шаардлага хангагдаагүй тохиолдолд аливаа этгээд планер чирэх нислэг үйлдэхийг хориглоно:

- 1/ чирэх агаарын хөлөг нь планерын зөвшөөрөгдөх хамгийн их хурдаас доош хурдтай нислэг үйлдэх боломжтой;
- 2/ чирэх ачаалал нь агаарын хөлгийн нислэгийн ашиглалтын зааварт тусгасан хамгийн их ачааллын хэмжээнээс хэтрээгүй байх;
- 3/ тухайн этгээд нь планер чирэх дэгээ, холбоосыг нислэг эхлэхийн өмнө шалгасан байх;
- 4/ тухайн этгээд нь ИНД-149-ийн дагуу гэрчилгээ эзэмшигч байгууллагаас тогтоосон хөөрөлт, планерыг суллах журам, нислэгийн хурд, аваарын дохиоллуудыг хэрэглэсэн байх;
- 5/ планер болон чирэгчийн 15 метр /50 фут/ хүртэл өндөр авах хөөрөлт үйлдэх зай нь ХБЗ-ны хөөрөлтийн боломжит зайн /TODA/ 85%-иас хэтрэхгүй байх;
- 6/ планер чирч байгаа агаарын хөлөг нь аэродромоос дээш 300 метрийн /1000фут/ өндөрт хамгийн бага нь 1м/сек-ээс (200фут/мин) доошгүй босоо хурдтай өндөр авах чадвартай байх.

(в) Аливаа этгээд дараах нөхцөлд планер чирэх нислэг үйлдэхгүй:

- 1/ агаарын хөлөгт дор дурдсан зүйлийг тоноглоогүй бол:
  - 1.1 чирэх дэгээ, холбох хэрэгсэл;
  - 1.2 чирэх дэгээнээс аль ч чиглэлд 450кг хүртэл жинтэй ачаалал өгөхөд нисгэгчийн тусламжтайгаар чирэх холбоосыг хурдан тайлагч механизм.
- 2/ энэ дүрмийн Хавсралт 25-д заасан шаардлагыг хангасан чирэх холбоосгүй бол;
- 3/ хэрэв 1-ээс олон планер чирэх бол чирэх холбоос нь:
  - 3.1 планер тус бүрд нэг байх;
  - 3.2 планер болон чирч буй агаарын хөлгийн хооронд 50 м-ээс доошгүй зайтай байх;
  - 3.3 бүх планерын хооронд 30 м-ээс доошгүй зайтай байх;



3.4 агаарын хөлгөөс салгаж болох чирэх нэг цагирагт холбогдсон байх.

**91.711. Планераас бусад зүйлийг чирэх**

(а) Аливаа этгээд дараах нөхцөлд планераас бусад зүйлийг чирэхгүй:

1/ тухайн этгээд нь:

- 1.1 ИНД-61-ийн дагуу хувийн нисгэгчийн үнэмлэх ба планер бусад зүйлийг чирэх нислэгийн зэрэглэл эзэмшээгүй бол; эсхүл
- 1.2 ИНД-61-ийн дагуу коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй бол; эсхүл
- 1.3 ИНД-61-ийн дагуу агаарын тээврийн нисгэгчийн үнэмлэх эзэмшээгүй бол.

2/ агаарын хөлөг нь:

- 2.1 хурдан тайлагддаг мехнизмтэй чирэх дэгээ ба бусад туслах хэрэгслээр тоноглогдоогүй бол;
- 2.2 нислэг үйлдэх тухайн өндөрт өндөр авах чадваргүй бол.

(б) Нисгэгч нь планераас бусад зүйл чирэх агаарын хөлгөөр аливаа этгээдийг тээвэрлэхгүй.

**И БҮЛЭГ. ГАДААДАД БҮРТГЭЛТЭЙ АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙН ГАДНА НИСЛЭГ ҮЙЛДЭЖ БУЙ, МОНГОЛ УЛСАД БҮРТГЭЛТЭЙ АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

**91.751. Үйлчлэх хүрээ**

(а) Энэ бүлэг нь, Монгол Улсын агаарын зайн гадна нислэг үйлдэж буй Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг, мөн Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэж буй гадаадад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаанд хамаарна.

**91.753. Монгол Улсын агаарын зайн гадна нислэг үйлдэж буй Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа**

(а) Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгөөр нислэг үйлдэх аливаа этгээд дор дурьдсан бичиг баримтад заасан шаардлагыг биелүүлнэ:

- 1/ усан дээгүүр нислэг үйлдэх бол Чикагогийн конвенцийн Хавсралт 2-т заасан шаардлага;
- 2/ гадаад улсын агаарын зайд нислэг үйлдэх бол тухайн улсын үйл ажиллагааны болон нислэгийн дүрэмд заасан шаардлага.

**91.755. Гадаадын агаарын хөлгийн үйл ажиллагааны тусгай дүрмүүд**

(а) **Ерөнхий зүйл.** Гадаадад бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх этгээд нь энэ дүрмийн холбогдох бусад шаардлагаас гадна энэ зүйлд заасан журмыг дагаж мөрдөнө.

(б) **ИХНД.** Тухайн агаарын хөлгийн нисэх багийн гишүүдээс нэг нь нислэгийн хугацаанд НХУ-аас шаардсан хэл дээр хоёр талын радио холбоо барих боломжгүй байвал, энэ дүрэмд заасан хоёр талын радио холбоо шаардсан агаарын зайд ИХНД-ээр нисэхгүй.

(в) **ХНД.** Дараах нөхцөлд ХНД-ээр нислэг үйлдэхгүй:

1/ агаарын хөлөг нь:

- 1.1 НХУ-тай агаарын зайд нисэхэд НХУ-ний байгууллагатай хоёр талын радио холбоо барих радио төхөөрөмжгүй бол;
- 1.2 нислэгийн төлөвлөгөөнд заасны дагуу нислэгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд ашиглах навигацийн төхөөрөмжөөр тоноглогдоогүй бол.

2/ нисгэгч нь:

- 2.1 Монгол Улсаас, эсхүл ИCAO-гийн гишүүн улсаас олгосон хэрэглэлийн нислэгийн зэрэглэлгүй бол;
- 2.2 агаарын замын, хүлээх бүсийн, ойртолтод хамаарах улсын нислэгийн холбогдох дүрмүүдтэй танилцаагүй бол.

3/ тухайн агаарын хөлгийн нисэх багийн гишүүдээс нэг нь ХНД-ээр нисэх хугацаанд хоёр талын радио холбоог НХУ-аас шаардсан хэл дээр харилцах боломжгүй бол.

## **К БҮЛЭГ. ДУУ ЧИМЭЭНИЙ ХЯЗГААРЛАЛТ**

### **91.801. Зорилго**

(а) Энэ бүлэгт, иргэний агаарын хөлгийн дуу чимээний ба хөдөлгүүрээс гарах хорт утааны хязгаарлалтыг тогтооно.

### **91.803. Агаарын хөлгийн дуу чимээний зөвшөөрөгдөх хэмжээ**

(а) Аливаа этгээд дор зааснаас бусад тохиолдолд агаарын хөлгөөр аэродром руу ба аэродромоос нислэг үйлдэж болно:

- 1/ Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг нь ИНД-21-ийн Хавсралт В-д заасан шаардлагыг биелүүлсэн;
- 2/ гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг нь Чикагогийн конвенцийн Хавсралт 16-гийн 1-р хэсэгт заасан стандартын дагуу гэрчилгээжсэн.

(б) Аливаа этгээд энэ зүйлийн (а)-д заасныг үл хамааран, тийрэлтэт ба хүрдэн тийрэлтэт хөдөлгүүрт онгоцоор Монгол Улсад Чикагогийн конвенцийн Хавсралт 16-гийн 1-р хэсгийн Дэд бүлэг 3-д заасан дуу чимээний стандартын дагуу гэрчилгээжсэнээс бусад үед дуунаас илүү хурдтай нислэг үйлдэхгүй.

### **91.805. Агаарын хөлгийн дууны хурдны долгион**

(а) Аливаа этгээд, ИНЕГ-аас үйл ажиллагаанд нь тусгай зөвшөөрөл олгогдоогүй бол агаарын хөлгөөр дууны хурдад харьцуулсан М тоогоор 0.92-оос их хурдтайгаар нислэг үйлдэхгүй.

(б) Агаарын хөлгийн нислэгийн зөвшөөрөгдөх боломжит хурд нь дууны хурдад харьцуулсан М тоогоор 0.92-оос их боловч Монгол Улсын агаарын зайд дууны хурдны долгион нь газрын гадаргууд хүрэхгүй бол агаарын хөлгийн дарга нислэг үйлдэхгүй.

(в) Дууны хурдад харьцуулсан М тоогоор 0.92-оос их хурдтай нислэг үйлдэх агаарын хөлгийн дарга нислэгийн хязгаарлалтын шаардлагыг биелүүлнэ.

### **91.807. Хөдөлгүүрээс гарах хорт утааны зөвшөөрөгдөх хэмжээ**

(а) Аливаа этгээд дор зааснаас бусад тохиолдолд агаарын хөлгөөр аэродром руу ба аэродромоос нислэг үйлдэж болно:

- 1/ Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөг нь ИНД-21-ийн Хавсралт В-д заасан шаардлагыг биелүүлсэн;
- 2/ гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлөг нь Чикагогийн конвенцийн Хавсралт 16-гийн 2 дугаар хэсгийн стандартын дагуу гэрчилгээжсэн.

#### **ХАВСРАЛТ А. ХЭРЭГЛЭЛ БА ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШААРДЛАГА**

Энэ дүрмийн Е Бүлэгт шаардсан хэрэглэл, тоног төхөөрөмжүүд нь дараах шаардлагыг хангасан байна:

##### ***A1. Тэмдэглэгээ ба зурагт хуудас***

(а) Бүх тэмдэглэгээ, зурагт хуудасны үсэг арилах, эвдрэх, ойлгомжгүй байх, унахаас хамгаалагдсан байх бөгөөд ил харагдах газар байрлуулна.

(б) Тэмдэглэгээ буюу зурагт хуудсанд хэрэглэж буй хэмжлийн нэгж нь холбогдох хэрэглэл дээр буюу нислэгийн зааварт хэрэглэж буй нэгжтэй ижил байна.

##### ***A2. Шатахуун ба тосны тэмдэглэгээ***

(а) *Шатахуун ба тосны хэмжүүр.* Тээвэрлэгч, үйлдвэрлэгчид захиалсан хувилбараас хамаарч шатахуун ба тосны хэмжүүр нь кг, литр, фунтээр тохируулсан, тохируулгыг тухайн нэгжээр хийсэн гэдгийг харагдахаар, ойлгомжтой тэмдэглэсэн байна.

(б) *Шатахуун ба тосны зурагт хуудас.* Агаарын хөлөгт бүх шатахуун ба тосны савны дэргэд түлш буюу тосны сорт, тодорхойлолтыг тусгасан зохих зурагт хуудсыг наасан байна.

##### ***A3. Суудал***

Бүх суудал буюу түшлэгтэй сандал нь АНУ-ын техникийн стандарт (Technical standard order-TSO) C25, эсхүл TSO C39-д заасан шаардлагыг хангасан байна.

##### ***A4. Хамгаалах бүс***

(а) Бүх хамгаалах бүс нь АНУ-ын TSO C22-д заасан шаардлагыг хангасан байна.

(б) Хамгаалах ташуу буюу мөрөвчтэй хамгаалах бүс нь АНУ-ын TSO C114-д заасан шаардлагыг хангасан байна.

##### ***A5. Хүүхдийн тусгай суудал***

Хүүхдийн тусгай суудал нь:

- 1/ АНУ-ын TSO C22-д заасан шаардлагыг хангасан хамгаалах бүсээр агаарын хөлгийн сандалд бэхлэгдсэн;
- 2/ Хүүхдийн тусгай суудал нь агаарын хөлөгт ашиглахыг зөвшөөрсөн байна.

**A6. Агаарын хөлгийн гэрлүүд**

(а) Агаарын хөлгийн мөргөлдөхөөс хамгаалах гэрлийн систем нь дараах зүйлээс бүрдсэн байна:

- 1/ эргэлддэг улаан гэрлэн дохио /маяк/;
- 2/ дараах шаардлагыг хангасан /capacitor discharge light/-ын зарчмаар ажилладаг цагаан, эсхүл улаан гэрлэн дохио;
  - 2.1 АНУ-ын TSO C96;
  - 2.2 агаарын хөлгийн маягийн стандарт
  - 2.3 ИНЕГ-ын хүлээн зөвшөөрсөн бусад стандарт.

(б) Агаарын хөлгийн байрлалын гэрэл нь АНУ-ын TSO C30-д заасан шаардлагыг хангасан байна.

**A7. Агаарын хөлгийн нислэгийн цагийг мэдээлэх төхөөрөмж**

Агаарын хөлгийн нислэгийн цагийг мэдээлэх төхөөрөмж нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрсөн стандарт шаардлагыг хангасан байна.

**A8. Өндөр хэмжигч**

(а) 7600м /25000 фут/-ээс дээш үнэмлэхүй өндөрт нислэг үйлдэх битүүмжлэгдсэн агаарын хөлгийн бүх өндөр заагч нь:

- 1/ хөөрөлтийн хамгийн их хүнд нь 5700 кг хүртэлх агаарын хөлөгт:
  - 1.1 агаарын хөлгийн даргын өмнө тоо буюу зүүгээр өндөр заагч хүрд хэлбэрт /drum pointer/ хэрэглэл байна;
  - 1.2 багийн бусад гишүүдийн ажлын байранд тоо буюу зүүгээр заагч хүрд хэлбэрт өндрийн хэрэглэлүүд байна.

2/ Хөөрөлтийн хамгийн их хүнд нь 5700 кг-аас дээш агаарын хөлөгт:

- 2.1 агаарын хөлгийн даргын өмнө тоогоор заагч өндрийн хэрэглэл байна;
- 2.2 багийн бусад багийн гишүүдийн ажлын байранд тоон заагч болон хүрд хэлбэрт өндөр заагч хэрэглэл байна.

(б) 7600 м /25000 фут/-ээс доош үнэмлэхүй өндөрт хэрэглэлээр нислэг үйлдэх агаарын хөлөгт бүх өндөр заагч нь тоон заагч хэрэглэлүүд байна.

(в) Зүүгээр заагч өндрийн хэрэглэл нь үнэмлэхүй өндөр 3000 м (10000 фут) хүртэл харагдаж болох тэмдэглэгээ бүхий бага өндрийг анхааруулах сектортой байх бөгөөд уг сектор нь 30 м (100 фут)-ээр заах хуваарьтай байх ба:

- 1/ өөр аль нэгэн зүүнд халхлагдахгүй 300 м (1000 фут)-ийн хуваарь;
- 2/ 300 м (1000 фут)-ийн интервалыг заасан нэг гол дээр эргэх;
- 3/ энэ зүйлийн (в)-гийн (1), (2)-т заасан үзүүлэлт хамт байна.

(г) Даралтын өндөр заагч бүр нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ АНУ-ын TSO C10;
- 2/ Гектопаскалаар хэмжигдэх барометрийн даралтад тохирсон байх бөгөөд 60 м (200 фут)-ийн үнэмлэхүй өндрийг хялбар унших боломжтой байхаар харагдаж байна.

(д) Нарийвчлал сайтай өндөр заагч шаардлагагүй агаарын хөлөг нь 60 м (200 фут)-ээс их биш үнэмлэхүй өндрийн өсөлтөд тохирсон өндрийн хэрэглэлтэй байна.

#### **A9. Холбоо навигацййн төхөөрөмж**

(а) Холбоо, навигацййн төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ холбооны аль нэг төхөөрөмж нь АНУ-ын TSO-ийн C31, C32, C37, C38, C50-ийн аль нэгийн шаардлагыг хангасан;
- 2/ навигацййн аль нэг төхөөрөмж нь АНУ-ын TSO-ийн C34, C35, C36, C40, C41, C60, C94, C129-ийн аль нэгийн шаардлагыг хангасан;
- 3/ компасаас аюулгүй зайд байна.

(б) Хоёр радио холбооны систем шаардлагатай бол:

- 1/ систем тус бүр антеннтай байна;
- 2/ тухайн 2 систем нь нэг тулгуурт бэхлэгдсэн утасгүй антенныг ашиглаж болно.

#### **A10. RNP, MNPS, RVSM төхөөрөмж**

RNP, MNPS, RVSM агаарын зайд үйлдэх нислэгт зориулан суурилуулсан навигацййн систем ба төхөөрөмж нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ ICAO-ын Doc7030-д заасан, тухайн агаарын зай болон нислэг үйлдэх маршрутад хэрэглэх шаардлагууд;
- 2/ RNP агаарын зайд үйлдэх нислэгт INS, IRS/FMS, GPS-ээс бүрдсэн 2 алсын зай навигацййн систем /LRNS/;
- 3/ тоног төхөөрөмж ба ажиллагааны шаардлагууд нь дараах бичиг баримтад заагдсан:
  - 3.1 RNP агаарын зайд үйлдэх нислэгт – Doc 9613;
  - 3.2 8840 метрээс /FL 290/ дээш 300м /1000 feet/-ийн багасгасан босоо зайчлал /RVSM/-аар тогтоогдсон агаарын зайд үйлдэх нислэгийн хувьд - Doc 9574.

#### **A11. CAT II, CAT III-т шаардагдах төхөөрөмж**

(а) ILS-ийн курс глиссадын төхөөрөмж нь DO-117 "Radio Technical Commission for Aeronautics (RTCA )" -д заасан шаардлагыг хангасан байна.

(б) Нислэгийн удирдлага хяналтын систем нь үнэлгээний хөтөлбөрт заасан шаардлагыг хангасан байна.

(в) Радио өндөр хэмжигч бүр нь:

- 1/ газрын гадаргуугаас үндсэн дугуй хүртэлх өндрийн хэмжээг  $\pm 1,5$  м ( $\pm 5$  фут) буюу 5%-ийн нарийвчлалтайгаар дор дурьдсан үед нисэх багт үзүүлнэ:
  - 1.1 тангаж нь буултын оролтын дундаж өнцгөөс  $\pm 5$  градус байх үед;
  - 1.2 крен нь аль ч тал руу 20 градус байх үед;
  - 1.3 давших хурд нь ойртолт үйлдэх хамгийн бага хурд ба 370 км\ц /200 узель/-ийн хооронд байх үед;
  - 1.4 30 м /100 фут/-ээс 60 м /200 фут/ хүртэлх үнэмлэхүй өндөрт өндөр алдах босоо хурдны хэмжээ нь 15 Ф/сек-ээс их биш байх үед;
  - 1.5 тэгш гадаргуу дээр бодит өндрийн заалт нь мэдэгдэхүйц хоцорсон буюу савлалт байхгүй үед;

- 2/ агаарын хөлөг нь 60 м /200 фут/-ийн үнэмлэхүй өндрөөс доош байх үед газрын гадаргуугын өндрийн өөрчлөлт тухайн агаарын хөлгийн үнэмлэхүй өндрийн 10%-нь болох бол:
  - 2.1 дэлгэц нь 0.1 секундын дотор хариулах;
  - 2.2 хэрэв радио өндөр заагч дахин ажиллавал дохиог 1 секундээс бага хугацаанд авна.
- 3/ 150 метрээс /500 фут/ доош өндөрт ажиллагааг шалгах товчийг ашиглаж байвал энэ өндрөөс доош системд хийгдэх бүх тест явагдана;
- 4/ цахилгаан тэжээлгүй болох, эсхүл газраас буцаж ойсон дохио алга болох гэх мэт ажиллагааны гэмтлийг анхааруулах дохио ямар ч үед гарч болохыг тооцож байх.

(г) Бусад хэрэглэл, төхөөрөмж нь 91.417-т заагдсан Тээвэрлэгчийн үйл ажиллагааны зааварт дурдсаны дагуу CATII, CATIII нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх хүчин чадалтай байх ёстой.

### **A12. Эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл**

Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэл нь:

- 1/ алдагдах, эсхүл муудаж чанараа алдах зэрэг аливаа эрсдлийг багасгасан саванд хадгалагдсан байна.
- 2/ дараах байдлаар байрлуулсан байна:
  - 2.1 осол аваар гарах үед гэмтэх, асгарах зэрэг эрсдэл бага байхаар;
  - 2.2 агаарын хөлгөөр зорчиж буй хүмүүст аюул учруулахгүй байхаар.
- 3/ байрлалын тэмдэглэгээг:
  - 3.1 тухайн хэрэгслийг хадгалж буй савны гадна талд;
  - 3.2 хөөрөлтийн дээд жин нь 5700 кг-аас хэтрэхгүй агаарын хөлгийн хувьд гадна талд нь хийсэн байна.
- 4/ мансууруулах бодис агуулсан эмнэлгийн анхны тусламжийн хэрэгслийг түгжээтэй саванд, аюулгүй байрлалд хадгална.

### **A13. Гал унтраагч**

Бүх гал унтраагч нь :

- 1/ агаарын хөлгийн аюулгүй ажиллагаа болон багийн гишүүд, зорчигчдын аюулгүй байдалд ноцтой нөлөөлөхгүй байрлалд суурилагдаж, бэхлэгдсэн байна;
- 2/ энэ зүйлийн (4)-ийн хүрээнд, гал унтраагч нь гарч болзошгүй галын төрөлд тохирох төрөл, тоо хэмжээтэй байна;
- 3/ хортой хийнээс гарах эрсдлийг багасгасан байна;
- 4/ зөвхөн гал унтраах зориулалтын дараах зүйлийг агуулсан байна:
  - 4.1 бромхлоридфлуорметан (halon 1211);
  - 4.2 бромтрифлуорметан (halon 1301);
  - 4.3 нүүрстөрөгчийн давхар исэл;
  - 4.4 хуурай нунтаг буюу химийн хуурай хор;
  - 4.5 гал унтраах зориулалтын бусад бодис, хэрэглэл.

### **A14. Аврах тоног төхөөрөмж**

(а) Аврах бүх тоног төхөөрөмж нь АНУ-ын TSO C85-д заасан шаардлагыг хангасан байна.

(б) Аврах завь АНУ-ын TSO C70-д заасан шаардлагыг хангасан, авран хамгаалах хэрэгслийг агуулсан байна.

(в) Авран хамгаалах хэрэгсэлд дараах зүйлийг багтаана:

- 1/ завины бүрхүүл - нэг;
- 2/ локаторын долгион ойлгогч - нэг,
- 3/ завь нөхөгч - нэг;
- 4/ завины ус шавхагч - нэг;
- 5/ дохионы толь - нэг;
- 6/ шүгэл - нэг;
- 7/ завины хутга - нэг;
- 8/ завь хийлэхэд зориулсан даралттай агаар бүхий баллон - нэг;
- 9/ завь хийлэгч гар насос- нэг;
- 10/ 25 м урттай аврах олс;
- 11/ соронзон луужин – нэг;
- 12/ усны өнгө хувиргагч будаг-нэг;
- 13/ гар чийдэн - нэг;
- 14/ сэлүүр, эсхүл сэлүүрдэх бээлий - хоёр;
- 15/ завин дээрх хоёр хүн тутамд 1,2 л ус, эсхүл далайн усыг давсгүйжүүлэх хэрэгсэл - нэг;
- 16/ хөнгөн гэмтлийг эмчлэх эмнэлгийн анхны тусламжийн хэрэгсэл - нэг;
- 17/ нислэг үйлдэж буй газар нутгийн тухай ном, лавлах материал - нэг.

(г) Авран хамгаалах байршил заагч гэрэл нь АНУ-ын TSO C85-д заасан шаардлагыг хангасан байна.

#### **A15. Ослын байршил дамжуулагч /ELT/**

(а) Ослын байршил дамжуулагч /ELT/ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ 121.5 мгц давтамж дээр дамжуулах АНУ-ын TSO C91;
- 2/ 406 мгц давтамж дээр дамжуулах АНУ-ын TSO C126.

(б) Ослын байршил дамжуулагч /ELT/-ийг:

- 1/ дараах байдлаар агаарын хөлөгт суурилуулсан байна:
  - 1.1 аваар, ослын үед гэмтэх буюу эвдрэх эрсдлийг багасгасан;
  - 1.2 агаарын хөлгийн их биеийн бүтцийн хүчин чадлыг бууруулах эрсдлийг багасгасан;
  - 1.3 бэхэлсэн хэсгийн 0,3-аас 1,0 метрийн хоорондох зайд 450 ньютон хүчний үйлчлэл үзүүлэхэд бэхлэгдсэн хэсэгтэй харьцуулсан статик хазайлт нь 2,5 мм-ээс ихгүй байна.
  - 1.4 ELT нь агаарын хөлгийн 3 тэнхлэгийн дагуу нэмэх болон хасах чиглэлд 100 g ачааллыг даах чадвартай байна;
  - 1.5 агаарын хөлгөөс салдаггүй ба салдаг автомат дамжуулагч /ELT/ нь аль болох арын хэсэгт байрлана.
- 2/ ослын үед залгагч мэдрэгч нь:
  - 2.1 болгоомжгүй үйл ажиллагаанаас сэргийлэх байрлалд;

2.2 агаарын хөлгийн уртааш тэнхлэгийн дагуу, ослын анхны доргилт чичиргээг мэдрэхээр байрласан байна.

3/ антенн нь:

3.1 агаарын хөлгийн хэвийн нислэгийн үед босоо байрлалд байх ;

3.2 гаднах антенн нь үйлдвэрлэгчээс онцолж заагаагүй бол, бусад VHF-ийн гадна антеннаас 0.6 метрээс багагүй зайтай байх;

3.3 дотор антенн нь 0.3 м<sup>2</sup>-аас дээш талбай бүхий цонхонд ил байх бөгөөд металл хэрэгслээс тусгаарлагдсан байх.

4/ ELT-ын дамжуулагч антенны кабелин төгсгөл бүрт чичиргээнээс хамгаалах холбоог суурилуулсан байна;

5/ ELT бүр нь хүрэхэд ойр байрлалд, таних тэмдэгтэй байна.

(в) ELT нь:

1/ ачаалал даах чадвартай;

2/ усанд нэвтэрдэггүй;

3/ зөөврийнх байна.

(г) Энэ дүрэм хүчин төгөлдөр болохоос өмнө суурилуулсан ELT нь:

1/ АНУ-ын TSO C91 буюу TSO C91a-д заасан шаардлагыг хангасан байна;

2/ ELT нь ажиллагаагүй болох үед, АНУ-ын TSO C91a-д заасан шаардлагыг хангасан ELT-аар солино.

### **A16. Хүчилтөрөгч**

Агаарын хөлөгт ашиглах хүчилтөрөгч нь Нисэхэд ашиглах стандарт хүчилтөрөгч буюу 99%-ийн цэвэр, чийгшил нь нэг м<sup>3</sup>-д 0.0056 граммаас ихгүй, нүүрстөрөгчийн дан исэлгүй байна.

### **A17. Зорчигчийн хүчилтөрөгчийн баг**

Зорчигчийн хүчилтөрөгчийн баг нь АНУ-ын TSO C64-т заасан шаардлагыг хангасан байна.

### **A18. Нисэх багийн гишүүдийн хүчилтөрөгчийн баг**

(а) Нисэх багийн гишүүдийн хүчилтөрөгчийн баг нь АНУ-ын TSO C78-д заасан шаардлагыг хангасан байна.

(б) Нисэх багийн гишүүдийн хүчилтөрөгчийн баг нь:

1/ нэг гараараа авч өмсөх боломжтой;

2/ зохих ёсоор бэхлэгдсэн байх бөгөөд 5 секундын дотор хүчилтөрөгчөөр хангах хүчин чадалтай;

3/ дараах нөхцлийг хангасан:

3.1 нүдний шилний гадуур өмсөхөд харагдах нөхцөлийг муутгахгүй ;

3.2 нисэх багийн гишүүд ажлын байрнаас дотоод холбоогоор ярилцах боломжтой;



3.3 нисэх багийн хоёр гишүүний ажлын байр болон зорчигчийн тасалгаа бүрд байгаа багийн нэг гишүүний хооронд холбоо барих.

#### **A19. Нөөц**

#### **A20. Амьсгал хамгаалах төхөөрөмж /PBE/**

Амьсгал хамгаалах хэрэгсэл нь:

- 1/ АНУ-ын TSO C99-д заасан шаардлагыг хангасан байна;
- 2/ хэрэглэгчдийг дор дурдсан нөлөөллөөс хамгаална:
  - 2.1 утаа;
  - 2.2 нүүрстөрөгчийн давхар исэл;
  - 2.3 хортой бусад хий;
  - 2.4 нисэх онгоцны битүүмжлэл алдагдсанаас бусад нөхцлийн улмаас бий болсон хүчилтөрөгчийн дутагдалтай орчин.

#### **A21. Багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж**

(а) Энэ зүйлийн (б)-д зааснаас бусад тохиолдолд, багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж нь АНУ-ын TSO C116-д заасан шаардлагыг хангасан байна.

(б) Багийн гишүүдийн амьсгал хамгаалах зөөврийн төхөөрөмж нь багийн гишүүдийн үүрэгт ажилд үл нөлөөлөх амьсгал хамгаалах хэрэгсэлтэй холбогдсон хүчилтөрөгчийн зөөврийн хэрэгслээс бүрдэж болно.

#### **A22. Автомат хариулагч төхөөрөмж**

Автомат хариулагч нь:

- 1/ АНУ-ын TSO C74с-д заасан шаардлагыг хангасан байна;
- 2/ S горимд ажиллах төхөөрөмж нь АНУ-ын TSO C112-ын зохих ангиллын шаардлагыг хангасан байна.

#### **A23. Өндрийн мэдээллийг кодлох тоноглол**

Өндрийн мэдээллийг кодлох хэрэгсэл нь АНУ-ын TSO C88-д заасан шаардлагыг хангасан байна.

#### **A24. Өндрийн дохиоллын систем**

Газрын гадаргуугаас дээш 1000 м (3000 фут)-ээс доош үйлдэх нислэгт өндрийн дохиоллын систем буюу төхөөрөмж нь харагдах, эсхүл сонсогдох дохио өгнө.

#### **A25. Аваарын үед хэрэглэх шүхэр**

Аваарын үед хэрэглэх шүхэр нь:

- 1/ маягийн гэрчилгээнд заасан шаардлагыг хангасан байна;
- 2/ АНУ-ын TSO C23 стандартад нийцсэн байна.

#### **A26. Планер чирэх холбоос**

(а) энэ зүйлийн 2/-т зааснаас бусад тохиолдолд, планер чирэх холбоосны бат бэх чанарын /тасрах/ хязгаар нь чирэгдэж буй планерын хөөрөлтийн хамгийн их жингийн 80%-иас багагүй, эсхүл 200%-иас ихгүй байна.

(б) хэрэв холбоосны бат бэх чанарын хязгаар нь чирэгдэж буй планерын нислэгийн хөөрөлтийн хамгийн их жингийн 200 %-иас их байх тохиолдолд бэхлэлтийн цэгүүд дээр дараах шаардлагыг хангасан хамгаалах гогцоо суурилуулна:

- 1/ чирэгдэж буй планерын бэхлэлтийн цэг дээрх гогцооны хувьд, бат бэх чанарын хязгаар нь тухайн планерын хөөрөлтийн хамгийн их жингийн 80%-иас багагүй, гэхдээ планерын хөөрөлтийн хамгийн их жингээс 2 дахин их байж болохгүй;
- 2/ чирж байгаа агаарын хөлгийн бэхлэлтийн цэг дээрх гогцооны хувьд, бат бэх чанарын хязгаар нь планерын хөөрөлтийн хамгийн их жингийн 100%-иас доошгүй, гэхдээ планерын хөөрөлтийн хамгийн их жингээс 2 дахин их байж болохгүй.

---oOo---